



Г.АМАРЖАРГАЛ /хуульч, судлаач/



ХҮН ХУДАЛДААЛАХ ГЭМТ ХЭРГИЙН ХОХИРОГЧИЙГ ИЛРҮҮЛЭХ

Анхан шатны нэгжид ажиллаж буй мэргэжилтнүүдэд
зориулсан гарын авлага



“Мөнхийн Үсэг” ХХК-д хэвлэв.
Утас: 70140459
Вэб хаяг: www.munkhiin-useg.mn

Улаанбаатар хот
2022 он



ХҮН ХУДАЛДААЛАХ ГЭМТ ХЭРГИЙН ХОХИРОГЧИЙГ ТАНИХ, ИЛРҮҮЛЭХ

Анхан шатны нэгжид ажиллаж буй
мэргэжилтнүүдэд зориулсан
гарын авлага

ХҮН ХУДАЛДААЛАХ ГЭМТ ХЭРГИЙН
ХОХИРОГЧИЙГ ТАНИХ, ИЛРҮҮЛЭХ

Анхан шатны нэгжид ажиллаж буй мэргэжилтнүүдэд
зориулсан гарын авлага

“Мөнхийн Үсэг” ХХК-д хэвлэв.

ӨМНӨХ ҮГ..... 5

**ХҮН ХУДАЛДААЛАХ ГЭМТ ХЭРГИЙН ХОХИРОГЧИЙГ ТАНИХ,
ИЛРҮҮЛЭХ ЗААВАР..... 7**

**НЭГ. МОНГОЛ УЛСЫН НЭГДСЭН ОРСОН ОЛОН УЛСЫН
ХЭМ ХЭМЖЭЭ 15**

- 1.1. Үндэстэн дамнасан зохион байгуулалттай гэмт хэргийн эсрэг НҮБ-ын конвенц, түүний нэмэлт Хүн, ялангуяа эмэгтэйчүүд, хүүхэд худалдаалахаас урьдчилан сэргийлэх, таслан зогсоох, шийтгэх тухай протоколоос 15
- 1.2. Албадан хөдөлмөрийн тухай 29 дүгээр конвенцоос..... 17
- 1.3. Албадан хөдөлмөрийг устгах тухай 105 дугаар конвенцоос..... 18
- 1.4. Боолчлол, боолын худалдааг хориглох тухай конвенцоос ...18
- 1.5. Боолчлол, боолын худалдаа болон боолчлолтой адилтгах ёс заншлыг устгах тухай нэмэлт конвенцоос..... 19
- 1.6. Хүүхдийн эрхийн конвенцоос 20
- 1.7. Хүүхдийн эрхийн конвенцын нэмэлт Хүүхдийг худалдах, хүүхдийн биеийг үнэлэх, хүүхдийг садар самуунд сурталчлахын эсрэг протоколоос..... 21
- 1.8. Хүүхдийн хөдөлмөрийн тэвчишгүй хэлбэрийн тухай олон улсын хөдөлмөрийн байгууллагын 182 дугаар конвенцоос 23
- 1.9. Хүүхдийг хамгаалах болон улс хооронд үрчлэх асуудлаар хамтран ажиллах тухай конвенцоос..... 23
- 1.10. Эмэгтэйчүүдийг алагчлах бүх хэлбэрийг устгах конвенцоос 24

ХОЁР. ХҮН ХУДАЛДААЛАХ ГЭМТ ХЭРГИЙН ОЙЛГОЛТ 25

- 2.2. Хүн худалдаалах гэмт хэргийн үндсэн шинж 26
- 2.3. Хүн худалдаалах гэмт хэргийн хүндрүүлэх шинж 29
- 2.4. Хүн худалдаалах гэмт хэргийн төрөл 30
- 2.5. Хүн худалдаалах гэмт хэргийн хохирогчийн тухай 38

2.6. Хүн худалдаалах гэмт хэрэг ба хохирогчийн хамаарал ...	39
2.7. ХХГХ-ийн хохирогч гэмт хэрэгт хүчээр оролцох тохиолдлууд:	40

**ГУРАВ. ХҮН ХУДАЛДААЛАХ ГЭМТ ХЭРГИЙН ХОХИРОГЧИЙГ
ИЛРҮҮЛЭХ НЬ** 42

3.1. Цагдаагийн албан хаагч хүн худалдаалах гэмт хэргийн хохирогчийг илрүүлэх, таних.....	43
3.2. Хилийн шалган нэвтрүүлэх албаны албан хаагч хүн худалдаалах гэмт хэргийн хохирогчийг илрүүлэх, таних.....	56
3.3. Эрүүл мэндийн байгууллагын албан хаагч хүн худалдаалах гэмт хэргийн хохирогчийг илрүүлэх, таних.....	65
3.4. Нийгмийн ажилтан болон хүүхдийн байгууллагын ажилтан албан хаагч хүн худалдаалах гэмт хэргийн хохирогчийг илрүүлэх, таних	71

**ДӨРӨВ. ХҮН ХУДАЛДААЛАХ ГЭМТ ХЭРГИЙН
ХОХИРОГЧИД ИЛЭРЧ БОЛОХ ШИНЖ ТЭМДЭГ.....**77

Хавсралт №1. Цагдаагийн албан хаагчийн хүн худалдаалах гэмт хэргийн хохирогчийг илрүүлэх асуулга.....	82
Хавсралт №2. Хилийн шалган нэвтрүүлэх албаны албан хаагчийн хүн худалдаалах гэмт хэргийн хохирогчийг илрүүлэх асуулга	85
Хавсралт №3. Эрүүл мэндийн байгууллагын мэргэжилтний хүн худалдаалах гэмт хэргийн хохирогчийг илрүүлэх асуулга	88
Хавсралт №4. Нийгмийн ажилтан болон хүүхдийн асуудал эрхэлсэн мэргэжилтний хүн худалдаалах гэмт хэргийн хохирогчийг илрүүлэх асуулга.....	90
Хавсралт №5. Эрсдэл бүхий гадаадын иргэнээс авах асуулга.....	94
Хавсралт №6. Хүн худалдаалах гэмт хэргийн хохирогчид шаардлагатай дэмжлэг, туслалцаа үзүүлэх, холбон зуучлах зурагл ал.....	96

ӨМНӨХ ҮГ

Хүн худалдаалах гэмт хэрэг нь үндэстэн дамнасан зохион байгуулалттай гэмт хэрэг бөгөөд сүүлийн жилүүдэд уг гэмт хэргийг хар тамхи, мансууруулах бодис худалдах, тээвэрлэх зэрэг гэмт хэрэгтэй хавсран үйлдэж ихээхэн хэмжээний ашиг орлого олдог хууль бус бизнес болон өргөжиж байгаа нь дэлхий нийтийн анхаарлыг татсан асуудал болоод байна.

Хүн худалдаалах гэмт хэргийн хохирогчид нь ихэвчлэн буурай хөгжилтэй болон хөгжиж байгаа орнуудын хүүхэд, эмэгтэйчүүд байдаг бөгөөд тухайн орны эдийн засгийн хөгжил доогуур, иргэдийн эрх зүйн мэдлэг, ойлголт хангалтгүй байгаа зэрэг нь энэхүү гэмт хэргийн хохирогч болох гол хүчин зүйл болж байна. НҮБ-ын Мансууруулах бодис, гэмт хэргийн асуудал эрхэлсэн албанаас гаргасан тайланд дурдсанаар хүн худалдаалах гэмт хэргийн улмаас 137 орны 2,4 сая иргэн (хохирогч) хохирсон байдаг бөгөөд хохирогчдын 75 хувийг охид, эмэгтэйчүүд эзэлж байна.

Манай улсад 2018-2021 онд Хүн худалдаалах гэмт хэргийн 131 хохирогчтой 38 хэргийг илрүүлэн шалгахад худалдаалагдсан 3 хохирогч тутмын 1 нь насанд хүрээгүй хүн байсныг ЦЕГ-аас мэдээлсэн. Сэтгэл эмзэглүүлэх эдгээр тоо мэдээний ард хүүхэд, эмэгтэйчүүд ихэнхдээ хохирч, олон эрхүүд нь зөрчигдөн, жам ёсны эрхэнд нь заналхийлж байдаг ноцтой гэмт хэрэг юм. Тиймээс дэлхий нийтээрээ үндэстэн дамнасан зохион байгуулалттай хэргийн нэг болох хүн худалдаалах гэмт хэрэгтэй тэмцэхэд ихээхэн ач холбогдол өгч байна.

Хүн худалдаалах гэмт хэргийн хохирогчийг таньж, илрүүлж чадахгүй байх нь дарамт мөлжлөгт өртсөн хохирогчийн аюулгүй байдлыг хамгаалж, шаардлагатай тусламж үйлчилгээнд хамруулах, эрхийг нь хамгаалж чадахгүйд хүрдэг. Хохирогчийг таньж илрүүлснээр гэмт хэргийг таслан зогсоох, гэмт хэрэгтнийг илрүүлэх, ял шийтгэл оногдуулах, хохирогчид шаардлагатай туслалцаа үйлчилгээг хүргэх, урьдчилан сэргийлэхэд чухал үр дүнтэй байдаг.

2019-2023 онд Хөдөлмөр нийгмийн хамгааллын яам, БНСУ-ын Гэр бүл, жендерийн тэгш эрхийн яамтай хамтран хэрэгжүүлж буй “Эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийллээс урьдчилан сэргийлэх, бэлгийн мөлжлөгийн хохирогчдод туслалцаа үзүүлэх” төслийн

хүрээнд БНСУ-ын туршлага дээр үндэслэн энэхүү гарын авлагыг салбар бүрийн мэргэжилтнүүдийн олон удаагийн хэлэлцүүлэг, зөвлөмжийн тусламжтайгаар боловсруулан гаргаж, та бүхний хүртээл болгоход бэлэн боллоо. Энэхүү гарын авлагыг боловсруулахад оюун ухаан цаг заваа зарцуулан ажилласан судлаач Г.Амаржаргал, мэргэжил арга зүйн дэмжлэг үзүүлэн ажилласан Хүйсийн тэгш эрхийн төвийн хамт олон, техникийн болон санхүүгийн дэмжлэг үзүүлсэн БНСУ-ын Гэр бүл жендэрийн тэгш эрхийн яаманд талархлаа илэрхийлье.

Хүн худалдаалах гэмт хэргийн хохирогчийг таньж тогтоох нь амаргүй тул энэхүү гарын авлагаар хохирогчийг тогтооход нэмэр болохуйц жишиг үзүүлэлт, асуулт, түүнчлэн мөлжлөгийн олон хэлбэрийн талаар тусгаж, хууль эрх зүйн орчинтой уялдуулан тайлбарлаж өгсөн тул та бүхний ширээний ном болно гэдэгт итгэлтэй байна. Мөн хүн худалдаалах гэмт хэрэгтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх чиглэлээр ажиллаж буй байгууллага, мэргэжилтнүүдэд лавлах болгон ашиглагдахуйц үнэ цэнтэй эх сурвалжуудын нэг болсон.

Энэхүү гарын авлагыг хэрэглээ болгохоор “Хүн худалдаалах гэмт хэргийн хохирогчийг таних, илрүүлэх, шаардлагатай дэмжлэг туслалцаанд холбон зуучлах зааварчилгаа”-г холбогдох байгууллагуудын мэргэжилтнүүдэд зориулан Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын тушаалаар баталж, хэрэгжилтийг хангахаар ажиллаж байна.


Хүн худалдаалахтай тэмцэх тухай хуулиар үүрэг хүлээсэн салбар, байгууллагууд чиг үүргийн хүрээнд гарын авлагад үндэслэн дотоодод мөрдөж ашиглах заавар, журмыг боловсруулан ажиллахыг уриалж байна.

Та бүхнийг хүндэтгэсэн:

Н.БАЯРМАА
Хөдөлмөр Нийгмийн Хамгааллын Яамны
Гэр бүлийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах
газрын дарга

ХҮН ХУДАЛДААЛАХ ГЭМТ ХЭРГИЙН ХОХИРОГЧИЙГ ТАНИХ ИЛРҮҮЛЭХ ЗААВАР

Нийгмийн ажилтнуудад зориулав.



**МОНГОЛ УЛСЫН
ХӨДӨЛМӨР, НИЙГМИЙН ХАМГААЛЛЫН
САЙДЫН ТУШААЛ**

2022 оны 04 сарын 05 өдөр Дугаар 1157 Улаанбаатар хот

Заавар батлах тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг, Хөдөлмөрийн тухай хуулийн 7, 8 дугаар зүйл, Хүн худалдаалахтай тэмцэх тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.4 дэх хэсэг, Хүүхэд хамгааллын тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.1.2 дахь заагийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Хүн худалдаалах гэмт хэргийн хохирогчийг таних, илрүүлэх зааврыг нэгдүгээр, Хүн худалдаалах гэмт хэргийн хохирогчийг илрүүлэх асуулгыг хоёрдугаар, Хүн худалдаалах гэмт хэргийн хохирогчийг шаардлагатай дэмжлэг туслалцаа үзүүлэх, холбон зуучлах үйлчилгээ үзүүлэх зураглалыг гуравдугаар хавсралтаар тус тус баталсугай.
2. Энэхүү зааврыг хэрэгжүүлж, үр дүнд хяналт тавьж ажиллахыг Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны Гэр бүлийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газар /Н.Баярмаа/, Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газар /Г.Батдорж/-т тус тус даалгасугай.

САЙД  **А.АРИУНЗАЯА**

151201460

Хөдөлмөр, нийгмийн хамгааллын
сайдын 2022 оны 12 сарын 2 өдрийн 14/2
дугаар тушаалын нээдүгээр хэсрэлт

ХҮН ХУДАЛДААЛАХ ГЭМТ ХЭРГИЙН ХОХИРОГЧИЙГ ТАНИХ, ИЛРҮҮЛЭХ ЗААВАР



Үндэслэл:

Монгол Улс нь НҮБ-ын Ерөнхий Ассамблейгаас батлан гаргасан Үндэстэн дамнасан зохион байгуулалттай гэмт хэргийн эсрэг Конвенцын нэмэлт болох Хүн, ялангуяа эмэгтэйчүүд, хүүхэд худалдаалахаас урьдчилан сэргийлэх, таслан зогсоох, шийтгэх тухай протоколд 2008 онд нэгдсэн орсон.

Монгол Улс Хүн худалдаалахтай тэмцэх тухай хуулийг 2012 онд батлан, 2015 онд шинэчлэн найруулсан Эрүүгийн хуулийн 13.1 дүгээр зүйлд хүн худалдаалах гэмт хэргийг хуульчлан, 12.3 дугаар зүйлд бэлгийн мөлжлөг, 12.6 дугаар зүйлд биеэ үнэлэхийг зохион байгуулах, 13.13 дугаар зүйлд албадан хөдөлмөрлүүлэх, 16.6 дугаар зүйлд буюу хүүхэд худалдах, 16.8 дугаар зүйлд хүүхэд садар самууныг сурталчлах, уруу татах, 16.9 дүгээр зүйлд хүүхэд оролцуулж садар самууныг сурталчлах, 16.10 дугаар зүйлд хүүхдээр тэвчишгүй хөдөлмөр эрхлүүлэх гэмт хэргийг тус тус хуульчилсан байдаг.

Цагдаагийн байгууллагын гэмт хэргийн статистик мэдээллээр 2021 онд хүн худалдаалах гэмт хэрэг 8, бэлгийн мөлжлөгийн гэмт хэрэг 3, биеэ үнэлэхийг зохион байгуулах гэмт хэрэг 9, албадан хөдөлмөрлүүлэх гэмт хэрэг 1, хүүхэд худалдах гэмт хэрэг 1, хүүхэд садар самууныг сурталчлах, уруу татах гэмт хэрэг 19, хүүхэд оролцуулж садар самууныг сурталчлах гэмт хэрэг 2, хүүхдээр тэвчишгүй хөдөлмөр эрхлүүлэх гэмт хэрэг 1 бүртгэгдсэн. Шүүхийн статистик мэдээллээр бэлгийн мөлжлөгийн зорилгоор хүн худалдаалах хэрэг 3, бэлгийн мөлжлөгийн 1 гэмт хэргийг тус тус шийдвэрлэгдсэн байна. Харин хүний цус, эс, эд, эрхтнийг хууль бусаар авах, хүүхдээр гуйлга гуйлгах гэмт хэрэг бүртгэгдээгүй байна.

БНСУ-ын Засгийн газрын дэмжлэгтэйгээр "Монгол Улс дах эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийллээс урьдчилан сэргийлэх, бэлгийн мөлжлөгийн хохирогчид туслалцаа үзүүлэх" төслийг 2019 оноос хэрэгжүүлж, төслийн хүрээнд хүн худалдаалах гэмт хэргийн хохирогчийг таних, илрүүлэх арга зүйн зөвлөмжийг агуулсан гарын авлагыг боловсруулаад байна.

Иймд тус гарын авлагыг албан хэрэгцээндээ ашиглах мэргэжлийн бүлгүүд ялангуяа нийгмийн хамгааллын салбарын мэргэжилтнүүдийг удирдлага, арга зүйгээр хангах шаардлагатай.

Зорилго: Хүн худалдаалахтай тэмцэх тухай хуулийн хэрэгжилтийг эрчимжүүлэх, хүн худалдаалах гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, энэ төрлийн гэмт хэргийн хохирогчийг таних, илрүүлэх, холбон зуучлах үйлчилгээнд хамруулахад арга зүйн заавар өгөхөд чиглэнэ.

Зарчим:

1. Хохирогч төвтэй, хүний эрхэд суурилсан хандлагаар хохирогчийг таних, илрүүлэх;
2. Үйлчлүүлэгч бүрийн онцлог, хэрэгцээ шаардлагад нийцсэн байх;
3. Хохирогчийн хувийн нууцлалыг хамгаалах, сахиу.

Хамрах хүрээ:

Төрийн захиргаа, төрийн үйлчилгээний албанд гүйцэтгэх, туслах албан тушаалд ажиллаж буй албан хаагч, үйлчилгээ үзүүлэгч төрийн бус байгууллагын мэргэжилтнүүд.

Зааврыг хэрэглэх:

Энэхүү зааврыг хүн худалдаалах гэмт хэргийн хохирогчийг таних, илрүүлэх, хамгаалах, тэдэнд үйлчилгээ үзүүлэх, холбон зуучлах үйлчилгээг анхан шатанд үзүүлж буй үйлчилгээ үзүүлэгч төрийн ба төрийн бус байгууллагын ажилтнууд албан хэрэгцээндээ ашиглана.

Нэг. Хүн худалдаалах гэмт хэргийн хохирогчийг таних, илрүүлэх

1.1. Хүн худалдаалах гэмт хэрэгт өртсөн байх магадлалтай хохирогч нь баг, хорооны нийгмийн ажилтан, хүүхдийн асуудал хариуцсан мэргэжилтэнд хандсан бол хохирогчийг илрүүлэх асуулгыг ашиглан тогтооно.

1.2. Нийгмийн ажилтан, хүүхдийн асуудал эрхэлсэн мэргэжилтэн нь хүн худалдаалах гэмт хэргийн хохирогч байх магадлал илэрсэн тохиолдол бүрт Цагдаагийн байгууллага, Тагнуулын байгууллагад заавал мэдээлнэ.

1.3. Хүн худалдаалах гэмт хэргийн хохирогчийг таньж мэдэх, илрүүлэхдээ Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам, Хүйсийн тэгш эрх төвийн хамтран гаргасан анхан шатны нэгжид ажиллаж буй мэргэжилтнүүдэд зориулсан Хүн худалдаалах гэмт хэргийн хохирогчийг илрүүлэх гарын авлагыг хэрэглэнэ.

1.4. Нийгмийн ажилтан, хүүхдийн асуудал эрхэлсэн мэргэжилтэн нь Хүн худалдаалах гэмт хэргийн хохирогчийг илрүүлэх гарын авлагыг ашиглан Хүн худалдаалахтай тэмцэх тухай хуулийн 12.3.1-т заасан ажлын байраар хангах, мэргэжлийн сургалтад хамруулах үйлчилгээ үзүүлэх журмын хэрэгжилтийг хангах, энэ төрлийн гэмт хэргийн хохирогчид шаардлагатай дэмжлэг тусалцаа, холбон зуучлах үйлчилгээ үзүүлнэ.

Хоёр. Үйлчилгээ үзүүлэгч байгууллагад хүн худалдаалах гэмт хэргийн хохирогчийг холбон зуучлах

2.1. Хүн худалдаалах гэмт хэргийн хохирогчийг илрүүлсэн тохиолдолд мэргэжлийн, дагнасан үйлчилгээ үзүүлэгч төрийн бус байгууллагад хандуулна.

2.2. Үйлчилгээ үзүүлэгч төрийн бус байгууллага нь хүн худалдаалах гэмт хэргийн хохирогчдод анхан шатны болон нөхөн сэргээх үйлчилгээнд хамруулахдаа Хүн худалдаалах гэмт хэргийн хохирогчид үзүүлэх нийгмийн үйлчилгээнд тавих нийтлэг шаардлага MNS6418:2013 стандартыг баримтлан ажиллана.

2.3. Холбон зуучлах үйлчилгээгээр хүлээн авсан хүн худалдаалах гэмт хэргийн хохирогчдод үзүүлж буй үйлчилгээний гухай мэдээллийг тогтмол солилцох, эргэх холбоотой ажиллана.

Хөдөлмөр, нийгмийн хамгааллын
сайдын 2022 оны 07 сарын 05 өдрийн 14
дугаар тушаалын хоёрдугаар
хавсралт



**НИЙГМИЙН АЖИЛТАН БОЛОН ХҮҮХДИЙН АСУУДАЛ ХАРИУЦСАН
АЛБАН ХААГЧИЙН ХҮН ХУДАЛДААЛАХ ГЭМТ ХЭРГИЙН
ХОХИРОГЧИЙГ ИЛРҮҮЛЭХ АСУУЛГА**

Нийгмийн ажилтан, хүүхдийн асуудал хариуцсан албан хаагч нь хүн худалдаалах гэмт хэргийн эрсдэл бүхий иргэн, насанд хүрээгүй хүнийг /хүүхэд/-ийг /цаашид хүн гэнэ/ илрүүлэхдээ гарын авлагын шалгах хуудсыг бөглөнө.

Асуулга:

№	Асуулт	Тийм	Үгүй	Дэлгэрэнгүй мэдээлэл тэмдэглэх
Суурь үзүүлэлт:				
1.	Нас:			
2.	Хүйс:			
3.	Суралцаж буй байдал:			
4.	Амьдралын нөхцөл байдал			
Үндсэн үзүүлэлт. Зөвлөмж:				
<ul style="list-style-type: none"> Нийгмийн ажилтан болон хүүхдийн асуудал эрхэлсэн мэргэжилтэн нь дор тавигдсан асуултаас гадна тухайн хүний яриа, бусад нөхцөл байдал, өөрийн мэдрэмжээр асуултуудыг нарийвчлан тодруулах замаар хохирогч мөн эсэхийг тогтоохыг зорино. <ul style="list-style-type: none"> Хүн худалдаалах гэмт хэрэг, бэлгийн мөлжлөгийн хохирогчтой өнгөрсөн үйл явдлын талаар олон удаагийн давтамжтай ярих нь сэтгэл зүйн дарамтанд орох эрсдлийг бий болгож байдаг тул анхаарч ажиллана. Ярилцлагын явцад хүн худалдаалах хэргийн хохирогчтой хүн худалдаалах гэмт хэрэг, бэлгийн мөлжлөгт өртөгч, биеэ үнэлэгч гэх мэт үгсийг аль болох ашиглахаас татгалзана. Хохирогч төвтэй хандлагатай, хүний эрхийн мэдрэмжтэй, ярилцлагын асуултуудыг аль болох ойлгомжтой байдлаар тайлбарлан, тодорхой хариулт авахыг зорьж ажиллана. Ярилцагчийн асуултад хариулж буй байдал логик холбоотой байгаа эсэхэд анхаарлаа хандуулж, эргэлзээтэй санагдсан хариултыг 4-5 асуулт, хариулт явуулсны дараа дахин тодруулан асууж нягтална. 10 буюу түүнээс дээш асуултанд "Тийм" гэсэн хариултыг өгч байвал хүн худалдаалах гэмт хэргийн хохирогч болсон байх магадлалтай гэж үзнэ. Ярилцлагын явцад илэрсэн хохирогч болсон эсхүл хохирогч байх магадлалтай өөр хүмүүсийн талаярх мэдээллийг тодорхой тэмдэглэж, яаралтай цагдаа, тагнуулын байгууллагад мэдээлнэ. Нийгмийн ажилтан болон хүүхдийн асуудал эрхэлсэн мэргэжилтэн нь тухайн хүүхдийг бэлгийн мөлжлөг, хүн худалдаалах гэмт хэргийн хохирогч болсон байх магадлалтай гэх үндэслэл байвал нутаг дэвсгэрийн цагдаагийн байгууллага эсхүл тагнуулын байгууллагын эрх бүхий албан тушаалтанд хандаж, шуурхай арга хэмжээг авна. 				
1.	Гэр бүлээсээ тусдаа амьдарч байна уу?			
2.	Хүссэн үедээ эцэг, эхтэйгээ уулзах боломжгүй байна уу?			

3.	Хүүхэд сургуульд явахаа больсон уу?			
4.	Зан авирт огцом өөрчлөлт гарсан шинж ажиглагдсан уу?			
5.	Бэлгийн мөлжлөгт өртсөн байх магадлалтай талаар мэдээлэл авсан уу?			
6.	Тухайн хүн өөрөө бэлгийн мөлжлөгт өртсөн талаар мэдээлэл өгсөн үү?			
7.	Хөдөлмөрийн мөлжлөгт өртсөн байх магадлалтай талаар мэдээлэл авсан уу?			
8.	Тухайн хүн өөрөө хөдөлмөр мөлжлөгт өртсөн талаар мэдээлэл өгсөн үү?			
9.	Хэт урт цагаар, амралтгүйгээр ажилладаг уу?			
10.	Яриа нь эмх цэгцгүй, эргэлзсэн эсвэл сэтгэл санааны дарамт, хүчирхийлэл, сэтгэцийн хувьд хэвийн биш байгаа байдал харагдаж байна уу?			
11.	Бие махбодын хүчирхийллийн шинж тэмдэг илэрч байна уу?			
12.	Ажлын байран дээр хоног төөрүүлдэг, ажлын байрандаа амьдардаг эсэх?			
13.	Хүүхэд аймхай, цочимхой, хүлцэнгүй, бусдаас хараат шинж байна уу?			
14.	Хоол хүнс, амралт, нойр, эмнэлгийн тусламж дутагдсан шинж тэмдэг илэрч байна уу?			
15.	Ихэвчлэн өөрийг нь хянадаг эсвэл нөхцөл байдлыг байнга хянаж байгаагаа илэрхийлдэг хэн нэгэнтэй хамт байдаг уу? (хаашаа явах, хэнтэй уулзах, ярилцах, асуултад юу гэж хариулах талаар байнга заадаг, хянаж шалгадаг гм)			
16.	Тухайн хүнд юу хэлэхийг зааж сургасан шинж ажиглагдаж байна уу?			
17.	Хэвийн амьдрахад тохиромжгүй нөхцөлд амьдарч байна уу?			
18.	Өмнө нь гэмт хэрэг, ялангуяа бэлгийн эрх чөлөөний эсрэг гэмт хэргийн хохирогч болж байсан уу?			
19.	Тухайн амьдарч буй газраа чөлөөтэй орхиж чадах уу?			
20.	Улирлын чанартай хувцас дутагдсан, эсвэл насандаа			


	тохирохгүй илт бэлгийн болон хөдөлмөр мөлжлөгт өртөж буйг илтгэх хувцас, хэрэгсэлтэй байна уу?			
21.	Хийсэн ажлынхаа хөлсийг тохиролцсон хэмжээндээ авч чадсан эсэх?			
22.	Хөдөлмөр эрхэлсэн хөлсийг хэн нэгэн шууд болон шууд бусаар авдаг байсан уу? (эцэг эх, гэр бүл, хамаатан садан, ажил олгогч гм)			
23.	Аюулгүй байдлыг нь хангах яаралтай үндэслэл байна уу?			
24.	Амь нас, эрүүл мэндэд нь ноцтой хохирол учруулж болзошгүй бусад хүчин зүйл байгаа юу?			
25.	Ямар нэгэн хүчирхийллийн улмаас гэрээсээ зугатааж, оргож байсан уу?			
26.	Цагдаагийн байгууллагаар эрэн сурвалжлагдаж байсан уу? (хэдэн удаа)			
27.	Амиа хорлох, биеэ гэмтээх оролдлого хийж байсан уу?			
28.	Цагдаагийн байгууллагад зөрчлийн улмаас саатуулагдаж байсан уу?			
Тэмдэглэл:				

Асуулга: Эрсдэл бүхий гадаадын иргэнээс авах асуулга

№	Асуулт	Тийм	Үгүй	Дэлгэрэнгүй мэдээлэл тэмдэглэх
Суурь үзүүлэлт:				
1.	Нас:			
2.	Иргэншил:			
3.	Ажил эрхлэлт			
4.	Цалин хөлстэй эсэх			
5.	Та Монгол хэл мэдэх үү, мэддэг бол ямар түвшинд мэддэг вэ?			
6.	Монголд хэзээ, хэрхэн, хэнтэй, яаж ирсэн бэ?			
7.	Таниас зөвшөөрөл авалгүйгээр визний хугацааг сунгах, ажлын байр өөрчлөх тохиолдол гарч байсан уу?			
8.	Яагаад Монгол Улсад ирж, ажиллах болсон бэ?			


	Таныг энд ирүүлэхийн тулд хэн нэгэн ятгах, дарамтлах зэргээр нөлөөлсөн үү?		
9.	Таны Монгол Улсад ирэх зардлыг хэн хариуцсан бэ?		
10.	Та одоо Монгол Улсад ямар нөхцөлд ажиллаж амьдарч байна вэ?		
11.	Та өдөрт, долоо хоногт хэдэн цаг ажилладаг вэ?		
12.	Та одоо эрхэлж байгаа ажлаа хийж эхлэхдээ хөдөлмөрийн гэрээ байгуулсан уу?		
13.	Танд мэдээлэл, харилцаа, холбооны хэрэгсэл ашиглах боломж байдаг уу?		
14.	Ажил олгогч тантай анх тохирсноосоо өөр эсвэл илүү ажил хийхийг санал болгох, шаардах тохиолдол гарч байсан уу?	тийм	үгүй
	Хэрэв тийм бол ямар ажил хийхийг санал болгосон бэ?		
15.	Таны иргэний бичиг баримтууд өөрт тань бий юу?		
16.	Та ажил олгогчдоо эсхүл таныг ажилд зуучилсан хүнд өртэй юу?		
17.	Та хийж буй хөдөлмөрийнхөө хөлсөнд хэдэн төгрөг авдаг вэ?		
	Ажил олгогч тантай анх тохирсны дагуу цалингаа бүрэн олгодог уу?		
18.	Таны олсон орлогоос хувь авдаг хүн бий юу?	тийм	үгүй
	Хэрэв тийм хүн байгаа бол хэд, хэдэн хувиар нь хуваадаг вэ?		
	Танд оногдох хувь таны амьдралд хүрэлцээтэй байдаг уу?		
19.	Таныг амьдарч байгаа орон байрнаасаа гарахыг хориглох тохиолдол гарч байсан уу?		
	Хэрэв тийм бол та тухайн үед ямар арга хэмжээ авсан бэ?		
20.	Хүссэн үедээ нутаг руугаа буцах боломж байсан үү?		
Тэмдэглэл:			

Хөдөлмөр, нийгмийн хамгааллын
сайдын 2022 оны 04 сарын 08 өдрийн А/57
дугаар тушаалын гуравдугаар
хавсралт



ХҮН ХУДАЛДААЛАХ ГЭМТ ХЭРГИЙН ХОХИРОГЧИЙГ ШААРДЛАГАТАЙ ДЭМЖЛЭГ ТУСЛАЛЦАА ҮЗҮҮЛЭХ, ХОЛБОН ЗУУЧЛАХ

Хүн худалдаалах гэмт хэргийн хохирогчид шаардлагатай дэмжлэг, туслалцаа үзүүлэх, холбон зуучлахдаа дараах үе шатыг баримтлана. Үүнд:



ХӨДӨЛМӨР, НИЙГМИЙН ХАМГААЛЛЫН ЯАМ

Хүний наймаатай тэмцэх чиглэлээр гарсан анхны олон улсын эрхзүйн баримт бичиг нь 1927 оны 3 дугаар сарын 9-ний өдөр хүчин төгөлдөр болсон “Боолчлол, боолын худалдааг хориглох тухай конвенц” юм. Тус баримт бичигт хүнийг боол болгох зорилгоор олзлох, олж авах буюу эрхэндээ оруулах, боолыг худалдах буюу солих зорилгоор түүнийг олж авах, худалдах буюу солих замаар эрхэндээ оруулах үйлдлийг “Боолын худалдаа” хэмээн тодорхойлоод конвенцын дагуу нэгдэн орсон улсууд боолчлолтой тэмцэхийг үүрэг болгож байжээ.

Олон улс хүний наймаатай тэмцэх тэмцлээ тасралтгүй явуулж энэ хирээр олон улсын гэрээ конвенцудад түүнтэй тэмцэх чиглэлийн зохицуулалтууд тусгалаа олж ирсэн бөгөөд НҮБ-ын Ерөнхий Ассамблейгаас баталсан “Үндэстэн дамнасан зохион байгуулалттай гэмт хэргийн эсрэг конвенц”, түүний нэмэлт болох “Хүн, ялангуяа эмэгтэйчүүд, хүүхэд худалдаалахаас урьдчилан сэргийлэх, таслан зогсоох, шийтгэх тухай” протокол нь хүний наймаатай тэмцэх, таслан зогсоох, урьдчилан сэргийлэх чиглэлээр өнөөдрийн байдлаар хамгийн гол баримт бичиг болон мөрдөгдөж байна.

Дараах хэсэгт холбогдох гол олон улсын гэрээ, конвенцод хүний наймаа, түүний төрөл, хэлбэрүүдтэй тэмцэх, таслан зогсоох, түүнээс урьдчилан сэргийлэх асуудлуудыг хэрхэн авч үзэж тодорхойлсныг тоймлон харууллаа:

1.1. ҮНДЭСТЭН ДАМНАСАН ЗОХИОН БАЙГУУЛАЛТТАЙ ГЭМТ ХЭРГИЙН ЭСРЭГ НҮБ-ЫН КОНВЕНЦ, ТҮҮНИЙ НЭМЭЛТ ХҮН, ЯЛАНГУЯА ЭМЭГТЭЙЧҮҮД, ХҮҮХЭД ХУДАЛДААЛАХААС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ, ТАСЛАН ЗОГСООХ, ШИЙТГЭХ ТУХАЙ ПРОТОКОЛООС

НҮБ-ын Ерөнхий Ассамблейгаас 2000 оны 11 сарын 15-ны өдөр баталсан Үндэстэн дамнасан зохион байгуулалттай гэмт хэргийн эсрэг конвенц, 2000 оны 11 дүгээр сарын 15-ны өдөр баталсан түүний нэмэлт протоколд Монгол Улс 2008 оны 05 дугаар сарын 16-ны өдөр нэгдэн орсон.

Хүний наймаа нь ямагт зохион байгуулалттай төдийгүй олон улсыг хамарсан онцлог шинжийг агуулдаг. Энэ утгаараа хүний наймаа нь үндэстэн дамнасан зохион байгуулалттай гэмт хэргийн нэг бие даасан төрөл гэж хүлээн зөвшөөрөгддөг бөгөөд энэхүү гэмт хэргээс урьдчилан сэргийлэх болон түүнтэй тэмцэх зорилгоор 2000 оны 12 сард “Үндэстэн дамнасан зохион байгуулалттай гэмт хэргийн эсрэг НҮБ-ын конвенц”-ыг бага хуралд оролцсон улсуудаас санаачлан боловсруулж байжээ. Тус баримт бичгийг Италийн Палермо хотод хэлэлцэн үзэглэсэн тул Палермогийн протокол хэмээн олон улсын түвшинд нэрлэх нь бий. НҮБ-ын энэхүү конвенц нь 41 зүйлээс бүрдсэн, үндэстэн дамнасан зохион байгуулалттай гэмт хэргийн эсрэг батлан гаргасан олон улсын шинжтэй эрх зүйн томоохон актуудын нэг юм.

НҮБ-ын энэхүү конвенцоор үндэстэн дамнасан зохион байгуулалттай гэмт хэрэгтэй холбогдсон нэр томъёо, түүнийг мөрдөн байцаах, шалгах, урьдчилан сэргийлэх болон шүүн шийдвэрлэх, яллагдсан этгээдийг шилжүүлэх, эрх зүйн туслалцаа үзүүлэх зэрэг харилцааг нарийвчлан зохицуулсан төдийгүй түүний нэмэлт протоколд хүн ялангуяа эмэгтэйчүүд хүүхдийг худалдаалахаас урьдчилан сэргийлэх, таслан зогсоох ба шийтгэх талаар онцгойлон авч үзэж дэлхийн улс орнуудаар дагаж мөрдүүлэх уриалгыг гаргаад байна.

Тус баримт бичигт хүний наймаанаас урьдчилан сэргийлэх ба түүнтэй тэмцэх, ингэхдээ эмэгтэйчүүд ба хүүхдийн хувьд тусгайлан анхаарал тавих, хүний наймааны хохирогчдын хүний эрхийг бүрэн хүндлэн тэднийг хамгаалах, туслалцаа үзүүлэх, хамтын ажиллагааг дэмжих зэрэг зорилгуудыг тунхаглажээ. Энэ зорилгоос үзвэл хүн наймаалах гэмт хэргийн гол объект болох эмэгтэйчүүд, хүүхдийн (гэмт халдлагад өртөмтгий) эрх ашгийг тусгайлан хамгаалсан чиг үүрэгтэй олон улсын эрх зүйн хэм хэмжээ юм.

Протоколийн 3-р зүйлд “хүн худалдаалах” гэдэг нь хүнийг мөлжих зорилгоор хүч хэрэглэхээр заналхийлэх буюу хүч хэрэглэх, эсхүл хүчирхийллийн бусад хэлбэрийг ашиглах, хулгайлах, залилах, хууран мэхлэх, эрх мэдлээ урвуулан ашиглах буюу эмзэг байдлыг нь ашиглах, эсхүл өөр этгээдийг хяналтдаа байлгаж буй этгээдийн зөвшөөрлийг авахын тулд төлбөр хийж буюу ашиг олгон хахуульдах зэрэг аргаар хүмүүсийг урвуулан

элсүүлэх, тээвэрлэх, дамжуулах, нуугдуулах буюу хүлээж авах үйлдлийг хэлнэ гэжээ.

“Мөлжих” гэдэгт наад зах нь бусдын биеийг нь үнэлүүлэх буюу бэлгийн харилцаанд оруулан мөлжих бусад хэлбэрүүд, албадан ажиллуулах буюу үйлчлүүлэх, боолчлол буюу боолчлолтой төсөөтэй заншил, эрх чөлөөгүй байлгах буюу эрхтнийг нь авах зэргийг ойлгож байна. Дээр дурдсан аргуудын аль нэгийг ашигласан байх тохиолдолд хүний наймааны хохирогч өөрийг нь мөлжих гэж байгааг өөрөө зөвшөөрснийг хэрэгсэхгүй. Мөн дээр дурдсан аргуудыг хэрэглээгүй байсан ч мөлжих зорилгоор хүүхдийг урвуулан элсүүлэх, тээвэрлэх, дамжуулах, нуугдуулах буюу хүлээж авах үйлдлийг “хүн худалдаалах” гэж үзнэ. Хүүхэд гэдэгт 18 нас хүрээгүй хүн бүрийг хэлнэ гэснээс үзвэл насанд хүрээгүй хүмүүсийн эсрэг энэ төрлийн гэмт хэргийг үйлдэхэд гэмт хэрэг үйлдэхэд ашигласан арга огт хамааралгүй гэдгийг тодорхойлон заажээ.

Оролцогч улсууд хүний наймаанаас урьдчилан сэргийлэх ба түүнтэй тэмцэх зорилгоор судалгаа, олон нийтийн хэвлэл мэдээллийн кампанит ажил явуулах, түүнчлэн нийгэм, эдийн засгийн холбогдох санаачилгуудыг хэрэгжүүлэх зэрэг арга хэмжээ авахыг эрмэлзэх ба ийнхүү тодорхойлсон бодлого, хөтөлбөрүүд болон бусад арга хэмжээ нь зохих нөхцөлд засгийн газрын бус байгууллагууд, бусад холбогдох байгууллага болон иргэний нийгмийн бусад хэсэгтэй хамтран ажиллах асуудлыг хамарна. Мөн хүн наймаалахад хүргэж буй, хүн, ялангуяа эмэгтэйчүүд болон хүүхдүүдийг бүх хэлбэрээр мөлжих явдлыг бий болгодог эрэлт хэрэгцээний эсрэг чиглэсэн хууль тогтоох буюу боловсрол, нийгэм, соёлын гэсэн бусад арга хэмжээнүүдийг авах буюу боловсронгуй болгох үүргийг тус баримт бичгээр оролцогч улс орнуудад хүлээлгэжээ.

1.2. АЛБАДАН ХӨДӨЛМӨРИЙН ТУХАЙ 29 ДҮГЭЭР КОНВЕНЦООС

Олон Улсын Хөдөлмөрийн Байгууллага (ОУХБ)-ын Женев хотноо хуралдсан дөрөвдүгээр хуралдаанаар хэлэлцэж, 1930 оны 6 дугаар сарын 28-ны өдөр баталсан тус конвенцыг Монгол Улс 2005 онд соёрхон баталжээ.

Энэхүү конвенцын 2 дугаар зүйлд албадан хөдөлмөр гэдгийг “ямар нэг торгууль шийтгэл ногдуулахаар заналхийлж

аливаа иргэнээс өөрийгөө сайн дураар санал болгоогүй байхад шаардах аливаа ажил, үйлчилгээ” хэмээн тодорхойлсон байна. Конвенцид заасан албадан хөдөлмөр гэх ойлголтоос дараах хөдөлмөрийн төрлүүдийг тусгайлан хассан байдаг. Үүнд:

- » Заавал гүйцэтгэх цэргийн алба (зөвхөн цэргийн шинжтэй ажил гүйцэтгэх);
- » Иргэний үүрэг хариуцлага, олон нийтэд үйлчлэх
- » Тодорхой нөхцөлд гүйцэтгэх ялтны хөдөлмөр;
- » Дайн, гамшиг зэрэг хүн амыг бүхэлд нь буюу нэг хэсгийг хамарсан аюултай нөхцөл байдалд гүйцэтгэх онцгой байдлын үеийн ажил үйлчилгээ зэрэг багтана.

1.3. АЛБАДАН ХӨДӨЛМӨРИЙГ УСТГАХ ТУХАЙ 105 ДУГААР КОНВЕНЦООС

ОУХБ-аас 1957 оны 6 дугаар сарын 25-ны өдөр Женев хотноо баталсан тус конвенцыг Монгол Улс 2005 онд соёрхон баталсан.

Энэхүү конвенцыг соёрхон баталсан ОУХБ-ын гишүүн бүр албадан буюу заавал хийлгэх хөдөлмөрийн аливаа хэлбэрийг хориглож, дараах зорилгоор ашиглахыг таслан зогсоох үүрэг хүлээж байна. Үүнд:

- » Улс төрийн нөлөөнд оруулах болон хүмүүжлийн арга хэрэгсэл болгох, эсхүл улс төр, эдийн засаг, нийгмийн тогтолцооны эсрэг чиглэсэн улс төрийн үзэл бодол буюу оюун санааны үзэл бодолтой байх, түүнийг илэрхийлсний төлөө ногдуулах шийтгэл болгох;
- » Эдийн засгийг хөгжүүлэх зорилгоор ажиллах хүчийг дайчлах, ашиглах арга хэлбэр болгох;
- » Хөдөлмөрийн сахилга батыг сахиулах арга хэрэгсэл болгох;
- » Ажил хаялтад оролцсонд ногдуулах шийтгэл болгох;
- » Арьс өнгө, нийгмийн байдал, яс үндэс, шашин шүтлэгээр алагчлах арга хэрэгсэл болгох;

1.4. БООЛЧЛОЛ, БООЛЫН ХУДАЛДААГ ХОРИГЛОХ ТУХАЙ КОНВЕНЦООС

Энэхүү конвенц нь Женев хотноо 1926 оны 9 дүгээр сарын 25-ны өдөр батлагдаж, 1927 оны 3 дугаар сарын 9-ний өдөр хүчин төгөлдөр болсон. 1953 оны 12 дугаар сарын 7-ны өдрийн

протоколоор нэмэлт өөрчлөлт оруулсан нь 1955 оны 7 дугаар сарын 7-ны өдрөөс хүчин төгөлдөр мөрдөгдөж болжээ.

Энэхүү конвенцод зааснаар “Боолчлол” гэдэгт өмчлөх эрхэд хамаарах бүх, эсхүл зарим эрх мэдлийг хүн дээр хэрэгжүүлсэн байдал буюу нөхцөлийг ойлгоно.

“Боолын худалдаа” гэдэгт хүнийг боол болгох зорилгоор олзлох, олж авах буюу эрхэндээ оруулах бүх үйлдэл; боолыг худалдах буюу солих зорилгоор түүнийг олж авахтай холбогдсон бүх үйлдэл; худалдах буюу солих зорилгоор олж авсан боолыг худалдах буюу солих замаар эрхэндээ оруулах бүх үйлдэл, бүхэлдээ боолыг тээвэрлэх, эсхүл худалдах бүх үйлдэл хамаарна гэжээ.

Конвенцод оролцогч улс нь өөрийн нутаг дэвсгэртээ боолын худалдааг хориглох болон түүнээс урьдчилан сэргийлэх, боолчлолын бүх хэлбэрийг аль болох богино хугацаанд эрчимтэй бүрмөсөн устгах арга хэмжээг авахыг үүрэг болгосон байна.

1.5. БООЛЧЛОЛ, БООЛЫН ХУДАЛДАА БОЛОН БООЛЧЛОЛТОЙ АДИЛТГАХ ЁС, ЗАНШЛЫГ УСТГАХ ТУХАЙ НЭМЭЛТ КОНВЕНЦООС

Энэхүү конвенцыг Женев дэх НҮБ-ын Европын салбарт 1956 оны 9 дүгээр сарын 7-ны өдөр баталж, 1957 оны 4 дүгээр сарын 30-ны өдөр хүчин төгөлдөр болсон.

Конвенцын 1 дүгээр зүйлд хараахан устаагүй байгаа дараах ёс болон заншлыг бүрэн халах буюу устгахыг аль болох богино хугацаанд амжилттай гүйцэтгэхийн тулд бүхий л хэрэгжихүйц болон шаардлагатай хуулийн болон бусад арга хэмжээ авах талаар дурдсан байна. Үүнд:

- » Өрөнд баригдаж боолчлогдсон, өөрөөр хэлбэл өртэй хүн өөрийнхөө, эсхүл өөрөөсөө хараат хүний үйлчилгээгээр өрөө төлөх үүргээ биелүүлэхтэй холбоотойгоор үүссэн барьцааны байдал буюу нөхцөл, хэрэв тэрхүү үйлчилгээг зохих ёсоор үнэлсэн үнэлгээ нь уг өрийн төлөөсөнд тооцогдохгүй, эсхүл тэрхүү хөдөлмөрийн шинж чанар, үргэлжлэх хугацаа нь тодорхой бус бол;
- » Хамжлага болох, өөрөөр хэлбэл, хууль, заншил, эсхүл гэрээний дагуу түрээслэгч өөр хүний эзэмшил газарт

амьдарч шан харамжтай буюу түүнгүйгээр хөдөлмөр хийх болон тухайн хүнд тодорхой зарим үйлчилгээ үзүүлэх үүрэг хүлээсэн нөхцөл, байдал болон уг байдлыг өөрчилж чадахааргүй бол;

- » Эмэгтэй хүнийг мөнгө болон биет эд зүйлийн оронд төлөх болзолтойгоор өөрийнх нь зүгээс татгалзах эрхгүйгээр түүний эцэг, эх асран хамгаалагч, гэр бүл, эсхүл бусад хүн, эсхүл бүлэг хүмүүсээс эхнэр болгож өгөхийг амласан эсхүл өгсөн, эмэгтэйн нөхөр, түүний гэр бүл, эсхүл овгийнхон нь тухайн эмэгтэйг өөр хүнд үнэтэй эд зүйлсийн оронд буюу бусад хэлбэрээр шилжүүлэн өгөх эрх эдэлдэг байх, нөхрийг нь нас барахад бэлэвсэн эхнэрийг бусдад өвлүүлэн өгөх зэрэг үйлдлийг зөвшөөрсөн аливаа ёс, заншил;
- » 18 нас хүрээгүй болон бага насны хүүхдүүдийг ашиглах буюу тэдний хөдөлмөрийг мөлжих зорилгоор эцэг эхийнх нь аль нэг, эсхүл хоёул, эсхүл асран хамгаалагч нь тэднийг шан харамжтай буюу түүнгүйгээр бусдад өгдөг аливаа ёс буюу заншил;

Энэхүү конвенцын оролцогч улсууд шаардлагатай бол гэрлэх насны зохистой доод хэмжээг тогтоох, иргэний болон албан тушаалтан болон шашны төлөөлөгчид гэрлэгчдээс хүслээ чөлөөтэй илэрхийлдэг болон хоёр талын аль аль нь зөвшөөрсний үндсэн дээр гэрлэдэг нөхцөлийг хангасан журам тогтоох, түүнчлэн гэрлэлтийг бүртгэдэг байхыг хөхиүлэн дэмжих үүргийг хүлээж байна.

1.6. ХҮҮХДИЙН ЭРХИЙН КОНВЕНЦООС

Хүүхдийн эрхийн тухай конвенцыг НҮБ-ын Ерөнхий Ассамблей 1989 оны 11 дүгээр сарын 20-нд баталснаас хойш 193 орон нэгдэн орсон бөгөөд хүн төрөлхтний түүхэн дэх хамгийн олон улс орон баталсан хүний эрхийн хэлэлцээр болсон юм. Монгол Улс 1990 оны 7 дугаар сарын 5-ны өдөр тус конвенцод нэгдэн орж хэрэгжүүлэх үүргийг хүлээжээ.

Хүүхдийн эрхийн конвенцын оролцогч улсууд хүүхдийг хууль бусаар шилжүүлэх буюу гадаад улсаас эх оронд нь буцаахгүй байхтай тэмцэх, эцэг эх, хууль ёсны асран хамгаалагч, хүүхдийг асран халамжилж байгаа бусад хүн хүүхдийг бие бялдар, сэтгэл зүйн хувьд бүхий л хэлбэрээр дарамтлах, доромжлох, сөргөөр ашиглах, хайр халамжгүй орхих, зүй бусаар хандах,

хэрцгийгээр харьцах, албадан хөдөлмөрлүүлэх буюу бэлгийн хүчирхийллээс хамгаалах зорилгоор хууль тогтоох, захиргааны, нийгмийн болон гэгээрлийн бүхий л шаардлагатай арга хэмжээ авах үүрэгтэй.

Мөн оролцогч улсууд хүүхдийг бэлгийн замаар ашиглан мөлжих бүхий л хэлбэрээс хамгаалах үүрэг хүлээнэ. Энэ зорилгоор оролцогч улсууд дараах зүйлээс урьдчилан сэргийлэхэд чиглэсэн үндэсний, хоёр талт болон олон талт шаардлагатай бүх арга хэмжээг авах тухай заажээ:

- » хүүхдийг бэлгийн хууль бус аливаа ажиллагаанд татан оролцуулах буюу шахалт үзүүлэх;
- » хүүхдийн биеийг үнэлүүлэх буюу бэлгийн хууль бус бусад ажиллагаанд ашиглан мөлжих;
- » хүүхдийг садар самуун үзүүлбэр болон түүнийг сурталчилсан материалд ашиглах.

Оролцогч улсууд хүүхдийг аливаа зорилго, хэлбэрээр хулгайлах, худалдах буюу хил дамжуулан худалдах явдлаас урьдчилан сэргийлэхэд чиглэсэн үндэсний, хоёр талт болон олон талт шаардлагатай бүх арга хэмжээг авна. Ийнхүү нөхөн сэргээх, нийгэмд нэгтгэх үйл явц нь хүүхдийн эрүүл мэнд, нэр төр, үе тэнгийнхний хүндэтгэл хангагдсан нөхцөлд хэрэгжих ёстой гэжээ.

1.7. ХҮҮХДИЙН ЭРХИЙН КОНВЕНЦЫН НЭМЭЛТ ХҮҮХДИЙГ ХУДАЛДАХ, ХҮҮХДИЙН БИЕИЙГ ҮНЭЛЭХ, ХҮҮХДИЙГ САДАР САМУУНД СУРТАЛЧЛАХЫН ЭСРЭГ ПРОТОКОЛООС

Хүүхдийн эрхийн конвенцын нэмэлт Хүүхдийг худалдах, хүүхдийн биеийг үнэлэх, хүүхдийг садар самуунд сурталчлахын эсрэг протокол нь НҮБ-ын Ерөнхий Ассамблейн 2000 оны 5 дугаар сарын 25-ны өдрийн А/RES/54/263 тогтоолоор батлагдаж, 2002 оны 1 дүгээр сарын 18-ны өдөр хүчин төгөлдөр болсон байна.

Энэхүү Протоколд зааснаар оролцогч улсууд хүүхдийг худалдах, хүүхдийн биеийг үнэлэх болон хүүхдийг садар самуунд сурталчлахыг хориглоно.

Оролцогч улс бүр эрүүгийн болон гэмт хэргийн талаарх хуульдаа дор хаяж дараах үйлдэл болон үйл ажиллагааг бүрэн

хамааруулж, эдгээр гэмт хэрэг улсын дотоодод буюу үндэстэн дамнасан болон ганцаарчилсан буюу зохион байгуулалттай хэлбэрээр үйлдэгдсэнийг харгалзахгүйгээр хариуцлага хүлээлгэх талаар дараах агуулгыг тусгасан байна. Үүнд:

- » хүүхдийг аливаа арга хэрэгслээр дараах зорилгоор санал болгох, шилжүүлэх буюу авах, бэлгийн хүчирхийлэлд ашиглах; шан харамж авч хүүхдийн эрхтнийг шилжүүлэх; хүүхдийг албадан хөдөлмөр эрхлүүлэхэд ашиглах;
- » хүүхэд үрчлэх үйл ажиллагаанд зуучлахдаа хүүхэд үрчлэх тухай олон улсын эрх зүйн баримт бичгийн заалтыг зөрчиж хууль бус арга хэрэглэн зөвшөөрүүлэх,
- » хүүхдийн биеийг үнэлэх зорилгоор хүүхдийг санал болгох, авах, шилжүүлэх болон өгөх;
- » хүүхэд оролцсон садар самуун сурталчилгааг үйлдэх, түгээх, тараах, импортлох, санал болгох, худалдах буюу хадгалбал хүлээлгэх хариуцлагын талаар тодорхой заах

Үндэсний хууль тогтоомжийн заалтаас хамааран дээрх үйлдлийн аль нэгийг хийхээр оролдсон, хамтран оролцсон тохиолдолд дээрх заалт мөн адил үйлчилнэ. Эдгээр гэмт хэргийн гэм хор үзүүлсэн зэрэглэлийг харгалзан оролцогч улс бүр зохих шийтгэл ногдуулах тухай дурдсан байна.

Оролцогч улсууд хүүхдийг худалдах, хүүхдийн биеийг үнэлэх болон хүүхдийг садар самуунд сурталчлах, бэлгийн дур хүслээ хүүхдээр хангах аялал зэрэг үйл ажиллагаанд оролцсон этгээдийг таслан зогсоох, илрүүлэх, мөрдөн байцаах, эрүүгийн хэрэгт шалгах болон шийтгэх зорилгоор олон талт, бүс нутгийн болон хоёр талт тохиролцоо байгуулах замаар олон улсын хамтын ажиллагааг бэхжүүлэхэд шаардлагатай арга хэмжээ авах үүрэг хүлээж байна.

Мөн хүүхдийг худалдах, хүүхдийн биеийг үнэлэх болон хүүхдийг садар самуунд сурталчлах, хүүхэд ашиглах секс аялалд нөлөөлж буй ядуурал болон хөгжлийн дорой байдал зэрэг шалтгааныг арилгах зорилгоор олон улсын хамтын ажиллагааг бэхжүүлэхэд дэмжлэг үзүүлнэ. Эл зорилгоор олон талт, бүс нутгийн, хоёр талт болон бусад хөтөлбөрийн хүрээнд санхүүгийн, техникийн болон бусад туслалцааг зохих боломжийн хэрээр үзүүлэх тухай заажээ.

1.8. ХҮҮХДИЙН ХӨДӨЛМӨРИЙН ТЭВЧИШГҮЙ ХЭЛБЭРИЙН ТУХАЙ ОЛОН УЛСЫН ХӨДӨЛМӨРИЙН БАЙГУУЛЛАГЫН 182 ДУГААР КОНВЕНЦООС

Хүүхдийн хөдөлмөрийн тэвчишгүй хэлбэрийн тухай олон улсын хөдөлмөрийн байгууллагын 182 дугаар конвенцыг Олон Улсын Хөдөлмөрийн Байгууллагын Ерөнхий бага хурал 1999 оны 6 дугаар сарын 17-ны өдөр баталж, 2000 оны 11 дүгээр сарын 19-ний өдрөөс хүчин төгөлдөр болсон.

Конвенцын зорилгод нийцүүлэн “хүүхдийн хөдөлмөрийн тэвчишгүй хэлбэр” гэдэгт:

- » боолчлолын бүх хэлбэр болон хүүхдийг худалдах, дамжуулан худалдах, өрийн төлөөс, хамжлагын албат болгох, хүчээр буюу албадан хөдөлмөрлүүлэх, түүний дотор зэвсэгт мөргөлдөөнд ашиглах зорилгоор хүчээр буюу албадан оролцуулах зэрэг боолчлолтой төстэй үйл ажиллагаа;
- » хүүхдийг биеэ үнэлэх, садар самуун сурталчилгааны үйлдвэрлэл буюу садар самуун үзүүлбэрт ашиглах, зуучлах, санал болгох;
- » олон улсын холбогдох гэрээнд тодорхойлсноор хүүхдийг мансууруулах бодис үйлдвэрлэх, хил дамжуулан худалдах зэрэг хууль бус үйл ажиллагаанд ашиглах, зуучлах, санал болгох;
- » ажлын шинж чанар, түүнийг гүйцэтгэх нөхцөл нь хүүхдийн эрүүл мэнд, аюулгүй байдал, ёс суртахуунд хор нөлөө үзүүлэх ажлыг ойлгож байна.

Улс бүр хүүхдийн хөдөлмөрийн тэвчишгүй хэлбэрийг нэн тэргүүнд устгахад чиглэсэн үйл ажиллагааны хөтөлбөр боловсруулан хэрэгжүүлэх үүрэгтэй. Үйл ажиллагааны хөтөлбөрийг холбогдох төрийн байгууллага, ажил олгогч болон ажилчдын байгууллагатай зөвшилцөн, бусад зохих бүлгийн санал бодлыг харгалзан боловсруулах буюу хэрэгжүүлэх тухай дурджээ.

1.9. ХҮҮХДИЙГ ХАМГААЛАХ БОЛОН УЛС ХООРОНД ҮРЧЛЭХ АСУУДЛААР ХАМТРАН АЖИЛЛАХ ТУХАЙ КОНВЕНЦООС

1993 оны 5 дугаар сарын 29-ний өдөр Гаг хотноо чуулсан Олон улсын хувийн эрх зүйн асуудлаарх Гаагийн бага хурлын

17 дугаар чуулганы үеэр Хүүхдийг хамгаалах болон улс хооронд үрчлэх асуудлаар хамтран ажиллах тухай конвенцыг баталж, 1995 оны 5 дугаар сарын 1-ний өдрөөс хүчин төгөлдөр болсон.

Энэхүү Конвенц нь улс хооронд хүүхэд үрчлэхэд хүүхдийн дээд ашиг сонирхол болон түүний үндсэн эрх олон улсын эрх зүйд нийцэж байгаа талаар баталгаа бүрдүүлэх, хүүхэд хулгайлах, худалдах, хил дамнан худалдахаас сэргийлж тэдгээр баталгааг хүндэтгэх үүднээс хэлэлцэн тохирогч улсууд хамтын ажиллагааны тогтолцоо бий болгох, хэлэлцэн тохирогч улсууд Конвенцын дагуу хүүхэд үрчлэхийг зөвшөөрөх явдлыг хангуулах гол зорилготой.

1.10. ЭМЭГТЭЙЧҮҮДИЙГ АЛАГЧЛАХ БҮХ ХЭЛБЭРИЙГ УСТГАХ КОНВЕНЦООС

НҮБ-ын Ерөнхий Ассамблейн 34/180 тоот тогтоолоор тус конвенцыг 1979 оны 12 дугаар сарын 18-ны өдөр баталж, 1981 оны 9 дүгээр сарын 3-ны өдрөөс хүчин төгөлдөр болсон. Монгол Улс 1980 оны 07 дугаар сарын 10-нд гарын үсэг зурж, 1981 оны 05 дугаар сарын 14-нд соёрхон баталсан.

“Эмэгтэйчүүдийг алагчлах” гэдэгт гэрлэлтийн байдлаас үл хамаарч эрэгтэй, эмэгтэйчүүдийн тэгш эрхийн үндсэн дээр улс төр, эдийн засаг, нийгэм, соёл, иргэний болон аливаа бусад салбарт эмэгтэйчүүдийн хүний эрх, үндсэн эрх чөлөөг хүлээн зөвшөөрөх, эдлүүлэх, хэрэгжүүлэхэд саад хийх, эсхүл үгүйсгэх үр дагавар, эсхүл зорилго бүхий хүйсээр ялгаварлах, үгүйсгэн гадуурхах буюу хязгаарлахыг ойлгох тухай заасан байна.

Оролцогч улсууд эмэгтэйчүүдийг худалдах, тэдний биеийг үнэлүүлэн ашиглах бүх хэлбэрийг таслан зогсоохын тулд зохистой бүх арга хэмжээ, түүний дотор хууль тогтоох арга хэмжээг авна. Мөн эрэгтэй, эмэгтэйчүүдийн тэгш эрхийн үндсэн дээр хөдөлмөр эрхлэлтийн салбарт эмэгтэйчүүдийг алагчлах үзлийг устгахын тулд эрэгтэй, эмэгтэйчүүдийг тэгш эрхээр хангах зорилгоор зохистой бүх арга хэмжээг авах тухай заажээ.

Монгол Улсын Их Хурлаас 2015 онд баталсан Эрүүгийн хууль /шинэчилсэн найруулга/-ийн 13.1 дүгээр зүйлд хүн худалдаалах гэмт хэргийг хуульчлахдаа НҮБ-ын Үндэстэн дамнанас зохион байгуулалттай гэмт хэргийн эсрэг конвенцын нэмэлт Палермогийн протокол, Хүн худалдаалахтай тэмцэх тухай Монгол Улсын хуулийн агуулгад нийцүүлж, 2002 оны Эрүүгийн хуулийн 113 дугаар зүйлийн зарим заалтыг айлбарлах тухай 2008 оны Улсын дээд шүүхийн 12 дугаар тогтоол, Эрүүгийн хуульд заасан хууль тогтоогчийн тайлбарыг тус тус гэмт хэргийн объектив талын шинжид багтаан хуульчилсан онцлогтой.

НҮБ-ын Үндэстэн дамнанас зохион байгуулалттай гэмт хэргийн эсрэг конвенцын нэмэлт Палермогийн протокол	Эрүүгийн хууль /шинэчилсэн найруулга/
<p>Хүн худалдаалах гэдэг нь “Хүнийг мөлжих зорилгоор хүч хэрэглэхээр заналхийлэх буюу хүч хэрэглэх, эсхүл хүчирхийллийн бусад хэлбэрийг ашиглах, хулгайлах, залилах, хууран мэхлэх, эрх мэдлээ урвуулан ашиглах буюу эмзэг байдлыг нь ашиглах, эсхүл өөр этгээдийг хяналтдаа байлгаж буй этгээдийн зөвшөөрлийг авахын тулд төлбөр хийж буюу ашиг олгон хахуульдах зэрэг аргаар хүмүүсийг урвуулан элсүүлэх, тээвэрлэх, дамжуулах, нуугдуулах буюу хүлээж авах” үйлдлийг хэлнэ.</p>	<p>Хүн худалдаалах гэдэг нь “Биеийг нь үнэлүүлэх, бусад хэлбэрээр бэлгийн мөлжлөг, хүчирхийлэлд оруулах, боолчлох, түүнтэй ижил төстэй нөхцөлд байлгах, эд, эрхтнийг авах, албадан хөдөлмөрлүүлж мөлжих зорилгоор хүч хэрэглэж, хүч хэрэглэхээр заналхийлж, хулгайлж, хууран мэхэлж, итгэл эвдэж, эрх мэдлээ урвуулан ашиглаж, эмзэг байдлыг нь далимдуулж, эсхүл хяналтдаа байлгаж байгаа хүнд төлбөр төлж, хахуульдаж хүнийг эрхшээлдээ оруулан элсүүлсэн; тээвэрлэсэн; орогнуулсан; дамжуулсан; хүлээн авсан” үйлдлийг хэлнэ.</p>
<p>“Мөлжих” гэдэгт наад зах нь бусдын биеийг нь үнэлүүлэх буюу бэлгийн харилцаанд оруулан мөлжих бусад хэлбэрүүд, албадан ажиллуулах буюу үйлчлүүлэх, боолчлол буюу боолчлолтой төсөөтэй заншил, эрх чөлөөгүй байлгах буюу эрхтнийг нь авах зэргийг ойлгоно.</p>	

<p>Дээр дурдсан аргуудын аль нэгийг ашигласан байх тохиолдолд хүн худалдаалах хэргийн хохирогч өөрийг нь мөлжих гэж байгааг өөрөө зөвшөөрснийг хэрэгсэхгүй.</p>	<p>Энэ гэмт хэргийг үйлдсэнд тооцоход хохирогч өөрийг нь хуулийн 13.1 дүгээр зүйлийн 1 дэх хэсэгт заасан аргаар хохироож байгааг өөрөө зөвшөөрсөн эсэх нь гэмт хэргийн зүйлчлэлд нөлөөлөхгүй.</p>
<p>Дээр дурдсан аргуудыг хэрэглээгүй байсан ч мөлжих зорилгоор хүүхдийг урвуулан элсүүлэх, тээвэрлэх, дамжуулах, нуугдуулах буюу хүлээж авах үйлдлийг “хүн худалдаалах” гэж үзнэ. Хүүхэд гэдэгт 18 нас хүрээгүй хүн бүрийг хэлнэ.</p>	<p>Тайлбар: Хүүхдийн эсрэг энэ гэмт хэргийг үйлдсэнд тооцоход энэ зүйлийн 1 дэх хэсэгт заасан аргаар үйлдсэн байхыг шаардахгүй.</p>

Хүн худалдаалах гэмт хэрэг нь хүний хувийн эрх, эрх чөлөө, халдашгүй, чөлөөтэй байх эрхэд халддаг, нийгэмд аюултай, гэм буруутай үйлдэл бөгөөд олон улсын шинжтэй гэмт хэрэгт тооцдог.

2.2. ХҮН ХУДАЛДААЛАХ ГЭМТ ХЭРГИЙН ҮНДСЭН ШИНЖИ

Объект: Хүний халдашгүй, чөлөөтэй байх эрх, бусад ашиг сонирхол байна.

Халдлагад өртөгч: Худалдаалагдсан хүн байна. Хүн худалдаалахтай тэмцэх тухай² хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.2-д “хохирогч” гэж Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд заасны дагуу эрүүгийн хэрэг үүсгэсэн, хохирогчоор тогтоосон эсэхээс үл шалтгаалан хүн худалдаалахын улмаас эрх, эрх чөлөө, ашиг сонирхол нь зөрчигдсөн хүнийг ойлгохоор заасан.

Объектив тал: Эрүүгийн хуульд заасан тусгай зорилгоор хүнийг худалдаалахдаа хүч хэрэглэх, хүч хэрэглэхээр заналхийлэх, хулгайлах, хууран мэхлэх, итгэл эвдэх, эрх мэдлээ урвуулан ашиглах, эмзэг байдлыг нь далимдуулах, эсхүл хяналтандаа байлгаж байгаа хүнд төлбөр төлж, хахуульдах аргаар хүнийг эрхшээлдээ оруулан элсүүлсэн, тээвэрлэсэн, орогнуулсан, дамжуулсан, хүлээн авсан идэвхтэй үйлдэл байна.

Хүн худалдаалах гэмт хэрэг нь эдгээр үйлдлүүдийн аль нэгийг хийснээр төгсдөг хэлбэрийн шинжтэй гэмт хэрэг бөгөөд хохирол, хор уршиг учирсан байхыг шаардахгүй. Хохирогч

¹ Б.Энхболд, С.Гантулга, Эрүүгийн эрх зүйн тусгай анги, сурах бичгээс

² Хүн худалдаалахтай тэмцэх тухай хууль, УБ., 2012, 3 дугаар зүйл

худалдаалагдахыг өөрөө зөвшөөрсөн эсэх нь гэмт хэргийн зүйлчлэлд нөлөөлөхгүй³ байхаар зохицуулсан нь хохирогч хамгааллын талаар авсан эрх зүйн шинэлэг зохицуулалт юм.

- » **Хүч хэрэглэсэн** гэж гэмт этгээд хохирогчийн бие махбодид халдаж, түүний эсэргүүцлийг няцаасан байхыг ойлгоно. Хохирогчийн бие махбодод халдах үйлдэл нь алгадах, цохих, түлхэх, дарах, хоолойг боох, зэрэг хэлбэртэй байж болно.
- » **Хүч хэрэглэхээр заналхийлсэн** гэж гэмт этгээд хохирогчийг болон ойр дотны хүнийг ална, эрүүл мэндэд хохирол учруулна, эрх, эрх чөлөөг хязгаарлана зэргээр айлан сүрдүүлсэн байхыг ойлгоно.
- » **Хулгайлсан** гэж хүнийг худалдаалах зорилгоор хүч хэрэглэж, хүч хэрэглэхээр заналхийлж, хууран мэхэлж, эсхүл сэтгэцийн өвчтэй, согтуурсан, мансуурсан, сэтгэцийн үйл ажиллагаа нь түр сарнисан, бусад өвчний улмаас биеэ хамгаалах, эсэргүүцэл үзүүлэх чадваргүй байдлыг ашиглаж эрхшээлдээ оруулан авч явсан 4 үйлдлийг ойлгоно.
- » **Хууран мэхэлсэн** гэж үгээр буюу үйлдлээр бодит байдлыг нуун дарагдуулах эсхүл зохиомол байдлыг зориудаар бий болгох замаар бусдыг төөрөгдүүлснийг ойлгоно. Тухайлбал хохирогчийг гадаад улсад өндөр цалинтай ажилд зуучилна, суралцуулна, тэтгэлэг олгуулна, виз гаргана зэргээр худал амлах хэлбэрээр илэрнэ.
- » **Итгэл эвдсэн** гэж хоёр талын итгэлцэлд үндэслэх бөгөөд хохирогчид ашигтай нөхцөл бий болгоно гэж хуурамч гэрээ бичиг баримт ашиглан итгүүлэх, дараа нь итгэлийг нь хөсөрдүүлснийг ойлгоно.
- » **Эрх мэдлээ урвуулан ашигласан** гэж албан тушаалтан албан үүрэг, бүрэн эрх, албан тушаалын байдлаа урвуулан ашиглаж, эсхүл зориуд хэрэгжүүлэхгүй байж үйлдсэнийг ойлгоно.
- » **Хохирогчийн эмзэг байдлыг далимдуулсан** гэж хохирогчийн эдийн засаг, эрүүл мэнд болон хөгжлийн бэрхшээлтэй байдал, гэр бүлийн таагүй орчин түүнчлэн, амьдрал ахуйн бусад хүнд байдал зэргийг ашигласан байхыг ойлгоно.

³ Эрүүгийн хуулийн 13.1 дүгээр зүйлийн тайлбар

⁴ Эрүүгийн хууль /шинэчилсэн найруулга/, УБ.,2015, 13.2 дугаар зүйлийн 13.2.1 дэх заалт

- » **Хяналтдаа байлгаж байгаа хүнд төлбөр төлж, хахуульдаж хүнийг эрхшээлдээ оруулсан** гэж хохирогчийг бүх хэлбэрээр хяналтдаа байлгаж буй этгээд өөртөө эдийн болон эдийн бус ашигтай байдлыг бий болгох болзолтойгоор бусдад хүнийг шилжүүлж буй үйлдлийг ойлгоно. Тухайлбал өөрийн асрамжид байдаг бага насны хүүхдийг бусдаас мөнгө авч, шилжүүлсэн г.м
- » **Элсүүлсэн** гэж хүнийг худалдаалах зорилгоор тухайн болон бусад этгээдийг айлган сүрдүүлэх, тулган шаардах, ятгах замаар гэмт ажиллагааны оролцогч болго аливаа үйлдлийг хэлнэ. Хүн худалдаалах гэмт хэргийг үйлдэхдээ бусдыг татан оролцуулахаас гадна хохирогчийн биеэ хамгаалах чадваргүй болон эрхшээлдээ байгаа байдал зэргийг далимдуулан зөвшөөрүүлэх явдал нь энэ ойлголтод нэгэн адил хамаарна.
- » **Тээвэрлэсэн** гэж хүн худалдаалж байгааг мэдсэн этгээд худалдаалагдаж буй этгээдийг нэг газраас нөгөөд бүх төрлийн тээврийн хэрэгслээр ил болон далд хэлбэрээр зөөвөрлөхөөс гадна уг ажиллагаанд бүх талын дэмжлэг туслалцаа үзүүлэхийг ойлгоно. Хүн худалдаалж байгаа этгээд өөрөө тээвэрлэсэн бол энэ нь түүний гэмт үйлдлийн нэг хэсэг болно.
- » **Дамжуулсан** гэж хүн худалдаалж байгааг мэдсэн этгээд хүнийг гуравдагч улсын нутаг дэвсгэрээр дамжуулан хил нэвтрүүлэх, нэг этгээдээс нөгөөд хүнийг шилжүүлэх болон уг ажиллагаанд бүх талын дэмжлэг туслалцаа үзүүлэхийг хэлнэ.
- » **Орогнуулсан** гэж хүн худалдаалж байгааг мэдсэн этгээд худалдаалагдаж буй хүнийг хүлээн авах этгээдэд шилжих хүртэл түр хугацаагаар өөрийн эсхүл бусдын орон байранд хяналттай болон хяналтгүйгээр нуугдуулан байрлуулахыг ойлгоно.
- » **Хүлээн авсан** гэж худалдаалагдсан хүнийг өөрийн мэдэлд байлгаж, ашиглахаар шилжүүлэн авахыг ойлгоно.
- » Субъектив тал: Гэм буруугийн санаатай хэлбэрээр үйлдэгдэх бөгөөд хохирогчийн биеийг нь үнэлүүлэх, бусад хэлбэрээр бэлгийн мөлжлөг, хүчирхийлэлд оруулах, боолчлох түүнтэй ижил төстэй нөхцөлд байлгах, эд эрхтнийг авах, албадан хөдөлмөрлүүлж мөлжих тусгай зорилготой байна.

- » **Биеийг нь үнэлүүлэх** гэж хохирогчийн хүсэл зоригийн эсрэг түүнийг бусадтай төлбөртэйгөөр бэлгийн харьцаанд оруулахыг ойлгоно.
- » **Бусад хэлбэрээр бэлгийн мөлжлөг, хүчирхийлэлд оруулах** гэж хохирогчийн хүсэл зоригийн эсрэг түүнийг садар самуун сурталчилсан кино, дүрс бичлэг, тайчих үзүүлбэр, тоглолт, уралдаан, тэмцээнд оруулахыг ойлгоно.
- » **Боолчлох, түүнтэй ижил төстэй нөхцөлд байлгах** гэж хүн бусад хүнийг хүчээр өөрийн өмч болгон өөрийн дур хүсэл, сонирхлын дагуу ажиллуулахыг хэлнэ. Өөрөөр хэлбэл, эд хөрөнгийн болон эд хөрөнгийн бус өмчлөх эрхэд хамаарах бүх, эсхүл зарим эрхийг хүн дээр хэрэгжүүлж, түүнийг төрөлхийн болон жам ёсны бүх эрхийг хориглох буюу хязгаарлахыг ойлгоно.
- » **Эд эрхтнийг авах** гэж гэмт этгээд өөрийн болоод бусдын бие, эд, эрхтнийг нөхөн сэргээх, аль нэг эрхтнийг орлуулан солих, эсхүл бусдад худалдаалж ашиг олох зорилгоор хүний эд, эрхтнийг авсныг ойлгоно.
- » **Албадан хөдөлмөрлүүлэх** гэж хүний хүсэл зоригийн эсрэг илт хохиролтой болзол, нөхцөл тулгаж, аливаа ажил үйлчилгээг цалин хөлсгүй гүйцэтгүүлэхийг ойлгоно.
- » Субъект: Эрүүгийн хуульд эрүүгийн хариуцлага хүлээлгэхээр заасан 16 насанд хүрсэн, хэрэг хариуцах чадвартай хувь хүн байна.

2.3. ХҮН ХУДАЛДААЛАХ ГЭМТ ХЭРГИЙН ХҮНДРҮҮЛЭХ ШИНЖ

- » **Хүүхэд, жирэмсэн эмэгтэйг мэдсээр байж** гэж гэмт этгээд хохирогчийг 18 насанд хүрээгүй эсхүл жирэмсэн гэдгийг түүний гадаад төрх байдал, хоорондын харилцаа, эсхүл бусад эх сурвалжаас лавтай мэдэж байсныг ойлгоно.
- » **Хоёр, түүнээс олон хүнийг худалдаалсан** гэж гэмт этгээд хоёр буюу түүнээс олон хүнийг худалдаалах гэсэн нэгдмэл нэг санаа зорилгоо цаг хугацаанд, эсхүл тодорхой цаг хугацааны дараа хэрэгжүүлсэн байхыг хэлнэ.
- » **Монгол Улсын хилээр нэвтрүүлсэн** гэж хүн худалдаалахын тулд Монгол Улсын хилийг нууцаар эсхүл хуурамч буюу хууль ёсны баримт бичиг ашиглан илээр нэвтрүүлэхийг ойлгоно.

- » **Хүн худалдаалах гэмт хэргийг байнга тогтвортой үйлдсэн** гэж энэ гэмт хэргийг гурав ба түүнээс дээш удаа үйлдсэн байхыг ойлгоно.
- » **Зохион байгуулалттай гэмт бүлэг үйлдсэн** гэж гэмт хэрэг байнга үйлдэж ашиг олох зорилгоор урьдчилан нэгдсэн гурав, түүнээс олон хүний тогтвортой нэгдэл 5 үйлдсэнийг ойлгоно.

2.4. ХҮН ХУДАЛДААЛАХ ГЭМТ ХЭРГИЙН ТӨРӨЛ

Нэг. Бэлгийн мөлжлөг

Дэлхий нийтээр хүний худалдаалах гэмт хэргийн 70-аас илүү хувь нь бэлгийн мөлжлөгийн зорилгоор үйлдэгддэг. Уг гэмт хэрэг хил дамнан болон өөрийн улс дотор үйлдэгддэг ч илрүүлэлт багатай байдаг. Хохирогч нь дийлэнхдээ насанд хүрээгүй охид, залуу эмэгтэйчүүд байдаг боловч цөөн тохиолдолд хөвгүүд, залуу эрэгтэйчүүд өртөж болно. Олон улсын хөдөлмөрийн байгууллагын тоо мэдээнээс харвал бэлгийн мөлжлөгийн зорилгоор худалдаалагдсан хохирогчдын 99% нь охид, эмэгтэйчүүд байсан байна⁵. Насанд хүрсэн хүнийг албан шахалтаар, хүч хэрэглэхээр айлган сүрдүүлсэн, хууран мэхлэн, хүч хэрэглэх болон эдгээрийн аль алийг хэрэглэсний улмаас биеэ үнэлэх байдалд орсон бол ХХГХ-ийн хохирогчоор тооцно. Энэ тохиолдолд хохирогчдыг элсүүлсэн, орогнуулсан, тээвэрлэсэн, нийлүүлсэн, нуун далдалсан, худалдан авсан, худалдсан болон дээрх бүх зорилгоор тодорхой этгээдийг өөртөө хадгалсан үйлдэл хийсэн этгээдийг насанд хүрсэн хүнийг бэлгийн мөлжлөгт өртүүлсэн бол хүн худалдаалах гэмт хэрэг үйлдсэнд тооцно.

Бэлгийн мөлжлөг нь зарим тохиолдолд гэмт этгээд хохирогчдод тэднийг авчрах үед гарсан зардал, тэднийг ажиллуулахад зарцуулсан зардал, түүнчлэн тэднийг амьдрахад зарцуулж буй зардлаа хүүгийн хамт төл гэх мэтээр хууль бусаар өрөнд оруулж, энэхүү өрөө төлсөн тохиолдолд өөрсдийг нь чөлөөтэй явуулна хэмээн амлах, хүч хэрэглэн биеийг нь үнэлэх явдлаар үйлдэгддэг. Түүнчлэн хохирогч хэдийгээр анхнаасаа биеэ үнэлэх зорилготой байсан боловч ийнхүү биеэ үнэлэхээр

⁵ Эрүүгийн хуулийн 3.8 дугаар зүйлийн 1 дэх хэсэг

⁶ <https://www.ilo.org/global/topics/forced-labour/lang-en/index.htm>

зөвшөөрснийх нь дараа тэднийг сэтгэл зүйн хувьд дарамтлах, биед нь хүч хэрэглэх замаар биеийг нь үнэлүүлэх тохиолдлууд олон байдаг бөгөөд үүнийг мөн адил хүн худалдаалах гэмт хэргийн хохирогч гэж авч үзнэ.

Монгол Улсын Эрүүгийн хууль /шинэчилсэн найруулга/-ийн 12.3 дугаар зүйлд “Хохирогчид хүч хэрэглэж, хүч хэрэглэхээр заналхийлж; эд хөрөнгө, албан тушаал, бусад нөхцөл байдлын улмаас эрхшээлдээ байгаа байдлыг далимдуулан зорчих эрхийг хязгаарлахгүйгээр бусадтай бэлгийн харьцаанд албадан оруулсан” үйлдлийг Бэлгийн мөлжлөгийн гэмт хэрэг хэмээн хуульчлан тогтоосон.



**БИЕИЙГ ҮНЭЛҮҮЛЭХ,
БУСАД ХЭЛБЭРЭЭР
БЭЛГИЙН МӨЛЖЛӨГТ
ӨРТҮҮЛЭХ**



**АЛБАДАН
ХӨДӨЛМӨРЛҮҮЛЖ,
МӨЛЖИХ**



**БООЛЧЛОХ, ТҮҮНТЭЙ
ИЖИЛ ТӨСТЭЙ
НӨХЦӨЛД БАЙЛГАХ**



ЭД ЭРХТНИЙГ АВАХ

Хүн худалдаалах гэмт хэрэг	Бэлгийн мөлжлөг
<p>Биеийг нь үнэлүүлэх, бусад хэлбэрээр бэлгийн мөлжлөг, хүчирхийлэлд оруулах, ... мөлжих зорилгоор хүч хэрэглэж, хүч хэрэглэхээр заналхийлж, хулгайлж, хууран мэхэлж, итгэл эвдэж, эрх мэдлээ урвуулан ашиглаж, эмзэг байдлыг нь далимдуулж, эсхүл хяналтдаа байлгаж байгаа хүнд төлбөр төлж, хахуульдаж хүнийг эрхшээлдээ оруулан элсүүлсэн; тээвэрлэсэн; орогнуулсан; дамжуулсан; хүлээн авсан</p>	<p>Хохирогчид хүч хэрэглэж, хүч хэрэглэхээр заналхийлж; эд хөрөнгө, албан тушаал, бусад нөхцөл байдлын улмаас эрхшээлдээ байгаа байдлыг далимдуулан зорчих эрхийг хязгаарлахгүйгээр бусадтай бэлгийн харьцаанд албадан оруулсан</p>
<p>Бэлгийн мөлжлөгийн гэмт хэрэг нь Хүн худалдаалах гэмт хэргээс субъектив шинжээрээ ялгагдана. Өөрөөр хэлбэл Хүн худалдаалах гэмт хэрэг нь мөлжих тусгай зорилго заасан байдаг. Гэхдээ хууль тогтоогчоос бэлгийн мөлжлөгийн гэмт хэргийн объектив талыг тодорхойлохдоо хохирогчийг бусадтай бэлгийн харьцаанд албадан оруулсан идэвхтэй үйлдэл байхаар заасан. Бэлгийн мөлжлөг гэмт хэрэг нь халдлагад өртөгчийн бэлгийн эрх чөлөө, халдашгүй байдалд хохирол учирсан байхыг шаардахгүй, бусадтай бэлгийн харьцаанд албадан оруулах үйлдэл хийснээр төгсдөг хэлбэрийн шинжтэй гэмт хэрэг.</p> <p>Бусадтай бэлгийн харьцаанд албадан оруулсан гэж хүч хэрэглэх, хүч хэрэглэхээр заналхийлэх, эд хөрөнгө, албан тушаал, бусад нөхцөл байдлын улмаас эрхшээлдээ байгаа байдлыг далимдуулан зорчих эрхийг хязгаарлахгүй байх арга хэрэглэж, хохирогчийн хүсэл зоригийн эсрэг бусадтай бэлгийн харьцаанд оруулах, бэлгийн харьцааны шинжтэй хүч хэрэглэсэн үйлдэл хийлгэхийг ойлгоно.</p> <p>Бэлгийн мөлжлөгийн гэмт хэргийн үндсэн шинжид ямар нэгэн зорилго заагаагүй боловч хүндрүүлэх шинжид хохирогчийн биеийг үнэлүүлж ашиг олох зорилгоор арван дөрвөөс арван найман насанд хүрээгүй хүнийг албадан оруулсан, урьд энэ бүлэгт заасан гэмт хэрэг үйлдэж гэм буруутайд тооцогдож байсан хүн үйлдсэн, хохирогчид мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодис хэрэглүүлж үйлдсэн, хохирогчийг жирэмсэн болгосон, хоёр, түүнээс олон хүний эсрэг үйлдсэн, байнга тогтвортой үйлдсэн, бага насны хүүхдийг албадан оруулж үйлдсэн, зохион байгуулалттай гэмт бүлэг үйлдсэн бол онгдуулах ялыг хүндрүүлэхээр зохицуулжээ.</p>	

Хоёр. Албадан хөдөлмөрлүүлж мөлжих

Монгол Улс Олон Улсын Хөдөлмөрийн Байгууллагын Албадан хөдөлмөрийн тухай 1930 оны 29-р конвенцыг 2005 онд соёрхон баталсан бөгөөд үүнд албадан хөдөлмөрийг “ямар нэг торгууль шийтгэл ногдуулахаар заналхийлж аливаа иргэнээс өөрийгөө сайн дураар санал болгоогүй байхад шаардах аливаа ажил, үйлчилгээ” хэмээн тодорхойлсон байдаг. Албадан хөдөлмөр буюу хөдөлмөр мөлжлөг нь хүч хэрэглэн болон бие махбодод нь халдах, сэтгэл зүйн албадлага үзүүлэх, хууль

тогтоомжоор айлган сүрдүүлэх, хууран мэхлэх болон бусад албадлагын арга хэрэглэн элсүүлэх, орогнуулах, тээвэрлэх, нийлүүлэх болон эзэмших гэх зэргээр бусдаар хөдөлмөр эрхлүүлсэн явдлыг ойлгоно. Дэлхий даяар албадан хөдөлмөр нь хувийн хэвшилд жил бүр 150 тэрбум ам.долларын хууль бус ашиг орлого авчирдаг бөгөөд албадан хөдөлмөр эрхэлсний улмаас ажилчдад төлөгдөөгүй цалин хөлсний нийт хэмжээг жил тутамд 19.6 тэрбум ам.доллар хэмээн тооцоолсон байна⁷.

Цалин хөлсийг тухайн ажилчныг ажилд нь хүчээр үлдээх арга хэрэгсэл болгож, зохион байгуулалттайгаар, зориудаар хойшлуулж, мөн ажил олгогчоо солих боломжоо эдлэхэд нь саад тотгор үзүүлж байвал энэ нь албадан хөдөлмөр болно. Хэрэв тухайн ажилтан дээрх байдлаар хөдөлмөр мөлжлөгт өртсөн бол түүний ажиллахаар зөвшөөрсөн эсэхээс үл хамааран тухайн хүнийг хүн худалдаалах гэмт хэргийн хохирогчоор, түүнийг авч ажиллуулсан ажил олгогчийг гэмт хэрэг үйлдсэн гэм буруутанд тооцно. Хэдийгээр шилжин суурьшигч болон бусад шилжин ирсэн хүмүүс ихэвчлэн энэ гэмт хэргийн хохирогч болдог боловч зарим тохиолдолд иргэд өөрийн оршин суугаа газарт албадан хөдөлмөрийн золиос болох тохиолдол байдаг.

Хохирогчид учирч болзошгүй аюул заналхийлэл нь бие махбод, сэтгэл санаа, санхүү болон бусад хэлбэрээр илэрч болох бөгөөд цалин хөлс олгохгүй байх, хөдөлгөөн, харилцаа холбоог хязгаарлах, бие махбодын хүчирхийлэл хэрэглэх, хувь хүний эрх, боломжийг хясан боогдуулах, ажлын муу нөхцөлд шилжүүлэх болон хууль бус цагаачлагчдыг холбогдох хууль хяналтын байгууллагуудад мэдээлэх зэрэг олон арга хэлбэрээр илэрдэг. Олон Улсын Хөдөлмөрийн байгууллагаас гаргасан албадан хөдөлмөр мөн эсэхийг тогтоох дараах шалгуур үзүүлэлтүүд⁸ байдаг. Үүнд:

- » Эмзэг байдлыг буруугаар ашиглах
- » Хууран мэхлэх
- » Чөлөөтэй зорчихыг хязгаарлах
- » Хорих, тусгаарлах
- » Бие махбодын болон бэлгийн хүчирхийлэл

⁷ https://www.ilo.org/wcmsp5/groups/public/---asia/---ro-bangkok/---ilobeijing/documents/publication/wcms_508368.pdf

⁸ ILO, Албадан хөдөлмөрийн шалгуур үзүүлэлт, https://www.ilo.org/beijing/what-we-do/publications/WCMS_537158/lang-en/index.htm

- » Айлган сүрдүүлэх, заналхийлэх
- » Бичиг баримт барьцаалах
- » Цалин хөлс олгохгүй байх
- » Өрийн барьцаа, төлөөс болгох
- » Ажиллаж, амьдрахад хортой хүнд нөхцөл
- » Илүү цагаар ажиллуулах

Тухайн нөхцөл байдалд эдгээр шинж тэмдгийн аль нэг нь эсвэл хэд хэдэн шинж тэмдэг нэгэн зэрэг илэрвэл албадан хөдөлмөр гэж тодорхойлж болно. Тиймээс энэ нь хэн нэгэн уг гэмт хэргийн хохирогч мөн эсэхийг үнэлж дүгнэх үндэс болж өгнө.

Монгол Улсын Эрүүгийн хууль /шинэчилсэн найруулга/-ийн 13.13 дугаар зүйлд “Бусдад хүч хэрэглэж, хүч хэрэглэхээр заналхийлж, илт хохиролтой болзол, нөхцөл тулгаж, эсхүл хөрөнгө чинээ, эрүүл мэнд, хөгжлийн бэрхшээлтэй байдал, гэр бүлийн таагүй орчин, амьдрал ахуйн бусад хүнд байдлыг далимдуулан эрхшээлдээ оруулж цалин хөлсгүй хөдөлмөр эрхлүүлсэн” үйлдлийг албадан хөдөлмөрлүүлэх гэмт хэрэгт тооцохоор хуульчилжээ.

Хүн худалдаалах гэмт хэрэг	Албадан хөдөлмөрлүүлэх
Биеийг нь үнэлүүлэх, бусад хэлбэрээр бэлгийн мөлжлөг, хүчирхийлэлд оруулах, боолчлох, түүнтэй ижил төстэй нөхцөлд байлгах, эд, эрхтнийг авах, албадан хөдөлмөрлүүлж мөлжих зорилгоор хүч хэрэглэж, хүч хэрэглэхээр заналхийлж, хулгайлж, хууран мэхэлж, итгэл эвдэж, эрх мэдлээ урвуулан ашиглаж, эмзэг байдлыг нь далимдуулж, эсхүл хяналтдаа байлгаж байгаа хүнд төлбөр төлж, хахуульдаж хүнийг эрхшээлдээ оруулан элсүүлсэн; тээвэрлэсэн; орогнуулсан; дамжуулсан; хүлээн авсан	Бусдад хүч хэрэглэж, хүч хэрэглэхээр заналхийлж, илт хохиролтой болзол, нөхцөл тулгаж, эсхүл хөрөнгө чинээ, эрүүл мэнд, хөгжлийн бэрхшээлтэй байдал, гэр бүлийн таагүй орчин, амьдрал ахуйн бусад хүнд байдлыг далимдуулан эрхшээлдээ оруулж цалин хөлсгүй хөдөлмөр эрхлүүлсэн
Албадан хөдөлмөрлүүлэх гэмт хэрэг нь Хүн худалдаалах гэмт хэргээс субъектив шинжээрээ ялгагдана. Өөрөөр хэлбэл Хүн худалдаалах гэмт хэрэг нь мөлжих тусгай зорилготой үйлдэгддэг онцлогтой.	

Гурав. Эд эрхтнийг авах

Эрхтэн шилжүүлэн суулгах мэс засал нь хүний амь аврах анагаахын шинжлэх ухааны гайхалтай нээлтүүдийн нэг юм. Дэлхийд донорын хомсдол нүүрлэж, жил ирэх бүр хүнд байдалд орж байгаа нь бодит байдал. Эрхтэн шилжүүлэн суулгах шаардлагатай өвчтөнүүдийн жагсаалт энэ төрлийн хагалгаа хөгжсөн улс орнуудад эрчимтэй нэмэгдэж, донор хүлээх хугацаа уртасжээ. Гэвч харамсалтай нь бэлэн донор эрхтний нийлүүлэлт үргэлж хомсдолтой, харин эрэлт нь байнга нэмэгдэж байгаагаас болж хүн худалдаалах гэмт хэргийн үйлдэгдэх нэг “хэлбэр” болох хүнийг эд эрхтний хууль бус донор болгон худалдаалах гэмт хэргийн шалтгаан, нөхцөл болж байна⁹.

Монгол Улсад сүүлийн жилүүдэд хүн амын өвчлөл нэмэгдэж, нас баралтын тэргүүлэх шалтгаанд хорт хавдар, гаднын шалтгаант осол гэмтэл эзэлж, жилээс жилд төрөлт нэмэгдэж, төрөлтийн хүндрэл буурахгүй, олдмол болон төрөлхийн цусны өвчлөл нэмэгдэж байна. Мөн эрхтэн шилжүүлэн суулгах мэс заслын эмчилгээ эрчимтэй хөгжиж 2006 онд анхны бөөр шилжүүлэн суулгах мэс заслыг хийснээс хойш 2017 он хүртэл өнөөдрийг хүртэл 128 иргэнд бөөр (108 иргэнд амьд донороос, 10 иргэнд амьгүй донороос бөөр шилжүүлэн суулгасан), 28 иргэнд элэг (27 иргэнд амьд донороос, 1 иргэнд амьгүй донороос элэг шилжүүлэн суулгасан), 2 иргэнд ясны чөмөг шилжүүлэн суулгах мэс заслын эмчилгээг амжилттай хийсэн, сүүлийн 3 жилд 300 гаруй хүн элэг шилжүүлэн суулгах мэс засал хийлгэхээр гадаад улс руу явсан байх бөгөөд зөвхөн эмчилгээний зардалд 50.000-250.000 ам доллар, бөөр шилжүүлэн суулгах мэс засал эмчилгээний зардалд 50.000-110.000 ам. доллар зарцуулж байгаа, дэлхий дээр дунджаар нийт хосын 12 хувь нь үргүйдэлтэй байдаг ба үргүйдлийн тархалт жил ирэх тусам ихсэж байгаа, ялангуяа хөгжиж байгаа орнуудад осол, гэмтэл, бэлгийн замаар дамжих халдварын шалтгаант үргүйдэл давамгайлсан, төмсөг, өндгөвчний төрөлхийн болон олдмол дутмагшил, удамшлын зарим хам шинж, төрөлхийн гаж хөгжил, хавдрын эмчилгээ зэргийн үед үйлчлүүлэгчийг үргүйдлийн эмчилгээнд хамрагдсан, эмэгтэйчүүдийн мэс заслын улмаас умай тайруулсан, авхуулсан,

⁹ Г.Амаржаргал, Г.Ганбаясгах, Хүн худалдаалах, бэлгийн хүчирхийлэл, хүчиндэх гэмт хэрэг, Өмгөөлөгчдөд зориулсан гарын авлага, УБ., 2019.

умайн төрөлхийн гаж хөгжилтэй эмэгтэйчүүд зөвхөн тээгч эхийн тусламжтай хүүхэдтэй болох боломжтой байдаг зэрэг нөхцөл байдлыг судлан тодорхойлж¹⁰ Донорын тухай хуулийн шинэчилсэн найруулгыг боловсруулан Монгол Улсын Их Хурлаас 2018 онд батлан өнөөдрийг хүртэл мөрдөж байна.

Энэ хууль хэрэгжсэнээр донор болох зөвшөөрлийг нас барахын өмнө өөрөөс нь, нас барсны дараа гэр бүлийн гишүүн, төрсөн эцэг, эх, харгалзан дэмжигчээс нь тус тус авах, донорын эгнээг өргөжүүлэх, донорын зар сурталчилгаа болон зуучлалыг хориглож, хүний эрхтний наймаанаас сэргийлэх нөхцөл бүрдсэн гэж судлаачид дүгнэж байна.

Донорын тухай хуулийн 12 дугаар зүйлд “Донор нь хүний эрүүл мэндийг хамгаалах, амь насыг аврахад зориулан цус, эс, эд, эрхтнээ өгөхдөө ашгийн төлөө бус, авлагагүй, сайн дурын байна. Донорын үйл ажиллагааг ашиг орлогын эх үүсвэр болгох, тулган шаардах, худалдахыг хориглоно” хэмээн заасан. Донор нь сэтгэцийн хувьд эрүүл, 25 насанд хүрсэн, эс, эд, эрхтнээ өгөх тухай зөвшөөрлөө бичгээр гаргасан байх бөгөөд хүүхдээс ясны хэм, чөмөг, хүйн цус авахдаа 14 хүртэлх настай бол эцэг, эх болон асран хамгаалагчийн, 14-өөс дээш настай бол өөрийнх нь болон эцэг, эх, харгалзан дэмжигч, асран хамгаалагчийн бичгээр гаргасан зөвшөөрлийг урьдчилан авч донорын амь насанд аюул учруулахгүйгээр эмнэлгийн нөхцөлд эс, эд, эрхтнийг авахаар зохицуулсан¹¹.

Шилжүүлэн суулгах эс, эд, эрхтнийг амьгүй донороос авах бөгөөд хэрэв амьд донороос авах бол эс, эдийн тохироо нь нийцсэн, эмгэг өөрчлөлтгүй, гэр бүлийн гишүүнээс авахаар хуульчилсан нь хүний эд эрхтнийг худалдаалах явдлаас урьдчилан сэргийлэх баталгаа болжээ. Мөн хүүхдээс ясны хэм, үүдэл эс, чөмөг, хүйн цуснаас бусад эс, эд, эрхтнийг шилжүүлэн суулгах зориулалтаар авахыг хориглосон нь хүүхдийг энэ төрлийн гэмт хэргийн хохирогч болохоос хамгаалах онцлог бүхий зохицуулалт болсон байна.

Монгол Улсад 2018 оныг хүртэл тээгч эхтэй холбоотой эрх зүйн зохицуулалт байгаагүй бөгөөд шинэчлэн найруулсан

¹⁰ Донорын тухай хуулийн төслийн танилцуулга, <http://forum.parliament.mn/projects/113>

¹¹ Донорын тухай хууль, 2018

Донорын тухай хуульд “эрүүл мэндийн шалтгаанаар өөрөө жирэмслэх, ураг тээх, хүүхэд төрүүлэх чадваргүй нь эмнэлгийн дүгнэлтээр тогтоогдсон эмэгтэйд тээгч эхээр дамжуулан хүүхэдтэй болохыг зөвшөөрнө” хэмээсэн нь тээгч эхтэй холбоотой хүүхэд худалдаалах явдлаас урьдчилан сэргийлэх бас нэг үндэс болсон байна..

Өнөөдрийг хүртэл манай улсад эд эрхтний наймааны хохирогч болсон тохиолдол хуулийн байгууллагад бүртгэгдээгүй байна.

Донорын тухай хууль	Хүн худалдаалахтай тэмцэх тухай хууль	Эрүүгийн хууль
3.1.1.“хүний эс, эд, эрхтэн” гэж хүний эрхтэн, эрхтний хэсэг, эс болон эдийн нийлмэл бүрдлийг	3.1.1.“хүн худалдаалах” гэж хүнийг ... эс, эд эрхтнийг нь авч ашиглан мөлжих зорилгоор ... хууль бус үйлдлийг	... эд, эрхтнийг авах, ... хүнийг эрхшээлдээ оруулан элсүүлсэн; тээвэрлэсэн; орогнуулсан; дамжуулсан; хүлээн авсан
<p>Донорын тухай хуулийн шинэчилсэн найруулга 2018 оны 01 дүгээр сарын 19-ний өдөр батлагдаж, Төрийн мэдээлэл сэтгүүлийн 2018 оны №6 дугаар хэвлэгдсэнээр хүчин төгөлдөр мөрдөгдөж эхэлсэн. Энэ хууль батлагдсантай холбоотойгоор 2018 оны 01 дүгээр сарын 19-ний өдөр Хүн худалдаалахтай тэмцэх тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.1 дэх хэсэгт “ЭС” гэдэг үгийг нэмсэн. Гэвч шинэчлэн найруулсан Эрүүгийн хуулийн 13.1 дүгээр зүйлд заасан Хүн худалдаалах гэмт хэргийн агуулгад энэ үгийг нэмэлтээр оруулаагүйг анхаарах зайлшгүй шаардлага байна.</p> <p>Монгол Улсын Эрүүгийн хуулийн тусгай ангийн 15.3 дугаар зүйлд Хүний цус, эс, эд, эрхтнийг хууль бусаар авах гэмт хэргийг тодорхойлсон. Өөрөөр хэлбэл Хүний цус, эс, эд, эрхтнийг хууль бусаар авах гэмт хэрэг гэж хүний хувийн аюулгүй байдалд халдаж, цус, эс, эд, эрхтнийг хууль бусаар авсан нийгэмд аюултай, гэм буруутай үйлдэл юм. Хууль тогтоогчоос энэ үйлдлийг хүнд гэмт хэргийн ангилалд багтаан эрүүгийн хариуцлага оногдуулахаар хуульчилжээ¹. Хүний цус, эс, эд, эрхтнийг хууль бусаар авах гэмт хэргийг хууран мэхлэх, хүч хэрэглэх, хүч хэрэглэхээр заналхийлэх, хохирогчийн хөрөнгө чинээ, эрүүл мэнд, хөгжлийн бэрхшээлтэй байдал, гэр бүлийн таагүй орчин, амьдрал ахуйн бусад хүнд байдал, биеэ хамгаалж чадахгүй байдлыг далимдуулах аргаар үйлдэнэ. Энэ нь хүн худалдаалах гэмт хэргийн үйлдлийн аргатай ижил байгаа хэдий ч субъектив шинжээрээ ялгагдана.</p> <p>Мөн хүний цус, эс, эд, эрхтнийг авах зорилгоор хүн худалдаалсан бол хүн худалдаалах гэмт хэрэг гэж үзэж Эрүүгийн хуулийн 13.1 дүгээр зүйлд зааснаар зүйлчилнэ².</p>		

2.5. ХҮН ХУДАЛДААЛАХ ГЭМТ ХЭРГИЙН ХОХИРОГЧИЙН ТУХАЙ

Хүний наймаа үйлдэж буй гэмт хэрэгтнүүд, захиалагч, зуучлагч, ажил олгогчид нь хохирогчийн сэтгэл зүй болон бие махбодыг бүрэн хяналтдаа авахын тулд доорхи аргуудыг ашигладаг¹². Үүнд:

- » Хүч хэрэглэх – хохирогчийг эрхшээлдээ оруулахдаа бусад хохирогчийн дэргэд хүч хэрэглэх, хэрцгийгээр зодох, тарчлаадаг. Энэ нь бусад хохирогч үг дуугүй хэлснийг нь дагах нөхцөлийг бүрдүүлдэг.
- » Айлган сүрдүүлэх – байнгын айдаст байлгах, өөрийг нь болон гэр бүлийн гишүүдийг нь заналхийлэх, сүрдүүлдэг.
- » Хууран мэхлэх – хохирогчийг өөртөө итгэх итгэл, эргэн тойрноо ойлгох ойлголтугүй болгох, байнгын найдвар төрүүлэх, өөрөөс нь өөр хэн ч тусалж, хамгаалж чадахгүй гэсэн ойлголтыг бий болгодог.
- » Урьдчилан таамаглах боломжгүй нөхцөлийг бий болгох -хохирогчийг тогтворгүй болгох, ямарваа зүйлийг төлөвлөх боломжийг хаах эсвэл тэдний ертөнцийг үзэх үзэл, амьдралын хэв маягийг өөрчилж зөвхөн хариу өгөх, өөрийгөө хамгаалж амь гарах арга барилтай болгох, хайр сэтгэлтэй дүр үзүүлдэг.
- » Шийдвэр гаргах эрх мэдэлгүй болгох – хүний сайн сайхан байдал, амь гарах эсэх нь “эзэн”-ээс шалтгаална, “эзэн”-ий үгэнд орж түүнийг сэтгэл хангалуун байхаас шалтгаална гэсэн ойлголтыг төрүүлэх, буруу алхам хийвэл одоо байгаагаасаа нөхцөл байдал дордоно гэж итгүүлдэг.
- » Сэтгэл хөдлөлийг нь хянах – гэмт үйлдлийнхээ эерэг талуудыг харуулахыг оролдох ба хохирогчид хийж буй ажил нь гэр бүлдээ туслах боломж гэсэн ойлголт төрүүлэх, мөрөөдлөө биелүүлэхэд тусалж, ирээдүйд илүү сайхан амьдарна гэсэн тэдний хүлээлтийг бий болгодог.
- » Хуулийн байгууллага, цагаачлалын албаар сүрдүүлэх – хэрэв оргох, эсэргүүцэх байдал үүсгэвэл хууль, хяналтын байгууллагад хандсанаар энд байгаагаас илүү аймшигтай нөхцөлд орно, хуулийн байгууллага бидний талд ажилладаг, танил тал ихтэй гэж итгүүлдэг.

¹² Хамтын бүтээл, Өмгөөлөгчдөд зориулсан гарын авлага /хүн худалдаалах, бэлгийн хүчирхийлэл, хүчиндэх гэмт хэрэг/, УБ., 2019

- » Мансуурах бодис хэрэглүүлэх – архи, согтууруулах ундаа, мансууруулах, сэтгэцэд нөлөөт эм, бэлдмэлийг хүчээр хэрэглүүлдэг.
- » Эрүүл мэндийн эрсдэлд оруулах – үйлчлүүлэгч хүсвэл хамгаалалтгүй бэлгийн харьцаанд оруулах, сарын тэмдгийг хүчээр зогсоох, жирэмслэлтийг хүчээр зогсоох, ураг зулбуулах, бэлгийн болон бусад халдварт өвчтэй болгодог.

Хүчирхийллийн эдгээр олон аргуудыг хэрэглэж байгаагийн гол зорилго нь хохирогчийг өөрөөсөө хамааралтай болгож, бие хүн гэсэн сэтгэлгээг устгаж, хэн ч надад тусалж чадахгүй, энэ л миний хувь тавилан, энэ хүн л надад тусална, өөр гарц байхгүй гэсэн сэтгэлгээг суулгаснаар бусадтай харилцах холбоог үгүй болгодог.

Хүний наймааны хохирогчийг “амь насаа алдахуйц” нөхцөл байдалд оруулж эсэргүүцвэл үхэлтэй нүүр тулна гэдгийг хүчээр ойлгуулдаг. Хохирогч өөрийн аюулгүй байдлын төлөө юу ч хийж чадахгүй, зөвхөн “эзэн” бүхнийг хянаж байна гэсэн ойлголтыг төрүүлнэ.

Дараа нь “Бие махбодийн цээрлэл”-ийг үзүүлнэ. Хохирогчийг уртасгасан цагаар, чөлөөт цаггүй, амралтгүй, байнгын дарамтан дор ажиллуулж “эзэн”-ий бүрэн хяналтад байна гэдгийг ойлгуулдаг. Ямарч амралтгүй ажилласан хохирогч ядарч туйлдан, өөрийгөө хамгаалах төлөвлөгөө зохиох чадваргүй болох ба зөвхөн хүний өгсөн тушаалыг биелүүлж, дарамт зодуурыг хүлээн зөвшөөрдөг.

Эцэст нь хохирогчийг өөрөөсөө бүрэн хамааралтай болгож, хяналтыг гартаа аван, ганцаардуулан тусгаарлах явдал юм. Тухайн нөхцөлд хохирогч зөвхөн “эзэн”, “зуучлагч”-тай харьцдагаас гадаад орчин болон өөрийнхөө нөхцөл байдлыг зөвхөн тэдний хэлж ярьснаар төсөөлж эхэлдэг. Ингэснээр хохирогч гэмт хэрэгтний эрхшээл, хяналтанд бүрэн ордог.

2.6. ХҮН ХУДАЛДААЛАХ ГЭМТ ХЭРЭГ БА ХОХИРОГЧИЙН ХАМААРАЛ

Хүн худалдаалах гэмт хэргийг илрүүлэх, таслан зогсооход Хүн худалдаалах гэмт хэргийн хохирогчийг зарим тохиолдолд хүн худалдаалах гэмт хэрэгт хамтран оролцуулж ихэнх тохиолдолд элсүүлэгч, зуучлагчийн үүргийг гүйцэтгүүлдэг. Ингэснээр хүн

худалдаалах гэмт хэргийн хохирогч нь хүчээр болон хууран мэхлэгдэж, сайн дураараа уг гэмт хэрэгт хамтран оролцогч болдог¹³.

ХХГХ-ийн хохирогч гэмт хэрэгт өөрийн хүсэлтээр сайн дураараа оролцох тохиолдлууд:

- » Хохирогчийг худалдан авч мөлжих зорилгоор ашиглаж буй этгээдийн хараа хяналтаас гарч суллагдах боломж гарч магадгүй гэсэн найдвар
- » Хууль бусаар ирсэн тухайн улсдаа цагдаа, цагаачлалын алба, хууль сахиулах байгууллагад мэдэгдэлгүйгээр үлдэх гэсэн оролдлого
- » Худалдагдсан улс орныхоо хэл, ёс заншил, газар орны байршлыг мэдэхгүйн улмаас гэмт хэрэгт хамтран оролцохоос өөр аргагүй болсон
- » Хохирогчийн гадаад пасдорт, бусад баримт бичгийг барьцаалсан, хурааж авсан тохиолдолд түүнийгээ олж авахын тулд
- » Хохирогч нь биеийн эрүүл мэндийн байдал, түүнчлэн амьдралын нөхцөл, ар гэрийн байдлаасаа шалтгаалан “эзэн”-ий тавьж буй бүхий л шаардлагыг үг дуугүй биелүүлэхээс өөр гарцгүй болсон.
- » “Эзэн”-ий хуурамч амлалтад итгэдэг. Амлалт нь харилцан адилгүй, хэн нэгнийг элсүүлж өөрийгөө суллах, өөрт нь хайр сэтгэлтэй мэт сэтгэгдэл төрүүлэх, хамтран ажиллаж хувь хүртэх санал тавих зэрэг ямар ч агуулгатай байж болзошгүй.

2.7. ХХГХ-ИЙН ХОХИРОГЧ ГЭМТ ХЭРЭГТ ХҮЧЭЭР ОРОЛЦОХ ТОХИОЛДЛУУД:

- » Хохирогч болон түүний гэр бүлийн гишүүдийн амь нас, эрүүл мэндэд аюул учруулахаар заналхийлэх, учруулах, хэрэв гэр бүлдээ эргэж очвол бүгдийх нь амь насыг хорооно гэж итгүүлэх
- » Хууль бусаар хил нэвтэрсэн, хуурамч бичиг баримт ашигласан, биеэ үнэлсэн, хар тамхи, мансууруулах бодис хэрэглэсэн, хадгалсан гэх зэрэг гэмт хэргийн шинжтэй үйлдлүүдийг нь баримтжуулан хуулийн байгууллагад мэдээлнэ гэж сүрдүүлэх,

¹³ Мөн тэнд

- » “Эзэн”-ийхээ хүссэн үйлдлийг хийгээгүй тохиолдолд хүч хэрэглэх, хүчирхийлэл үйлдэх, ажлын хэт их ачаалал өгөх, хэт олон цагаар амралтгүй ажиллуулах, хоол ундыг хязгаарлах гм дарамт үзүүлэх
- » Хохирогчийн бие махбод, сэтгэл зүйг зөвхөн өөрөөсөө хамааралтай болгож удирдах (хар тамхи, мансууруулах бодис, согтууруулах ундаанд донтуулах зэргээр)
- » Сэтгэл санааны гутралд оруулах, өөрийнх нь хийж буй ажлын бичлэгийг үзүүлэн дарамтлах, цахим орчноор тараана гэж сүрдүүлэх, зөвхөн “эзэн” л бүх зүйлийг зохицуулж чадна гэсэн бодлыг суулгаж, хохирогчийг өөрийгөө удирдах, шийдвэр гаргах чадваргүй байдалд хүргэх,
- » Нийгэм болон хүрээлэн байгаа орчноос тусгаарлан ганцаардуулах, хэн ч чамд туслахгүй, хууль хяналтын байгууллагыг бүгдийг худалдан авсан, миний талд үйлчилнэ гэсэн ойлголтыг бий болгосон байдаг. Мөн хэн нэгэнтэй холбогдвол сургууль, гэр бүл, албан газарт чинь биеэ үнэлэгч гэж хэлнэ, эсвэл холбоо тогтоосон хамаатан садан, найз нөхдийгөө элсүүлж ирэхийг шаардах зэргээр бусадтай холбоо барих боломжийг нь хязгаарлаж байдаг.

Хүн худалдаалах гэмт хэргийн хохирогч нь уг гэмт хэргийн улмаас хохирох явцдаа хууль бусаар хил нэвтрэх, хуурамч баримт бичиг үйлдэх, ашиглах, хар тамхи мансууруулах бодис хадгалах, хэрэглэх зэрэг Эрүүгийн хуульд заасан гэмт хэргийн шинжтэй үйлдэлд холбогдсон байх тохиолдол элбэг байдаг. Гэвч өнөөгийн эрүүгийн эрх зүйн зохицуулалтаар ийнхүү хохирох явцдаа үйлдсэн нийгмийн хор аюулаар бага гэмт хэрэгт нь хүлээлгэх эрүүгийн хариуцлагаас чөлөөлөх үндэслэл, нөхцөл байдал хууль тогтоомжид заагдсан байдгийг мэддэггүйгээс гэмт хэрэгтэн болохоос эмээж, аль болох хууль, хяналтын байгууллагаас тойрч явахыг эрмэлздэг.

Хүн худалдаалах гэмт хэргийн хохирогч гэдэг нь хүн, ялангуяа эмэгтэйчүүд, хүүхдүүдийг худалдаалахаас урьдчилан сэргийлэх, таслан зогсоох, шийтгэх тухай Протоколд тусгагдсанаар 'хүн худалдаалах' гэмт хэрэгт өртсөн этгээдийг хэлнэ. Хүн худалдаалах гэмт хэргийн хохирогчдыг тодорхойлж чадаагүйгээс мөлжлөгт өртсөн хэвэндээ байж, авах ёстой тусламж, хамгаалалтаа авч чадахгүйгээс гадна гэмт хэрэгтнүүдийг шүүхэд шилжүүлэхэд шаардлагатай мэдээлэл, нотлох баримт цуглуулж чадахгүйд хүрдэг. Иймээс хохирогчийг илрүүлэн таньж мэдэх нь энэ төрлийн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, гэмт хэрэг үйлдсэн, гэм буруутай этгээдүүдийг яллах, хохирогчдод нэн шаардлагатай туслалцаа үзүүлэх, тэдний аюулгүй байдлыг хамгаалах үйл явцын чухал хэсэг юм.

Салбар бүрийн албан хаагч, мэргэжилтнүүд хүн худалдаалах гэмт хэргийн талаар хууль тогтоомжид хэрхэн тодорхойлсныг ойлгож мэдсэнээр, мөлжлөгийн янз бүрийн хэлбэрүүдэд өртсөн байж болзошгүй хохирогчид болон тэдгээрээс хүн худалдаалах гэмт хэргийн хохирогчдыг олж илрүүлэх магадлал өндөр байдаг.

Хүн худалдаалах гэмт хэргийн хохирогчийг таних нь угтаа маш хэцүү тул энэхүү гарын авлагад хэн нэг хүнийг энэ төрлийн гэмт хэргийн хохирогч мөн эсэхийг тогтоох босгыг багаар тогтоож өгөх нь тохиромжтой гэж тооцсон ба энэ нь албан хаагч, мэргэжилтнүүд болзошгүй хохирогчтой холбоо тогтоох нэн чухал үйл ажиллагаа юм. Хохирогч болсон хэн нэгэн тогтоогдвол түүнд зохих туслалцаа, хамгаалалтыг хууль, журмын дагуу үзүүлэх учиртай.

Хууль сахиулах, хил хамгаалах, гадаадын иргэн, харъяат, нийгмийн хамгаалал, хүүхэд хамгаалал, мэргэжлийн хяналт зэрэг төрийн анхан шатны нэгжийн эрх бүхий албан хаагч, мэргэжилтнүүд үүнд зохих ёсоор бэлтгэгдсэн байх ёстой бөгөөд хохирогч бүрийн хувийн зан төлөв болон тэдгээрийн хувийн нууцыг хүндэтгэж чадахуйц шаардлагатай мэргэжлийн ур чадвартай байх ёстой.

3.1. ЦАГДААГИЙН АЛБАН ХААГЧ ХҮН ХУДАЛДААЛАХ ГЭМТ ХЭРГИЙН ХОХИРОГЧИЙГ ИЛРҮҮЛЭХ, ТАНИХ

Эрх зүйн зохицуулалт

Цагдаагийн албаны тухай хууль

10 дугаар зүйл. Гэмт хэрэгтэй тэмцэх

10.1.Цагдаагийн байгууллага гэмт хэрэгтэй тэмцэх чиг үүргийн хүрээнд дараахь бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

10.1.1.гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, гэмт хэрэг гарсан шалтгаан, нөхцөлийг тогтоох, арилгуулах;

10.1.2.гэмт хэрэг үйлдэхээр бэлтгэж, завдаж байгаа тухай мэдээллийг хүлээж авах, бүртгэх, олзлох, цуглуулах, олж авмагц таслан зогсоох, учирч болох хор хохирлыг гаргуулахгүй, нэмэгдүүлэхгүй байх арга хэмжээ авах, гэмт хэргийг илрүүлэх;

10.1.3.гэмт хэрэг гарсан тухай мэдээллийг хүлээн авмагц гэмт хэргийн газрыг хамгаалах, үзлэг хийх, нотлох баримт илрүүлэх, бэхжүүлэх, цуглуулах, гэмт этгээдийг олж тогтоох, эрэн сурвалжлах, баривчлах;

10.1.4.хуулиар харьяалуулсан гэмт хэрэгт хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалт явуулах;

10.1.5.хууль тогтоомжид заасан үндэслэл, журмын дагуу гүйцэтгэх ажил явуулах;

10.1.6.гүйцэтгэх ажил явуулах эрх бүхий бусад байгууллагатай хамтран ажиллах;

10.1.7.хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалт, шүүхээс оргон зайлсан сэжигтэн, яллагдагч, шүүгдэгч, гэмт хэрэг үйлдсэнд эсрдэгдсэн хүнийг эрэн сурвалжлах, баривчлах;

10.1.8.Гэрч, хохирогчийг хамгаалах тухай хуульд заасны дагуу гэрч, хохирогчийг хамгаалах;

Хүн худалдаалахтай тэмцэх тухай хууль

5 дугаар зүйл. Хүн худалдаалахтай тэмцэх талаарх төрийн байгууллагын бүрэн эрх

5.7.Цагдаагийн болон тагнуулын байгууллага нь хүн худалдаалах үйлдлийг илрүүлэх, таслан зогсоох чиг үүргийг хэрэгжүүлж, хүн худалдаалахтай холбоотой зар сурталчилгаанд хяналт тавина.

Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль

29 дүгээр зүйл. Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх талаар хууль сахиулах болон төрийн хяналт шалгалтын байгууллагын үүрэг

29.1. Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх талаар хууль сахиулах болон төрийн хяналт шалгалтын байгууллага дараах үүрэг хүлээнэ:

29.1.1. гэмт хэрэг, зөрчлийн шалтгаан, нөхцөлийг илрүүлэх, дүн шинжилгээ хийх, түүнийг арилгах;

29.1.2. гэмт хэрэг, зөрчил үйлдэж болзошгүй этгээдийг тогтоох, урьдчилан сэргийлэх бүртгэлд хамруулах;

29.1.3. гэмт хэрэг, зөрчил үйлдэхээр бэлтгэж байгаа этгээдийг олж илрүүлэх, гэмт хэрэг, зөрчлийг таслан зогсоох;

29.1.8. хариуцсан нутаг дэвсгэр, чиг үүргийн хүрээнд гэмт хэрэг, зөрчлийн нөхцөл байдалд дүн шинжилгээ тогтмол хийх;

Гэрч, хохирогчийг хамгаалах тухай хууль

3 дугаар зүйл. Гэрч, хохирогчийг хамгаалах үйл ажиллагааны зарчим

3.1. Гэрч, хохирогчийг хамгаалах үйл ажиллагаанд Монгол Улсын Үндсэн хуульд заасан зарчмаас гадна дараах үндсэн зарчмыг баримтална:

3.1.1. хүний хууль ёсны ашиг сонирхлыг хүндэтгэх;

3.1.2. нууцлалыг хамгаалах;

3.1.3. шуурхай байх;

3.1.4. хамтран ажиллах.

3.2. Гэрч, хохирогчийг хамгаалах үйл ажиллагаа нь хамгаалалтад байгаа хүний амьд явах эрх, итгэл үнэмшилтэй байх, шашин шүтэх, эс шүтэх эрх чөлөө, түүнчлэн эрүү шүүлт тулгах болон хүнлэг бус, хэрцгий хандах явдлаас ангид байх, эрүүл, аюулгүй орчинд амьдрах, эрүүл мэндээ хамгаалуулах эрхийг хязгаарлахгүй.

3.3. Хамгаалалтад байгаа хүн мэдээллээр хангагдах, мэдээлэл задрахаас хамгаалагдах, өмч болон ажлын байраа хадгалуулах эрхтэй.

Садар самуун явдалтай тэмцэх тухай хууль

4 дүгээр зүйл. Биеэ үнэлэх, бусдын биеийг үнэлүүлэхийг хориглох

4.1. Биеэ үнэлэхийг хориглоно.

4.2. Бусдын биеийг үнэлүүлэхийг хориглоно.

5 дугаар зүйл. Садар самууныг сурталчлахыг хориглох

5.1. Хэвлэл, мэдээллийн хэрэгслээр садар самууныг сурталчлахыг хориглоно.

5.2. Садар самууныг сурталчилсан хэвлэл, ном зохиол, зураг, кино, дүрс бичлэг, бусад зүйлийг бэлтгэх, тараах, борлуулах, энэ зорилгоор хадгалахыг хориглоно.

ХҮН ХУДАЛДААЛАХ ГЭМТ ХЭРГИЙН ХОХИРОГЧИЙГ ТАНЫЖ, ИЛРҮҮЛЭХ АСУУЛТ

Нэг. Суурь үзүүлэлт

Суурь үзүүлэлт нь хүн худалдаалах гэмт хэрэгт өртөх эрсдэлтэй этгээдийн талаарх ерөнхий мэдээллийг цуглуулахад чиглэгдэх ба тухайн этгээд хохирсон эсэхийг тодорхойлохгүй юм.

НАС

Зөвлөмж: /хүүхэд/:

Хүүхдийн эрхийн конвенцын 1 дүгээр хэсгийн 1 дүгээр зүйлд “18 нас хүрээгүй хүн бүрийг хүүхэд гэнэ” хэмээн тодорхойлсон бол Хүүхдийн эрхийн тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1 дэх хэсэгт “Хүүхдийг төрсөн цагаас нь эхлэн 18 насанд хүртэлх эрхийг нь хангахад энэ хууль үйлчилнэ” гэж тодорхойлсон¹⁴. Үүнээс үзвэл тухайн хүнийг 18 нас хүрсэн өдөр хүртэлх хугацааг хүүхэд гэж үзэх бөгөөд энэ нь аливаа нөхцөл байдлыг зөвөөр үнэлж дүгнэхэд чухал ач холбогдолтой. Учир нь Монгол Улсын Эрүүгийн хуулийн 13.1 дүгээр зүйлд заасан Хүн худалдаалах гэмт хэргийг хүүхдийн эсрэг үйлдсэнд тооцоход мөн хуульд заасан аргаар үйлдсэн байхыг шаардахгүй байх зохицуулалт тусгагдсан.

Иймээс ярилцагч нь тухайн хүн нь насанд хүрсэн, хүрээгүй эсэхийг тогтоох нь аливаа гэмт хэргийн зүйлчлэл хийгээд

¹⁴ Хүүхдийн эрхийн тухай хууль, УБ.,2016.

хүлээлгэх хариуцлагад ач холбогдолтойг сайн мэдэж байх нь чухал юм.

Иргэншил

Зөвлөмж:

Гадаадын иргэн, харьяалалгүй хүн нь хэлний мэдлэгээс шалтгаалан эмзэг байдал нь нэмэгдэх бөгөөд энэ нь ажил олгогчийн дарангуйлал, хяналтанд орох нөхцөлийг бүрдүүлдэг.

Ажил эрхлэлт

Зөвлөмж: Эрсдэлтэй байж болзошгүй иргэн нь одоо эсхүл өмнө нь хэн нэгний зүгээс санал болгосон ажил хөдөлмөр эрхэлж байсан эсэх, хэрэв хөдөлмөр эрхэлж байсан бол ажил олгогчтой хөдөлмөрийн гэрээ байгуулсан эсэх, ажил олгогч нь тухайн иргэний бичиг баримтыг хураан авсан эсэх, анх тохиролцсоноос өөр ажил үйлчилгээ хийхийг санал болгосон, шаардсан, тулгасан эсэх, ажил олгогчийн зүгээс тухайн иргэнийг ажил эрхлэлттэй нь холбоотойгоор хууран мэхэлсэн, айлган сүрдүүлсэн, хүч хэрэглэсэн, хүч хэрэглэхээр заналхийлж байсан эсэх, ажлын байрнаас өөрийн дураар чөлөөтэй гарч орох боломжтой эсэхийг тодруулна.

Өр зээл

Зөвлөмж: Тухайн иргэн нь ажил олгогчдоо эсхүл өөр бусад хүнд өр, зээлтэй эсэх, өр, зээлтэй бол тухайн хүний дарамт шахалтанд орж байсан эсэхийг тодруулна.

Цалин хөлс

Зөвлөмж: Нэмэгдэл цалин хөлс олгохгүйгээр илүү цагаар ажиллуулж байсан эсэх, ямар нэгэн шалтгаангүйгээр хөдөлмөрийн цалин хөлснөөс суутгал шимтгэл авч байсан эсэхийг тодруулна.

Хоёр. Үндсэн үзүүлэлт

Зөвлөмж:

- » Ярилцлага хийж буй албан хаагч нь дор тавигдсан асуултаас гадна харилцагчийн яриа, бусад нөхцөл байдал, өөрийн мэдрэмжээр асуултаудыг нарийвчлан тодруулах замаар хохирогч мөн эсэхийг тогтоохыг зорих,
- » Хүний наймаа, бэлгийн мөлжлөгийн хохирогчид болж өнгөрсөн үйл явдлын талаар олон удаагийн давтамжтай

- ярих нь сэтгэл зүйн дарамтад орох эрсдэлийг бий болгож байдгийг анхаарах,
- » Ярилцлагын явцад хүний наймааны хохирогч, биеэ үнэлэгч, мөлжлөгт өртөгч гэх мэт үгсийг аль болох ашиглахаас татгалзах,
 - » Хохирогч төвтэй хандлагатай, хүний эрхийн мэдрэмжтэй байж, ярилцлагын асуултыг аль болох ойлгомжтой байдлаар тайлбарлаж өгөх замаар тодорхой хариулт авахыг зорих.

Ярилцагчид тавигдаж буй асуултууд, түүнд хариулж буй байдалд логик байгаа эсэх, үнэн эсхүл худал ярьж байгааг мэдэрэх хэрэгтэй.

Ярилцлагын явцад өөр бусад хохирогч болсон эсхүл хохирогч байх магадлалтай хүмүүсийн талаарх мэдээлэл гарвал түүнийг тусгайлан тэмдэглэж, олж тогтооход анхаарах нь зүйтэй.

Биеэ үнэлэх, биеийг нь үнэлүүлэхтэй холбоотой нөхцөл байдлыг тодорхойлох:

- ***Та хэзээнээс биеэ үнэлж эхэлсэн бэ? Таныг биеэ үнэлэхэд хэн нэгэн татан оруулсан уу?/цаг хугацаа, явц, хэн татаж оруулсан, таних эсэх/***

Зөвлөмж: Биеэ үнэлэх ажлыг хэдий чинээ урт хугацаагаар хийсэн байна төдий чинээгээр эрх нь зөрчигдөх эрсдэл өндөр байдаг. Мөн өр зээл, амьжиргааны түвшин, эдийн засгийн эмзэг байдал нь биеэ үнэлэх замыг сонгоход нөлөөлсөн байдаг тул бие махбод болон бусад төрлийн хохирол амссан ч биеэ үнэлэхээс тийм амархан татгалзаж чадахгүй болсон байдгийг ярилцагч анхаарах хэрэгтэй. Өөрөөр хэлбэл энэ ажил нь амьдралынх нь эх үүсвэр болсон байдаг нь эрх нь зөрчигдсөн ч түүнийг үл хайхран ажиллах эрсдэлийг бий болгодог. Эрх нь зөрчигдөж байгаа талаар хэн нэгэнд, ялангуяа хууль сахиулах байгууллагад мэдэгдэхийг хүсдэггүй юм.

- ***Та биеэ үнэлнэ гэдгээ мэдэж байсан уу?***

Зөвлөмж: Монгол Улсын нэгдэн орсон Үндэстэн дамнасан зохион байгуулалттай гэмт хэргийн эсрэг НҮБ-ын конвенцын нэмэлт болох “Хүн, ялангуяа эмэгтэйчүүд, хүүхдийг худалдаалахаас урьдчилан сэргийлэх, таслан зогсоох, шийтгэх

тухай” протоколд “хүний наймааны хохирогч өөрийг нь мөлжиж ашиг олох гэж байгааг зөвшөөрснийг хэрэгсэхгүй” гэж, Монгол Улсын Эрүүгийн хуулийн 13.1 дүгээр зүйлийн тайлбарт “Энэ гэмт хэргийг үйлдсэнд тооцоход хохирогч өөрийг нь хүч хэрэглэж, хүч хэрэглэхээр заналхийлж, хулгайлж, хууран мэхэлж, итгэл эвдэж, эрх мэдлээ урвуулан ашиглаж, эмзэг байдлыг нь далимдуулж, эсхүл хяналтдаа байлгаж байгаа хүнд төлбөр төлж, хахуульдаж хүнийг эрхшээлдээ оруулах зэрэг аргаар хохироож байгааг өөрөө зөвшөөрсөн эсэх нь гэмт хэргийн зүйлчлэлд нөлөөлөхгүй” гэжээ. Өөрөөр хэлбэл хохирогч биеэ үнэлнэ гэдгээ мэдэж байсан эсэх нь хүний наймааны гэмт хэргийг үгүйсгэх нөхцөл болохгүй гэдгийг анхаарах хэрэгтэй.

- Та биеэ үнэлэх талаар мэдээгүй байсан бол хэрхэн биеэ үнэлэх болсон бэ?

Зөвлөмж: Биеэ үнэлэх нөхцөл байдлыг урьдчилан таамаглах боломжгүй нөхцөлд байсны улмаас жинхэнэ хийх ажлынхаа талаар хожуу мэдэж, татгалзах тохиолдолд ажил олгогч буюу гэмт хэрэг үйлдэгчийн зүгээс ихэвчлэн хүч хэрэглэх, хүч хэрэглэхээр заналхийлэх, гэр бүлийн болон ойр тойрны хүмүүст аюул занал учруулна гэж сүрдүүлэх үйлдэл гаргадаг. Ийнхүү сонголтгүй болсон хохирогч биеэ үнэлэхээс өөр аргагүй болсноо мэдэрч, биеэ үнэлсэн тохиолдол их бий. Түүнчлэн хохирогчийг гадаад улсад эсхүл дотоодод тээвэрлэсэн, орон байраар хангасан төлбөр тооцож, тухайн өр төлбөрөө биеэ үнэлж барагдуулах сонголтгүй сонголтыг тулган шаарддаг байна. Иймээс ярилцлага хийгч ийм нөхцөл байдлыг анхаарах хэрэгтэй юм.

Бэлгийн мөлжлөгтэй холбоотой нөхцөл байдлыг тодорхойлох:

- Биеэ үнэлэх явцдаа хэн нэгний /хамтран ажилладаг, худалдан авагч гэх мэт/ дарамт, хүчирхийлэлд орж байсан уу? Эсвэл бусад биеэ үнэлэгч ийм байдалд орж байсан талаар сонссон зүйл бий юу?

Зөвлөмж: Хүчирхийлэл бол хамгийн энгийн хэрнээ үр дүнтэй хяналтын хэрэгсэл юм. Хүчирхийлэл нь дан ганц бие махбодийн хүчирхийллээр хязгаарлагдахгүй гэдгийг анхаарах хэрэгтэй. Хэдийгээр хууль ёсны утгаар хүчирхийлэлд орохгүй

ч, хэл ярианы, сэтгэл зүйн хүчирхийлэл нь нөхцөл байдлаас хамаараад бие махбодийн хүчирхийллээс ч илүү үр дүнтэй хяналтын хэрэгсэл болдог. Хэл ярианы болон сэтгэлзүйн хүчирхийлэл нь хохирогчийг хүчгүй, сул болгож, ажил олгогч эзнээс хамааралтай болгодог. Энэ мэт байдлаас болоод заримдаа хохирогч ажил олгогч эзнээ хамгаалан өмөөрөх хандлага ч үзүүлдэг. Тэгэхээр ажил олгогч эсхүл үйлчлүүлэгч хохирогчоор бэлгийн ажлаас өөр зүйл хийлгэх, ёс бусаар бэлгийн дур хүслээ хангах сэдлээр хүчирхийллийн ямар арга хэрэгсэл ашиглаж байсныг тогтоох нь чухал болохыг тооцох учиртай. Хэрэвзээ өөрт нь ийм зүйл тохиолдоогүй бол таньж мэддэг өөр бусад хүмүүст ийм нөхцөл байсан эсэхийг тогтоон хохирогч болох магадлалтай хүмүүсийг тогтоох нь зүйтэй.

- ***Таныг биеэ үнэлдэг гэдгийг олон нийтийн сүлжээгээр эсвэл өөр бусад байдлаар бусдад тараана, мэдэгдэнэ гэж айлган сүрдүүлж байсан уу?***

Зөвлөмж: Хохирогчдын хамгийн их амсдаг сэтгэл зүйн хүчирхийллийн нэг хэлбэр нь тэднийг биеэ үнэлдэг гэж нийгмийн сүлжээ болон бусад байдлаар тарааж, нэр хүндийг нь гутаан доромжилно гэх сүрдүүлэг юм. Хэдий тэд өөрсдийн санаачлагаар бус бусдын албадлага, ятгалгаар биеэ үнэлж буй ч нийгэмд тийм гэдгийг хүлээн зөвшөөрдөггүй байдал нь хохирогчдыг ийм дарамт хүчирхийлэлд өртөхөд нөлөөлдөг. Өөрөөр хэлбэл тухайн хохирогчийн биеийн аль нэг хэсэг эсхүл бүтэн биеийн нүцгэн зураг, бэлгийн харьцаанд орж байх үеийн зураг бичлэг гэх мэтийг нийгмийн сүлжээнд байршуулах, гэр бүлийн гишүүд, найз нөхөд рүү илгээх гэх мэт үйлдэл гаргах эсхүл ийм үйлдэл гаргана гэж сүрдүүлдэг. Ийм сүрдүүлгээс айж, өөрийн, гэр бүлийн нэр хүнд, үнэт зүйлсийг хамгаалахын тулд хүчирхийллийн хохирогч болохыг хүлээн зөвшөөрдөг гэдгийг бодох хэрэгтэй.

- ***Таны биеийг үнэлүүлдэг этгээдийн зүгээс хууль сахиулах, шүүх эрх мэдлийн байгууллагын ажилтнуудтай дотно харилцаатай талаараа ярьж байсан уу?***

Зөвлөмж: Хохирогчид учирч болох дараагийн нэг хүчирхийлэл эь ажил олгогч буюу эзэн нь “би хууль, шүүхийн байгууллагын дарга, удирдлагуудыг танина. Чи энэ талаар ямар ч гомдол гаргасан чи өөрөө л хохирно уу гэхээс би хохирохгүй,

харин ч чамайг шоронд явуулж чадна” гэх мэтээр айлган сүрдүүлэх явдал юм. Энэ байдлаа нотлохын тулд хууль, шүүхийн байгууллагын хэн нэгэн хүнтэй уулзаж байгаа талаар харуулах, гэрэ зураг үзүүлэх гэх мэт нотолгоог хийдэг нь хохирогчид өөр ямар ч боломж байхгүй мэт сэтгэгдлийг төрүүлдэг байна. Мөн ийм байдал нь хохирогчийн хууль хяналтын байгууллагад итгэх итгэлийг үгүй хийж, ажил олгогч эзний хий гэсэн бүхнийг хийхээс өөр гарц байхгүй гэдэгт бат итгүүлдэг.

Ярилцагч нь хохирогчид ийм нөхцөл байгаа эсэхийг тогтоож, хэрэв ийм байдал байвал худлаа болохыг ойлгуулах, асуудлыг хууль хяналтын байгууллагаар шийдүүлэх зөвлөгөөг өгч болно.

- ***Монгол Улсын хуулиар биеэ үнэлсэн хүн ч мөн хариуцлага хүлээдэг гэж айлган сүрдүүлж, явуулж буй хууль бус ажиллагаагаа нуух, энэ талаар мэдээллэх боломжийг хязгаарлаж байсан уу?***

Зөвлөмж: Биеэ үнэлэлттэй холбоотой Монгол Улсад хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа Садар самуун явдалтай тэмцэх тухай, Зөрчлийн тухай, Эрүүгийн хуулийн талаарх буруу ойлголтыг хохирогчид өгөх, хохирогч өөрөө энэ хуулиар хариуцлага хүлээх, цаашлаад шоронд ч орж магадгүй, иймээс энд болж буй үйл явдлын талаар хаана ч, хэнд ч хэлж болохгүй, ингэвэл чи л өөрөө хохирно гэж хохирогчийг сүрдүүлэх нь хүчирхийллийн мөн нэг хэлбэр нь юм. Үүнийг илүү ойлгуулахын “чи илүү ял шийтгэлтэй шүү” гэдгийг ой тойнд нь шингэтэл ойлгуулах явдлаар илэрнэ.

Иймээс ярилцагч нь хуулийн зохицуулалтын талаар үнэн зөв мэдээлэл өгч, хэн нэгний хүчирхийлэл, дарамтад биеэ үнэлж байсан бол хохирогч болж, эрхээ хамгаалуулдаг гэдгийг сайтар зөвлөх хэрэгтэй.

- ***Ажил олгогчийн зүгээс таны зургийг авах, бэлгийн харилцааны үеийн болон тийм шинжтэй үйлдлийн бичлэгийг хийдэг байсан уу?***

Зөвлөмж: Хохирогчийн бүтэн биеийн нүцгэн болон аль нэг хэсгийн, тухайлбал хөх, өгзөг, бэлэг эрхтэн, нуруу, хүзүү, нүүр гэх мэт хэсгийн зургийг авах, бэлгийн ажлын үеийн гэрэл зураг авах, дүрс бичлэг хийх байдлаар дарамт учруулдаг. Үүнийгээ ашиглан хохирогчид ямар нэгэн дарамт учруулах, дээр дурдсанаар нийтэд түгээх, гэр бүл, найз нөхөд рүү илгээнэ

хэмээн айлган сүрдүүлэх явдал байдаг. Хохирогч ажил олгогчийн зүгээс шаардсан ажил үйлчилгээг үзүүлэхгүй тохиолдолд ийнхүү бэлдсэн гэрэл зураг, дүрс бичлэгийг ашиглан дарамт учруулдаг байна. Ийн гэрэл зураг авах, дүрс бичлэг хийх нь бэлгийн хүчирхийллийн хэлбэр мөн тул ярилцагч нь энэ асуудлыг орхигдуулахгүй байх хэрэгтэй.

Хянан харгалзах болон дарамт шахалттай холбоотой нөхцөлийг тодорхойлох:

- ***Амьдарч байсан орон байрнаасаа чөлөөтэй гарч орох боломжтой байсан уу? Хэрэв боломжгүй байсан бол ямар нөхцөл байдал байсан бэ? Хэний зөвшөөрлөөр гадагш гарах боломжтой байсан бэ? Амьдарч байсан орон байрны чинь гадна болон дотор талд хяналтын камер байсан уу?***

Зөвлөмж: Хохирогчийн зорчих эрхийг хязгаарлах шинж бол бэлгийн мөлжлөгийг бие даасан биеэ үнэлэлтээс ялгах нэг шинж гэж үздэг. Өөрөөр хэлбэл хохирогчийг тодорхой орон байранд байрлуулж, тэндээс гарахгүй байх, гарсан ч тодорхой хяналттайгаар гарах нөхцөл байдлыг бий болгодог. Энэ үйл ажиллагааг биечлэн хүнээр гүйцэлдүүлэхээс гадна орчин цагт технологийн шийдэл ашиглаж байна. Тухайлбал хохирогчийн амьдарч буй болон ажил хийх өрөө тасалгааны гадна дотор талд 24 цагийн хяналтын камер суурилуулж, үйл хөдөлгөөн бүрийг хянаж байна. Хохирогчийг ийнхүү хорио бүхий нөхцөл байдалд байлгах нь сэтгэл зүйн дарамтад оруулж, хэзээ ч ийм нөхцөл байдлаас гарахгүй гэсэн бат бодлыг бий болгож, улмаар ажил олгогчийн хүссэн бүхнийг гүйцэлдүүлэх нөхцөлийг бий болгодог.

Гэхдээ зорчих эрхийг хязгаарлана гэдэг нь ганцхан орон байранд хяналттай байлгах замаар өөр газарт очих боломжгүй байлгах гэсэн үг биш бөгөөд тухайн ажил олгогч этгээдийн хүссэн үед, дуудсан газар цагт нь заавал очих нөхцөл байдлыг мөн хамааруулж ойлгох нь зөв юм.

Ярилцагч нь хохирогчоос тухайн орон байрны нөхцөл байдал, цонх, хаалганы талаарх дэлгэрэнгүй мэдээлэл, орох, гарах хөдөлгөөний хяналт, зөвшөөрөл, гадуур явах үеийн хяналтын талаар дэлгэрэнгүй тодруулахыг зорино. Хяналтын

системийг ажил олгогчоос гадна бусад хохирогчид бие биеэ хянаж буй байдлыг тодорхойлох нь мөн чухал юм.

- ***Амьдарч байсан орон байрны цонх эсхүл хаалганд хаалт байсан уу? Гадна орчин үл харагдах өнгөөр будсан, өөр бусад зүйлсээр битүүлсэн байсан уу?***

Зөвлөмж: Хорионоос болоод биеэ үнэлэх хүч хэрэглэснээс гал гарах зэрэг яаралтай нөхцөл байдал үүсэн тохиолдолд гаднаас тусламж авах боломжгүй гэдгийг харгалзан үзэх хэрэгтэй. Харанхуй, хаалттай орчинд урт хугацаагаар байх нь гансрах зэрэг сэтгэл зүйн хувьд хохирол амсах шалтгаан болох төдийгүй, тогтворгүй сэтгэл зүйн байдлын шалтгаан болдог. Дээрээс нь цоожтой гарц болон хагалж байж л гарч болох бүтэц нь мөн л хохирлын шалтгаан болдог гэдгийг таньж мэдэх шаардлагатай.

- ***Ажил олгогч, үйлчлүүлэгчийн хий гэсэн ажлыг үл хийх нь таныг ямар нөхцөл байдалд оруулдаг байсан бэ?***

Зөвлөмж: Бараг бүх хохирогч л ажил олгогч эсхүл үйлчлүүлэгчийнхээ хий гэсэн зүйлийг хийгээгүйн төлөө бие махбодын, хэл ярианы, сэтгэл зүйн хүчтэй хүчирхийлэл амсдаг. Угаас бэлгийн хүчирхийлэл нь үл хүсэх зүйлийг хүч хэрэглэх, хүч хэрэглэхээр заналхийлэх замаар үйлдэгддэг учир ийм байдал түгээмэл ажиглагдана. Дээрээс нь хохирогчийн хүсэл зоригоос үл хамааран бэлгийн хүчирхийлэлд оруулах, бэлгийн дур хүслээ ёс бусаар хангах эсхүл бүр өөр төрлийн гэмт хэрэг үйлдэхэд нөлөөлдөг.

Иймээс ярилцагч нь хохирогчид ийм зүйл тохиолдсон эсэхийг тогтоохоос гадна хэрэв ийм үйлдлийг үл хийсэн тохиолдолд хохирогчид ямар хохирол учирдаг, ямар нөхцөл байдалд хүргэдэг байсныг тодруулах хэрэгтэй.

- ***Ажил олгогчийн зүгээс бэлгийн хүчирхийлэл үйлдэж байсан уу?***

Зөвлөмж: Ажил олгогч өөрсдийн хэрэгцээг хангахын тулд, хохирогчийн хүсэл зоригийн эсрэг бэлгийн харилцаанд орохыг шаардах тохиолдол байдаг. Энэ нь хохирогчийн бэлгийн халдашгүй байдалд халдахаас гадна сэтгэл зүйн, бие махбодын хүчтэй дарамт болж байдаг. Түүнчлэн шинээр авч ирсэн хохирогчдын бэлгийн чадварыг шалгах нэрийдлээр

ийм төрлийн дарамт үзүүлдэг байна. Иймд ярилцагч нь ажил олгогч нь түүнийг хэзээ, ямар нөхцөл байдалд оруулж бэлгийн харилцааны шинжтэй хүч хэрэглэсэн үйлдэлд оруулсан, ийм байдлын улмаас хохирогчид ямар хохирол учирсан талаар дэлгэрэнгүй мэдээлэл авахыг зорих учиртай.

- ***Амралтын өдөр гэж байгаа юу? Байдаг бол хэзээ, хэчнээн цаг амардаг байсан бэ?***

Зөвлөмж: Олонх хохирогчид өдөр бүр 10-12 цаг эсхүл түүнээс ч олон цагаар ажилладаг байсан гэдэг. Гэхдээ энэ нь тогтсон цаг биш бөгөөд тухайн үеийн эрэлт, ажил олгогчийн тавьж буй шаардлага зэргээс хамаарч өөрчлөгдөж болдог байна. Ихэнхдээ амралтын өдөр гэж тусдаа өдөр байдаггүй гэх боловч тодорхой цагт амардаг талаар өгүүлэх нь бий.

Тэгвэл ярилцагч нь хохирогчоос өдөрт хичнээн цаг ажилладаг, 7 хоногийн хэдэн өдөрт нь амардаг, хэрэв амрах өдөр гэж тусдаа байдаггүй бол ядаж өдөрт хэдэн цаг амардаг байсныг тодорхойлох хэрэгтэй. Энэ нь хохирогчийн ямар нөхцөлд ажиллаж байсныг тогтооход бас чухал юм.

- ***Өөрийн хүссэн үедээ энэ ажлыг хийхээс татгалзах боломж байсан уу? Яагаад?***

Зөвлөмж: Хохирогчийг ийм төрлийн ажил эрхлэхээс татгалзах тухайгаа илэрхийлэх үед бие махбодын, хэл ярианы, сэтгэл зүйн хүчирхийлэл учруулдаг. Ялангуяа ажил олгогчоо авсан өр зээл нь түүнийг тухайн ажлыг орхиж явах боломжийг хязгаарлаж байдаг. Өр зээлгүй байсан ч түүний хийж байсан ажлынх нь талаар нийтэд мэдээлнэ нэр хүндэд нь халдана гэх зэргээр айлган сүрдүүлдэг байдал ажиглагдана.

Ярилцагч нь хохирогчид ийм байдал үүссэн эсэх, ийм ажил хийхээс татгалзаж болохгүй байгаа өнөөгийн шалтгааныг нарийн тодруулахыг зорих учиртай.

- ***Хувийн бичиг баримтыг өөртөө байлгах боломж байсан уу?***

Зөвлөмж: Хүний наймааны нэг үндсэн шинж нь тухайн хохирогчийн албан ёсны бичиг баримт өөрт нь байхгүй байх бөгөөд түүний бичиг баримтыг ямар нэгэн шалтгаанаар ажил олгогч хураан авсан байдаг. Энэ нь тухайн хохирогчийг, ялангуяа гадаад хохирогч эсхүл гадаадад хохирогч болсон хүнийг тухайн

улсын нутаг дэвсгэр дээр чөлөөтэй явах боломжийг хязгаарлаж байдаг. Мөн бичиг баримтгүйгээр гадагш гарах нь баривчлагдах нөхцөл болно гэж итгүүлснээр хохирогч байрлаж буй орон байрнаасаа гарах болможгүй болдог байна.

Ярилцагч нь хохирогчийн бичиг баримт өөрт нь байгаагүй бол ямар нөхцөл байдал үүссэний улмаас бичиг баримтаа өөртөө байлгах боломжгүй болсон, үүнээс болж ямар байдалд орсон талаар нь дэлгэрүүлэн судалбал зохино.

Үйлчилгээ авах, хэрэгцээгээ хангах, цалин хөлстэй холбоотой нөхцөл байдлыг тодорхойлох:

- ***Амьдралын наад захын хэрэгцээ болох хоол ундныхаа хэрэгцээгээ хязгаарлуулж байсан тохиолдол бий юу?***

Зөвлөмж: Ажил олгогч нь хохирогчийн эсэргүүцлийг дарах, бусдад сургамж болгох эсхүл хохирогчийн гадаад төрх, хэлбэрийг өөрчлөх зорилгоор амьдралын наад захын хэрэгцээний хоол ундыг багасгах, бүр огт хоол өгөхгүй байх зэрэг үйлдлийг гаргадаг. Энэ нь хохирогчийн хүсэл зоригоос үл хамаараад биеэ үнэлэлтийг хүлээн зөвшөөрүүлэх бас нэгэн хүчирхийллийн хэлбэр юм.

Ярилцагч нь хохирогчийг ийм байдалд орж байсныг тогтоох, хэрэв ийм байдалд орж байсан ямар хугацаанд үргэлжилсэн, хоол ундын хэрэгцээгээр хангах ямар болзол тавьж байсныг тодруулах хэрэгтэй.

- ***Эрүүл мэндийн эмчилгээ, үйлчилгээ авах эрхээ хязгаарлуулж байсан уу?***

Зөвлөмж: Хохирогчийн хийж буй ажил нь эрүүл мэндийг ноцтойгоор хохироох, бие махбодод гэмтэл учруулах, сэтгэл зүйн таагүй нөхцөлийг бий болгодог тул түүнд эмнэлэгийн тусламж зайлшгүй шаардлагатай болно. Гэвч түүнд эрүүл мэндийн тусламж үйлчилгээ авах боломж нөхцөлийг ажил олгогчоос бараг л үзүүлэхгүй байх талтай. Иймээс ярилцагч нь хохирогчид эмнэлгийн ямар тусламж үйлчилгээ авах хэрэгцээ шаардлагатай байсан, тухайн тусламж, үйлчилгээгээ авч чадсан эсэх, чадаагүй бол түүний эрүүл мэндэд одоо ямар хор хохирол учирсныг нарийн тодруулах шаардлагатай болно.

- **Цалин өгдөг үү? Өгдөг бол ямар хэмжээний цалин өгдөг вэ? Цалингаа өгөхгүй байх ямар тохиолдол байсан бэ?**

Зөвлөмж: Анхнаасаа хохирогчид цалин өгөхгүй байх зорилгоо нуун далдалж, цалин өгнө, гэхдээ өдөрт олох орлогын хэмжээг тодорхойлж, хэрэгцээнийхээ төлбөрийг өөрөө даах ёстой гэсэн шаардлагуудыг тавьж, цалин тавих хугацаа болохоор элдэв торгууль алданги, өр төлбөр тооцох байдал байдаг. Иймээс ярилцагч нь хохирогчийн хэдэн төгрөгний цалин авахаар тохиролцсон, хэчнээн төгрөгийн цалин авсан, цалин аваагүй бол ямар шалтгааны улмаас цалин аваагүй, өдөрт хэчнээн төгрөгийн орлого олох шаардлага тавьж байсан, энэ шаардлагад нь хүрч байсан эсэх, хүрч байгаагүй бол торгууль алданги тооцож өр төлбөр тооцдог байсан эсэх зэргийг нарийвчлан асууж тодруулах шаардлагатай. Энэ нь хохирогчийн бэлгийн мөлжлөгийн хохирогч болохыг батлах нэг нөхцөл болно.

- **Үйлчлүүлэгч төлбөрөө төлөхгүй байх нь танд эрсдэл бий болгож байсан уу? Тийм бол ямар эрсдэл үүсэж байсан бэ?**

Зөвлөмж: Биеэ үнэлэх нь хууль бус учраас хохирогчид эрсдэл, хор хохирол учирах нь бараг энгийн шахуу үзэгдэл болсон байдаг. Үйлчлүүлэгч төлбөрөө төлсөн эсэх нь хохирогчид төдий хамааралгүй ч гэсэн төлбөрөө төлөөгүй нь түүнд янз бүрийн дарамтыг учруулсан байдаг. Өөрөөр хэлбэл хохирогчийн үзүүлж буй үйлчилгээ таалагдаагүй, сэтгэлд хүрээгүй, хангалттай таашаал аваагүй, хий гэсэн зүйлсийг нь хийгээгүй зэрэг шалтгаан тоочиж үйлчлүүлэгч төлбөр төлөхөөс татгалзсан эсхүл бага хэмжээний төлбөр төлөх нь хохирогчийг өрөнд оруулах, бие махбодын хүчирхийлэлд өртөх нөхцөл болдог.

Иймээс ярилцагч нь хохирогчид ийм нөхцөл байдал тохиолдож байсан эсэх, хэрэв тийм бол ямар дарамт шахалт учирсныг тодруулах хэрэгтэй.

3.2. ХИЛИЙН ШАЛГАН НЭВТРҮҮЛЭХ АЛБАНЫ АЛБАН ХААГЧ ХҮН ХУДАЛДААЛАХ ГЭМТ ХЭРГИЙН ХОХИРОГЧИЙГ ИЛРҮҮЛЭХ, ТАНИХ

Эрх зүйн зохицуулалт

Монгол Улсын хилийн тухай хууль

16 дугаар зүйл. Улсын хилээр зорчигч, тээврийн хэрэгслийг нэвтрүүлэх

16.1. Улсын хилийг газар, ус, агаараар нэвтрэх зорчигч, тээврийн хэрэгсэл, бараа, мал, амьтан, ургамал, тэдгээрийн гаралтай түүхий эд, бүтээгдэхүүнийг хууль тогтоомж, хилийн асуудлаар байгуулсан Монгол Улсын олон улсын гэрээний дагуу улсын хилээр нэвтрүүлнэ.

17 дугаар зүйл. Улсын хилийн боомт дээр ажиллах хяналт шалгалтын байгууллага

17.1. Зорчигч, тээврийн хэрэгсэл, бараа, мал, амьтан, ургамал, тэдгээрийн гаралтай түүхий эд, бүтээгдэхүүнд хяналт шалгалт хийх зорилгоор хилийн боомтод улсын хил хамгаалах, гааль, мэргэжлийн хяналтын байгууллага, виз бүртгэлийн асуудлыг шийдвэрлэх зорилгоор гадаадын иргэн, харьяатын байгууллага ажиллана.

17.2. Зорчигч, тээврийн хэрэгсэл хилийн боомтод тогтоосон замаар нэвтрэх бөгөөд улсын хил хамгаалах, гааль, мэргэжлийн хяналтын байгууллагын албан хаагчид шалгуулах үүрэгтэй.

17.4. Хилийн хяналтын байгууллагын хяналт шалгалтаар илрүүлсэн гадаадын иргэний виз, бүртгэлийн зөрчлийг гадаадын иргэн, харьяатын байгууллага шийдвэрлэнэ.

17.6. Улсын хил хамгаалах байгууллага нь зорчигчийн улсын хил нэвтрэх эрхийн баримт бичигт тэмдэглэл хийж, улсын хил нэвтэрсэн зорчигч, тээврийн хэрэгслийн бүртгэлийг хөтөлж, нэгдсэн сан байгуулна.

17.7. Эрх бүхий байгууллагаас зорчигчийг улсын хилээр үл нэвтрүүлэх, саатуулах талаар улсын хил хамгаалах байгууллагад зохих журмын дагуу мэдэгдсэн тохиолдолд түүнийг улсын хилээр нэвтрүүлэхгүй.

35 дугаар зүйл. Улсын хил хамгаалах байгууллагын чиг үүрэг

35.1. Улсын хил хамгаалах байгууллага дараахь чиг үүргийг хэрэгжүүлнэ:

35.1.3. хилийн асуудлаар байгуулсан Монгол Улсын олон улсын гэрээгээр хүлээсэн үүргийг хэрэгжүүлж, улсын хилийн дэглэмийг сахиулах;

35.1.6. улсын хилээр зорчигч, тээврийн хэрэгслийг шалган нэвтрүүлэх, хилийн боомтын аюулгүй байдлыг хангах, хилийн боомтод мөрдөх журмыг сахиулах;

35.1.8. хил дамнасан гэмт хэргийг илрүүлэх, таслан зогсоох;

36 дугаар зүйл. Улсын хил хамгаалах байгууллагын бүрэн эрх

36.1. Улсын хил хамгаалах байгууллага дараахь бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

36.1.4. хилийн боомтоор зорчигч, тээврийн хэрэгслийг улсын хил нэвтрүүлэхдээ баримт бичгийг шалгах, тэмдэглэл хийх, зөрчилтэй баримт бичгийг хураан авч холбогдох байгууллагад шилжүүлэх;

36.1.5. улсын хилээр нэвтэрч байгаа тээврийн хэрэгсэлд хил зөрчигчийг илрүүлэх зорилгоор үзлэг хийх явцад илэрсэн улсын хилээр нэвтрүүлэхийг хориглосон зүйлийг хураан авч, холбогдох байгууллагад шилжүүлэх;

36.1.9. хилийн төлөөлөгч, орлогч, туслагч нь улсын хилийн болон хил орчмын дэглэм зөрчсөн этгээдийг шалгах зорилгоор зургаан цагаас илүүгүй хугацаагаар түр саатуулах, зөрчил гаргасан этгээдийн баримт бичгийг шалгах, түүний өмчлөлд, эсхүл эзэмшилд байгаа эд зүйл, биед үзлэг хийх, эд зүйл, баримт бичгийг түр хугацаагаар хураан авах, битүүмжлэх, согтууруулах ундаа, мансууруулах, сэтгэцэд нөлөөлөх бодис хэрэглэсэн эсэхийг шалгах, гэмт хэргийг таслан зогсоох, гэмт этгээдийг мөрдөх үед байгууллага, иргэний орон байранд нэвтрэн орох, түр саатуулагдсан этгээдийн эд зүйл, биед үзлэг хийсэн, эд зүйл, баримт бичгийг хураан авсан тохиолдол бүрд хуульд заасны дагуу тэмдэглэл үйлдэх;

36.1.11. улсын хилийн болон хил орчмын дэглэмийг сахиулах, улсын хилээр зорчигч, тээврийн хэрэгслийг нэвтрүүлэх журамд хяналт тавихын тулд зайлшгүй шаардлагатай бүртгэл хөтлөх;

Хүн худалдаалахтай тэмцэх тухай хууль

5 дугаар зүйл. Хүн худалдаалахтай тэмцэх талаарх төрийн байгууллагын бүрэн эрх

5.8. Хүн худалдаалахтай тэмцэх талаар улсын хил хамгаалах байгууллага дараах чиг үүргийг хэрэгжүүлнэ:

5.8.1. Монгол Улсын хилээр нэвтэрч байгаа хүүхдийн биеийн байцаалтыг тодруулах, итгэмжлэлийн үндсэн дээр бусдын хүүхдийг харгалзан яваа этгээдийн биеийн байцаалт, ямар зорилгоор хүүхдийг дагуулан явж байгаа, тухайн хүүхэдтэй ямар холбоотой болох, хүлээн авагч гадаад улс, иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын талаарх дэлгэрэнгүй мэдээллийг шалгаж нягтлах;

5.8.2. итгэмжлэлийн үндсэн дээр гадаад улсад зорчиж байгаа хүүхэд тухайн улсад удаан хугацаагаар сурах, амьдрах тохиолдолд хүлээн авах этгээдийн талаарх мэдээллийг нягтлах;

5.8.3. улсын хилээр хамт гарсан насанд хүрээгүй хүнийг хилийн гадна үлдээсэн тохиолдолд эргэж ирээгүй шалтгааныг нь тодруулах, шаардлагатай гэж үзвэл тухайн асуудлыг цагдаагийн байгууллагад шалгуулахаар шилжүүлэх.

Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль

27 дугаар зүйл. Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх талаар төрийн байгууллагын үүрэг

27.1. Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх талаар бүх шатны төрийн байгууллага энэ хуулийн 30.1-д зааснаас гадна дараах үүрэг хүлээнэ:

27.1.1. хариуцсан чиг үүрэг, эрх хэмжээнийхээ хүрээнд хууль тогтоомжийг олон нийтэд таниулах, иргэдэд хуулийг сахин биелүүлэх дадал бий болгоход чиглэсэн цогц арга хэмжээг авч хэрэгжүүлэх;

27.1.2. хуульд заасан эрх хэмжээний хүрээнд гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх талаар бусад байгууллагад дэмжлэг үзүүлэх, харилцан мэдээлэл солилцох, хамтран ажиллах;

27.1.3. эрхлэх асуудлынхаа хүрээнд гэмт хэрэг, зөрчилтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх арга хэмжээг боловсруулж, хэрэгжүүлэх, холбогдох хууль тогтоомжийг мэдээлэх, сурталчлах, сургалт зохион байгуулах;

27.1.4. эрхэлсэн асуудлынхаа хүрээнд гэмт хэрэг, зөрчил гарч байгаа шалтгаан, нөхцөл, гэмт хэрэг, зөрчил үйлдэгдэхэд нөлөөлж байгаа хүчин зүйлсийг тогтоож, түүнийг арилгах тухай мэдэгдэл хүргүүлэх, биелэлтэд хяналт тавих;

ХҮН ХУДАЛДААЛАХ ГЭМТ ХЭРГИЙН ХОХИРОГЧИЙГ ТАНЬЖ, ИЛРҮҮЛЭХ АСУУЛТ

Нэг. Суурь үзүүлэлт

Суурь үзүүлэлт нь хүн худалдаалах гэмт хэрэгт өртөх эрсдэлтэй этгээдийн талаарх ерөнхий мэдээллийг цуглуулахад чиглэгдэх ба тухайн этгээд хохирсон эсэхийг тодорхойлохгүй юм.

НАС

Зөвлөмж: /хүүхэд/:

Хүүхдийн эрхийн конвенцын 1 дүгээр хэсгийн 1 дүгээр зүйлд “18 нас хүрээгүй хүн бүрийг хүүхэд гэнэ” хэмээн тодорхойлсон бол Хүүхдийн эрхийн тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1 дэх хэсэгт “Хүүхдийг төрсөн цагаас нь эхлэн 18 насанд хүртэлх эрхийг нь хангахад энэ хууль үйлчилнэ” гэж тодорхойлсон¹⁵. Үүнээс үзвэл тухайн хүнийг 18 нас хүрсэн өдөр хүртэлх хугацааг хүүхэд гэж үзэх бөгөөд энэ нь аливаа нөхцөл байдлыг зөвөөр үнэлж дүгнэхэд чухал ач холбогдолтой. Учир нь Монгол Улсын Эрүүгийн хуулийн 13.1 дүгээр зүйлд заасан Хүн худалдаалах гэмт хэргийг хүүхдийн эсрэг үйлдсэнд тооцоход мөн хуульд заасан аргаар үйлдсэн байхыг шаардахгүй байх зохицуулалт тусгагдсан.

Иймээс ярилцагч нь тухайн хүн нь насанд хүрсэн, хүрээгүй эсэхийг тогтоох нь аливаа гэмт хэргийн зүйлчлэл хийгээд хүлээлгэх хариуцлагад ач холбогдолтойг сайн мэдэж байх нь чухал юм.

Иргэншил

Зөвлөмж:

Гадаадын иргэн, харьяалалгүй хүн нь хэлний мэдлэгээс шалтгаалан эмзэг байдал нь нэмэгдэх бөгөөд энэ нь ажил олгогчийн дарангуйлал, хяналтанд орох нөхцөлийг бүрдүүлдэг.

¹⁵ Хүүхдийн эрхийн тухай хууль, УБ., 2016.

Ажил эрхлэлт

Зөвлөмж: Эрсдэлтэй байж болзошгүй иргэн нь одоо эсхүл өмнө нь хэн нэгний зүгээс санал болгосон ажил хөдөлмөр эрхэлж байсан эсэх, хэрэв хөдөлмөр эрхэлж байсан бол ажил олгогчтой хөдөлмөрийн гэрээ байгуулсан эсэх, ажил олгогч нь тухайн иргэний бичиг баримтыг хураан авсан эсэх, анх тохиролцсоноос өөр ажил үйлчилгээ хийхийг санал болгосон, шаардсан, тулгасан эсэх, ажил олгогчийн зүгээс тухайн иргэнийг ажил эрхлэлттэй нь холбоотойгоор хууран мэхэлсэн, айлган сүрдүүлсэн, хүч хэрэглэсэн, хүч хэрэглэхээр заналхийлж байсан эсэх, ажлын байрнаас өөрийн дураар чөлөөтэй гарч орох боломжтой эсэхийг тодруулна.

Хоёр. Үндсэн үзүүлэлт

Зөвлөмж:

- » Албан хаагч нь дор тавигдсан асуултаас гадна харилцагчийн яриа, бусад нөхцөл байдал, өөрийн мэдрэмжээр асуултуудыг нарийвчлан тодруулах замаар хохирогч мөн эсэхийг тогтоохыг зорих,
- » Хүний наймаа, бэлгийн мөлжлөгийн хохирогчид болж өнгөрсөн үйл явдлын талаар олон удаагийн давтамжтай ярих нь сэтгэл зүйн дарамтад орох эрсдэлийг бий болгож байдгийг анхаарах,
- » Ярилцлагын явцад хүний наймааны хохирогч, биеэ үнэлэгч, мөлжлөгт өртөгч гэх мэт үгсийг аль болох ашиглахаас татгалзах,
- » Хохирогч төвтэй хандлагатай, хүний эрхийн мэдрэмжтэй байж, ярилцлагын асуултыг аль болох ойлгомжтой байдлаар тайлбарлаж өгөх замаар тодорхой хариулт авахыг зорих.

Ярилцагчид тавигдаж буй асуултууд, түүнд хариулж буй байдалд логик байгаа эсэх, үнэн эсхүл худал ярьж байгааг мэдрэх хэрэгтэй.

Ярилцлагын явцад өөр бусад хохирогч болсон эсхүл хохирогч байх магадлалтай хүмүүсийн талаарх мэдээлэл гарвал түүнийг тусгайлан тэмдэглэж, олж тогтооход анхаарах нь зүйтэй.

Шалган нэвтрүүлэх албаны ажилтан нь тухайн этгээдийг хүн худалдаалах гэмт хэргийн хохирогч болсон байж магадгүй гэх

үндэслэл байвал нутаг дэвсгэрийн цагдаагийн байгууллага эсхүл тагнуулын байгууллагын эрх бүхий албан тушаалтанд хандаж, шуурхай арга хэмжээг авна.

– **Та ямар ажлаар гадаад улс руу зорчих гэж байгаа вэ?**

Зөвлөмж: Гадаад улс руу гарах гэж этгээд нь өөрийн ямар ажлаар зорчихоо хэлэхгүй байх, энэ талаар асуухад эгдүүцэх, уурлах, бухимдах, айх, сандрах зэрэг сэтгэл зүйн таагүй байдлыг үзүүлж, хэвийн байдлаасаа өөр биеийн хэлэмж үзүүлж болзошгүй байдгийг анхаарах хэрэгтэй.

- **Та хаанаас /аль аймаг, хот/ ирсэн бэ?**

Зөвлөмж: Хэрэв гадаад улс руу зорчиж буй этгээдийн аль аймаг, хотоос хилийн бүс, нутагт ирж гадаад улс руу зорих гэж байгааг тодруулах.

- **Та өөрийн ургийн овог, эцэг /эх/-ийн нэр, өөрийн нэр, регистрийн дугаарыг хэлнэ үү?**

Зөвлөмж: Нүүрний хэлбэр, төрх ижил хүмүүсийн гадаад паспорт бусад бичиг баримтыг ашиглан хохирогчийг гадаад улс руу гаргадаг тохиолдол байдаг тул түүнээс хувийн мэдээллийг нь баталгаажуулж тодруулах хэрэгтэй.

- **Та гадаад паспортоо хэзээ авч байсан бэ?**

Зөвлөмж: Хүн худалдаалах гэмт хэргийн хохирогчийг гадаад улсад гаргах зорилгоор түүний бичиг баримтыг өмнөөс нь хөөцөлдөж авах, хуурамч бичиг баримт бүрдүүлэх зэрэг нөхцөл байдал үүсдэгийг анхаарах

- **Таны бусад бичиг баримтууд таны биед байна уу? Байгаа бол үзүүлнэ үү?**

Зөвлөмж: Тухайн хүний гадаад паспорт болон холбогдох бусад бичиг баримтууд биед нь байгаа эсэхийг тодруулж, шалгах хэрэгтэй.

- **Та хэн нэгэн хүнтэй хамт явж байгаа юу?**

- » Хэрэв тийм бол хэнтэй хамт явж байгаа вэ?
- » Тантай ямар хамааралтай хүн бэ?
- » Та өмнө нь тухайн хүнтэй хамт гадаад улсыг зорьж байсан уу?
- » Та 2 хаанаас /аль аймаг, хот/ ирсэн бэ?

Зөвлөмж: Хүн худалдаалах гэмт хэргийн хохирогч байж болзошгүй этгээд нь ганцаараа эсхүл өөр бусад хүмүүстэй явж байж болох тул хэнтэй явж байгаа, тухайн хамт явж байгаа хүнээ таних эсэх, таньдаг бол хэн гэдэг, ямар харилцаа холбоотой, таньдаггүй бол яагаад хамт явж байгаа зэрэг нөхцөл байдлуудыг тогтооход асуултаа чиглүүлж нарийвчилж тодруулна.

– ***Та очих гэж буй тухайн улсдаа байгаа Элчин сайдын яам, Консулын газрын талаарх мэдээллийг мэдэх үү?***

Зөвлөмж: Хэрвээ ямар нэгэн асуудал үүсэж, хууль ёсны ашиг сонирхол нь хөндөгдвөл хандах газрын мэдээллийг тухайн хүнд өгөх нь зүйтэй.

Хөдөлмөр эрхлэлттэй холбоотой мэдээллийг тодруулах

– ***Таныг хэн нэгэн гадаад улсад ямар нэгэн ажилд зуучилж байгаа юу?***

» Хэрэв тийм бол аль улсад ажиллахаар явж байгаа вэ?

Тайлбар: Хүн худалдаалах гэмт хэргийн хохирогчийг гадаад ажилд зуучлах нэрийдлээр гаргах тохиолдол их байдаг тул энэ асуултыг нарийвчилж тодруулах зайлшгүй шаардлагатай юм.

– ***Тантай ажил гүйцэтгэх эсвэл хөдөлмөрийн гэрээ байгуулсан уу? Тийм бол түүнийгээ үзүүлнэ үү?***

Зөвлөмж: Ажиллах хүч гадаадад гаргах, гадаадаас ажиллах хүч, мэргэжилтэн авах тухай хуулийн

5.1 дүгээр зүйлд Аж ахуйн нэгж, байгууллага, иргэн /цаашид “байгууллага” гэх/ нь үндэсний ажиллах хүчний мэдлэг, мэргэжил, мэргэшлийн ур чадварыг ахиулах, хөдөлмөр эрхлүүлэх зорилгоор гадаадын аж ахуйн нэгж, байгууллагад Монгол Улсын иргэнийг хөдөлмөрийн гэрээгээр ажиллуулах, үйлдвэрлэлийн дадлага хийлгэх, мэргэжил эзэмшүүлэх гэрээ байгуулж болно. Энэхүү гэрээ нь энэ талаархи олон улсын эрх зүйн хэм хэмжээ, хоёр улсын хооронд байгуулсан гэрээ, тухайн орнуудын хууль тогтоомжид нийцсэн байвал зохино.

5.2. Ажиллах хүч гадаадад гаргах гэрээнд гадаадад ажиллах иргэний хөдөлмөрийн харилцаа, нийгмийн хамгааллын асуудалтай холбогдсон гэрээний нөхцөлийг ажиллах хүч авч байгаа орны хууль тогтоомжид заасан хэм хэмжээнээс дордуулахгүйгээр тусгасан байна.

5.3. Ажиллах хүч гадаадад гаргах тухай гэрээнд дараах нөхцөлийг тодорхой тусгана:

5.3.1. хөдөлмөрийн гэрээгээр ажиллах улс, хот, байгууллагын нэр;

5.3.2. ажил, мэргэжлийн чиглэл, гүйцэтгэх ажил, албан тушаал, ажиллах хүчний тоо;

5.3.3. гэрээний хугацаа, гэрээ дуусгавар болох, түүнийг цуцлах нөхцөл;

5.3.4. ажиллагчдын хөдөлмөрийн хөлсний доод хэмжээ;

5.3.5. хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, эрүүл ахуй, хөдөлмөрийн нөхцөл, ажил, амралтын цагийн горим;

5.3.6. орон сууц, нийгэм, ахуйн хангамжийн асуудал;

5.3.7. гэрээг хэрэгжүүлэхтэй холбогдон үүсэх маргаан болон хөдөлмөрийн маргааныг шийдвэрлэх арга, хэлбэр;

5.3.8. нийгмийн болон эрүүл мэндийн даатгал, тэтгэвэр, тэтгэмж, бусад хөнгөлөлт;

5.3.9. очих, буцах замын зардал, тээврийн нөхцөл;

5.3.10. цалин хөлс, хууль ёсны бусад орлогыг тухайн орноос гуйвуулах боломж зэргийг тусгана гэснийг анхаарах.

- ***Таныг ажилд зуучилсан хүн эсвэл байгууллага хөдөлмөр зуучлалын албан ёсны зөвшөөрөлтэй байсан уу?***

Зөвлөмж: Ажиллах хүч гадаадад гаргах, гадаадаас ажиллах хүч, мэргэжилтэн авах тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1 дэх хэсэгт Ажиллах хүч гадаадад гаргах үйл ажиллагааг хөдөлмөрийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаас олгосон Монгол Улсын иргэдийг гадаадад хөдөлмөр эрхлэхэд зуучлах тусгай зөвшөөрөл бүхий аж ахуйн нэгж, байгууллага, иргэн эрхэлнэ.

6.2. Зуучлах зөвшөөрлийг хөдөлмөрийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн олгоно. Зуучлах зөвшөөрлийн гэрчилгээ нь ялгагдах онцлог тэмдэг, улсын нэгдсэн дугаар бүхий албан ёсны баримт байх бөгөөд хөдөлмөрийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүнээр баталгаажигдсан байна. Гэрчилгээнд тухайн байгууллагын болон ажиллах хүч авах улсын нэр, зуучлах зөвшөөрөл олгосон шийдвэрийн дугаар, зөвшөөрлийн хүчинтэй байх хугацааг заана гэснийг анхаарах.

- ***Та гадаад улс руу зорчих зардлаа өөрөө гаргаж байгаа юу?***

- » Хэрэв та өөрөө зардлаа гаргаагүй бол таныг зардлыг хэн хариуцаж байгаа вэ?
- » Энэ талаар гэрээнд тусгасан зүйл бий юу?

Зөвлөмж: Ажиллах хүч гадаадад гаргах, гадаадаас ажиллах хүч, мэргэжилтэн авах тухай хуулийн 5.3 дугаар зүйлд Ажиллах хүч гадаадад гаргах тухай гэрээнд очих, буцах замын зардал, тээврийн нөхцлийн талаар зааж өгнө гэснийг анхаарах.

- ***Та гадаад улс руу ямар хугацаагаар явж байгаа вэ?***

Зөвлөмж: Тухайн этгээдийн гадаад улс руу зорчих хугацаа нь визтэй бол визний хугацаандаа ирэх эсэх, визгүй бол визгүй зорчих хугацаанд багтаж ирэхийг тогтоохоос гадна визний мэдээллээ өөрөө бүрэн мэдэж байгаа эсэхийг анхаарах хэрэгтэй.

Суралцахтай холбоотой асуудлыг тодруулах

- ***Та суралцахаар явж буй сургуулийнхаа талаар хаанаас мэдээлэл авсан бэ?***

- » Танд сургуулийн талаар мэдээлэл өгсөн хүн тантай хамт явж байгаа юу?

Зөвлөмж: Гадаад улсын ямар сургуульд, ямар мэргэжлээр суралцах гэж байгааг тодруулах нь тухайн хүний үнэн зөв мэдээлэл өгч байгааг тоорхойлж болох юм. Мөн тухайн сургуулийнхаа талаар огт мэдээлэлгүй байх нь зорчигчийг эрсдэлтэй гэж үзэх нэг үндэслэл болохыг анхаарах хэрэгтэй.

- ***Танд тухайн суралцах сургууль болон сургалтыг зуучилсан байгууллага нь албан ёсны зөвшөөрөлтэй байсан уу?***

- » Та гадаадад суралцахтай холбоотой гэрээ байгуулсан уу?
- » Таныг гадаад улсад очиж суралцахтай холбоотой сургалтын төлбөрөөс бусад зардлыг хэн хариуцаж байгаа вэ?
- » Таны сургалтын төлбөрийг хэн хариуцаж байгаа вэ?

Зөвлөмж: Дээд боловсролын санхүүжилт, суралцагчдын нийгмийн баталгааны тухай хууль, Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2013 оны “Дэлхийн шилдэг их сургуульд оюутан суралцуулах тухай” 78 дугаар зарлиг, Монгол Улсын Засгийн Газрын 2012

оны “Журам батлах тухай” 19 дүгээр тогтоолоор батлагдсан “Дээд боловсролын сургалтын байгууллагад суралцагчид сургалтын төлбөрийн болон амьжиргааны зардлын зээл олгох журам”, 2013 оны “Журам шинэчлэн батлах, журамд өөрчлөлт оруулах тухай” 271 дүгээр тогтоолоор батлагдсан “Дэлхийн шилдэг их сургуульд оюутан суралцуулах журам”, Монгол Улсын Засгийн Газрын 2014 оны “Журам, чиглэл шинэчлэн батлах тухай” 71 дүгээр тогтоол, зэрэг эрх зүйн баримт бичигт заасан шаардлага, шалгуур хангагдсан эсэхийг тогтоох, эсхүл ямар нэгэн зөвшөөрөлгүй аж ахуйн нэгж, байгууллага, хувь хүнээр дамжуулан зуучлуулсан эсэхийг тодорхойлох.

3.3. ЭРҮҮЛ МЭНДИЙН БАЙГУУЛЛАГЫН АЛБАН ХААГЧ ХҮН ХУДАЛДААЛАХ ГЭМТ ХЭРГИЙН ХОХИРОГЧИЙГ ИЛРҮҮЛЭХ, ТАНИХ

Эрх зүйн зохицуулалт

Эрүүл мэндийн тухай хууль

13 дугаар зүйл. Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний төрөл

13.1. Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ дараах төрөлтэй байна:

13.1.1. нийгмийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ;

13.1.2. эмнэлгийн тусламж, үйлчилгээ.

13.2. Нийгмийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээнд хүн амын эрүүл мэндийн байдал, түүнд нөлөөлөх хүчин зүйлийг тандах, судлах, хянах, эрүүл мэндийг дэмжих, хамгаалах, өвчин, эмгэгээс урьдчилан сэргийлэх, хүн амд эрүүл мэндийн боловсрол олгох үйл ажиллагаа хамаарна.

13.4. Эмнэлгийн тусламж, үйлчилгээ нь өрхийн эрүүл мэндийн, эмнэлгийн мэргэшсэн, эх барихын, эмнэлгийн яаралтай, сувилахуйн дагнасан, түргэн тусламжийн, сэргээн засахын гэсэн төрөлтэй байна.

28 дугаар зүйл. Эмнэлгийн мэргэжилтний эрх, үүрэг

28.4. Эмнэлгийн мэргэжилтэн дараах үүрэг хүлээнэ:

28.4.1. эмнэлгийн мэргэжилтний ёс зүйн хэм хэмжээг

биелүүлж, хүнлэг, энэрэнгүй үзлийг эрхэмлэн, мэргэжлээ хүний эрүүл мэндийн эсрэг ашиглахгүй байх;

28.4.2. гэнэтийн өвчин, осол, гэмтлээс амь насанд нь аюултай байдал бий болсон иргэн, төрөх гэж байгаа эхэд энэ хуулийн 28.1.3-т зааснаас бусад тохиолдолд эмнэлгийн тусламжийг ямар ч нөхцөлд үзүүлэх;

28.4.3. үйл ажиллагаандаа эрүүл мэндийн тухай хууль тогтоомж, оношлогоо, эмчилгээ, урьдчилан сэргийлэх ажлын стандарт, технологи, эмнэлгийн тусламж, үйлчилгээ үзүүлэх удирдамжийг мөрдөж ажиллах;

28.4.4. хүн амд эрүүл мэндийн боловсрол олгох чиглэлээр сургалт, сурталчилгаа явуулах, эрүүл аж төрөх ёсыг хэвшүүлэхэд дэмжлэг үзүүлэх;

28.4.5. өвчтөний өвчин, эмгэг болон нас барагчийн талаархи хууль тогтоомжоор хориглосноос бусад мэдээллийг холбогдох байгууллага, иргэн, өвчтөний болон нас барагчийн ар гэрийнхэнд өгөх;

28.4.6. мэргэжлийн ур чадвараа байнга дээшлүүлэх;

28.4.7. хууль тогтоомжид заасан бусад үүрэг.

Эмнэлгийн тусламж, үйлчилгээний тухай хууль

22 дугаар зүйл. Мэргэшсэн болон резидент эмчийн эрх, үүрэг

22.1. Мэргэшсэн эмч нь Эрүүл мэндийн тухай хуулийн 28 дугаар зүйлд заасан эмнэлгийн мэргэжилтний эрх, үүргээс гадна дараахь эрх эдэлж, үүрэг хүлээнэ:

22.1.1. үзлэг, шинжилгээ, оношилгоо хийх, зөвлөгөө өгөх, эмчилгээ, мэс засал, ажилбар хийх;

22.1.2. эмийн жор бичих;

22.1.3. нас барсныг тогтоох;

22.1.4. хүйсийг тогтоох;

22.1.5. цэргийн алба хаах, тээврийн хэрэгсэл жолоодох эрх авах, хуульд заасан зарим албан тушаалд томилогдох болон бусад нөхцөлд иргэний эрүүл мэндийн талаар тодорхойлолт гаргах;

22.1.6. шүүх, прокурорын байгууллагын шийдвэрээр эмчийн үзлэг хийх, шинжилгээ авах, эмчилгээ хийх, дүгнэлт гаргах, иргэний эрх зүйн чадамжийг үнэлэх;

22.1.7. өөрийнх нь шууд хяналт, удирдлагад ажиллах резидент эмчийг мэргэжил, арга зүйн удирдлагаар хангах;

22.1.8. оношлох, эмчлэх зорилгоор үйлчлүүлэгчид үзлэг, шинжилгээ, оношилгоо хийх ажлыг резидент эмчээр гүйцэтгүүлж болох бөгөөд энэ тохиолдолд резидент эмчид зөвшөөрөл олгосон шийдвэрийг бичгээр үйлдэж, удирдах албан тушаалтанд мэдэгдэх;

22.1.9. хууль тогтоомжид заасан бусад эрх, үүрэг.

22.2. Резидент эмч нь Эрүүл мэндийн тухай хуулийн 28 дугаар зүйлд заасан эмнэлгийн мэргэжилтний эрх, үүргээс гадна дараахь эрх эдэлж, үүрэг хүлээнэ:

22.2.1. энэ хуулийн 22.2.2, 22.2.3-т заасан ажлыг гүйцэтгэхдээ мэргэшсэн эмчээс арга зүйн туслалцаа авах;

22.2.2. эмнэлгийн удирдах албан тушаалтны баталсан резидент эмчийн бие даан үзүүлэх тусламж, үйлчилгээний жагсаалтын дагуу үйлчлүүлэгчид үзлэг, шинжилгээ, оношилгоо хийх;

22.2.3. мэргэшсэн эмчийн шууд хяналт, удирдлага доор үйлчлүүлэгчид үзлэг, шинжилгээ, оношилгоо, эмчилгээ, мэс засал, ажилбарыг хийх;

22.2.4. энэ хуулийн 22.2.2-т заасан ажлыг гүйцэтгэх явцад аливаа хүндрэл гарсан тохиолдолд мэргэшсэн эмчид цаг алдалгүй мэдэгдэх;

22.2.5. хууль, тогтоомжид заасан бусад эрх, үүрэг.

Хүн худалдаалахтай тэмцэх тухай хууль

5 дугаар зүйл. Хүн худалдаалахтай тэмцэх талаарх төрийн байгууллагын бүрэн эрх

5.5. Хүн худалдаалахтай тэмцэх талаар эрүүл мэндийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

5.5.1. энэ хуулийн 12.1.1, 12.1.2-т заасан үйлчилгээ үзүүлэх журмыг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах, биелэлтэд хяналт тавих;

5.5.2. хохирогчид үйлчилгээ үзүүлэх асуудлаар эмнэлгийн байгууллагын ажилтанд сургалт явуулах.

12 дугаар зүйл. Хохирогчид үзүүлэх халамж, үйлчилгээ

12.1. Хохирогчид дараах халамж, үйлчилгээг үзүүлнэ:

12.1.1. Эрүүл мэндийн нөхөн сэргээх эмчилгээ;

12.1.2. Сэтгэцийн нөхөн сэргээх эмчилгээ;

12.2. Энэ хуулийн 12.1.1, 12.1.2-т заасан үйлчилгээ үзүүлэх журмыг эрүүл мэндийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, ... тус тус батална.

Гэрч, хохирогчийг хамгаалах тухай хууль

3 дугаар зүйл. Гэрч, хохирогчийг хамгаалах үйл ажиллагааны зарчим

3.1. Гэрч, хохирогчийг хамгаалах үйл ажиллагаанд Монгол Улсын Үндсэн хуульд заасан зарчмаас гадна дараах үндсэн зарчмыг баримтална:

3.1.1. хүний хууль ёсны ашиг сонирхлыг хүндэтгэх;

3.1.2. нууцлалыг хамгаалах;

3.1.3. шуурхай байх;

3.1.4. хамтран ажиллах.

3.2. Гэрч, хохирогчийг хамгаалах үйл ажиллагаа нь хамгаалалтад байгаа хүний амьд явах эрх, итгэл үнэмшилтэй байх, шашин шүтэх, эс шүтэх эрх чөлөө, түүнчлэн эрүү шүүлт тулгах болон хүнлэг бус, хэрцгий хандах явдлаас ангид байх, эрүүл, аюулгүй орчинд амьдрах, эрүүл мэндээ хамгаалуулах эрхийг хязгаарлахгүй.

3.3. Хамгаалалтад байгаа хүн мэдээллээр хангагдах, мэдээлэл задрахаас хамгаалагдах, өмч болон ажлын байраа хадгалуулах эрхтэй.

Хүн худалдаалах гэмт хэргийн хохирогчийг таньж, илрүүлэх асуулт

Нэг. Суурь үзүүлэлт

Суурь үзүүлэлт нь хүн худалдаалах гэмт хэрэгт өртөх эрсдэлтэй этгээдийн талаарх ерөнхий мэдээллийг цуглуулахад

чиглэгдэх ба тухайн этгээд хохирсон эсэхийг тодорхойлохгүй юм.

НАС

Зөвлөмж: /хүүхэд/:

Хүүхдийн эрхийн конвенцын 1 дүгээр хэсгийн 1 дүгээр зүйлд “18 нас хүрээгүй хүн бүрийг хүүхэд гэнэ” хэмээн тодорхойлсон бол Хүүхдийн эрхийн тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1 дэх хэсэгт “Хүүхдийг төрсөн цагаас нь эхлэн 18 насанд хүртэлх эрхийг нь хангахад энэ хууль үйлчилнэ” гэж тодорхойлсон¹⁶. Үүнээс үзвэл тухайн хүнийг 18 нас хүрсэн өдөр хүртэлх хугацааг хүүхэд гэж үзэх бөгөөд энэ нь аливаа нөхцөл байдлыг зөвөөр үнэлж дүгнэхэд чухал ач холбогдолтой. Учир нь Монгол Улсын Эрүүгийн хуулийн 13.1 дүгээр зүйлд заасан Хүн худалдаалах гэмт хэргийг хүүхдийн эсрэг үйлдсэнд тооцоход мөн хуульд заасан аргаар үйлдсэн байхыг шаардахгүй байх зохицуулалт тусгагдсан.

Иймээс ярилцагч нь тухайн хүн нь насанд хүрсэн, хүрээгүй эсэхийг тогтоох нь аливаа гэмт хэргийн зүйлчлэл хийгээд хүлээлгэх хариуцлагад ач холбогдолтойг сайн мэдэж байх нь чухал юм.

Хоёр. Үндсэн үзүүлэлт

Зөвлөмж:

- » Эмнэлэгийн мэргэжилтэн нь дор тавигдсан асуултаас гадна харилцагчийн яриа, бусад нөхцөл байдал, өөрийн мэдрэмжээр асуултуудыг нарийвчлан тодруулах замаар хохирогч мөн эсэхийг тогтоохыг зорих,
- » Хүний наймаа, бэлгийн мөлжлөгийн хохирогчид болж өнгөрсөн үйл явдлын талаар олон удаагийн давтамжтай ярих нь сэтгэл зүйн дарамтад орох эрсдэлийг бий болгож байдгийг анхаарах,
- » Ярилцлагын явцад хүний наймааны хохирогч, биеэ үнэлэгч, мөлжлөгт өртөгч гэх мэт үгсийг аль болох ашиглахаас татгалзах,
- » Хохирогч төвтэй хандлагатай, хүний эрхийн мэдрэмжтэй байж, ярилцлагын асуултыг аль болох ойлгомжтой байдлаар тайлбарлаж өгөх замаар тодорхой хариулт авахыг зорих.

¹⁶ Хүүхдийн эрхийн тухай хууль, УБ.,2016.

Ярилцагчид тавигдаж буй асуултууд, түүнд хариулж буй байдалд логик байгаа эсэх, үнэн эсхүл худал ярьж байгааг мэдэрэх хэрэгтэй.

Ярилцлагын явцад өөр бусад хохирогч болсон эсхүл хохирогч байх магадлалтай хүмүүсийн талаарх мэдээлэл гарвал түүнийг тусгайлан тэмдэглэж, олж тогтооход анхаарах нь зүйтэй.

Эмнэлэгийн мэргэжилтэн нь тухайн хүнийг хүн худалдаалах гэмт хэргийн хохирогч болсон байж магадгүй гэх үндэслэл байвал нутаг дэвсгэрийн цагдаагийн байгууллага эсхүл тагнуулын байгууллагын эрх бүхий албан тушаалтанд хандаж, шуурхай арга хэмжээг авна.

- **Таны биед ямар нэгэн зовуурь байна уу?**

- » Хэрэв байгаа бол таны биеийн аль хэсэгт зовуурь байна вэ?
- » Энэ зовиур хэзээнээс бий болсон бэ?

Зөвлөмж: Бэлгийн мөлжлөг, хүн худалдаалах гэмт хэргийн хохирогч нь бие махбод, сэтгэл санааны зовлон шаналал, зовиурыг байнга мэдэрч, хэн нэгнээс хараат байдалд удаан байснаар сэтгэл зүйн гүн хямралд орох зэрэг нөхцөл байдал бий болсон байдаг тул түүнийг нь илрүүлэхэд анхаарах хэрэгтэй. Гэхдээ илрүүлэх гэж байна гээд улам хаагдмал болгох, стрессдүүлэх, сэтгэл зүйн таагүй байдалд оруулахаас урьдчилан сэргийлэх нь чухал.

- **Таны биед үүссэн гэмтэл, сорви, шарх /сонгох/ хэзээ, юунаас болж үүссэн бэ?**

- » Яагаад ийм гэмтэл, шарх, сорвитой болсон бэ?

Зөвлөмж: Бэлгийн мөлжлөгийн хохирогчийн биед ил, далд хэлбэрийн шарх, түүнээс үүссэн сорви үүссэн байх нь элбэг байдаг. Иймээс ярилцагчийн биед үүссэн тухайн шарх, сорвийг хэзээ, ямар шалтгаанаар үүссэн гэдгийг тодруулах зайлшгүй шаардлагатай. Тухайн шарх, сорви нь хурц ир үзүүртэй зүйлээр эсхүл хатуу мохоо зүйлийн үйлчлэлийн алинаар үүссэн болохыг нүдээр хараад ялгах боломжтой тул аль болох яагаад үүссэн гэмтэл, шарх, сорви болохыг тогтоохыг зорих хэрэгтэй.

- **Танд хэн нэгний зүгээс хүчирхийлэл, дарамт, шахалт ирж байсан уу?**

- » Өмнө нь хүчирхийлэл, дарамт, шахалтанд орж байсан уу?

- » Хэрэв орж байсан бол цаг хугацааны хувьд хэзээ ийм зүйл тохиолдсон бэ?

Зөвлөмж: Бэлгийн мөлжлөг, хүн худалдаалах гэмт хэргийн хохирогч нь бусдын эрхшээлд байж, их бага ямар нэгэн дарамт, шахалт, хүчирхийлэлд өртсөн байдаг тул түүнийг илрүүлэх чиглэлд ярилцлагаа оруулах хэрэгтэй. Ингэснээр тухайн хохирогч байж болзошгүй хүнийг хэн хэзээ хэрхэн хүчирхийлэл, дарамт шахалтад оруулж байсныг тогтоох боломжтой болох юм.

- ***Танд цаашид ямар нэгэн тусламж, дэмжлэг хэрэгтэй байна уу?***

Зөвлөмж: Нэгэнт тухайн хүнийг бэлгийн мөлжлөг, хүн худалдаалах гэмт хэргийн хохирогч байж болзошгүй гэж үзсэн бол хуульд заасан эрүүл мэндийн тусламж, үйлчилгээнээс гадна бусад тусламж, үйлчилгээг санал болгох, ийм үйлчилгээ үзүүлдэг байгууллагатай холбон зуучлах боломжтой гэдгийг тайлбарлаж ойлгуулахыг хичээгээрэй.

3.4. НИЙГМИЙН АЖИЛТАН БОЛОН ХҮҮХДИЙН БАЙГУУЛЛАГЫН АЖИЛТАН АЛБАН ХААГЧ ХҮН ХУДАЛДААЛАХ ГЭМТ ХЭРГИЙН ХОХИРОГЧИЙГ ИЛРҮҮЛЭХ, ТАНИХ

Эрх зүйн зохицуулалт

Эрүүгийн хууль

12.3 дугаар зүйл. Бэлгийн мөлжлөг

1. Хохирогчид хүч хэрэглэж, хүч хэрэглэхээр заналхийлж; эд хөрөнгө, албан тушаал, бусад нөхцөл байдлын улмаас эрхшээлдээ байгаа байдлыг далимдуулан зорчих эрхийг хязгаарлахгүйгээр бусадтай бэлгийн харьцаанд албадан оруулсан бол нэг жилээс таван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

2. Энэ гэмт хэргийг хохирогчийн биеийг үнэлүүлж ашиг олох зорилгоор:

2.1. арван дөрвөөс арван найман насанд хүрээгүй хүнийг албадан оруулж;

2.6. байнга тогтвортой үйлдсэн бол хоёр жилээс найман жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

3. Энэ гэмт хэргийн улмаас:

3.2. арван зургаан насанд хүрээгүй хүнийг жирэмсэн болгосон бол таван жилээс арван хоёр жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

4. Энэ гэмт хэргийг хохирогчийн биеийг үнэлүүлж ашиг олох зорилгоор:

4.1. бага насны хүүхдийг албадан оруулж;

4.2. зохион байгуулалттай гэмт бүлэг үйлдсэн бол арван хоёр жилээс хорин жил хүртэл хугацаагаар, эсхүл бүх насаар хорих ял шийтгэнэ.

Тайлбар: -Бага насны хүүхдийн эсрэг энэ гэмт хэргийг үйлдсэнд тооцоход энэ зүйлийн 1 дэх хэсэгт заасан аргаар үйлдсэн байхыг шаардахгүй.

13.1 дүгээр зүйл. Хүн худалдаалах

1. Биеийг нь үнэлүүлэх, бусад хэлбэрээр бэлгийн мөлжлөг, хүчирхийлэлд оруулах, боолчлох, түүнтэй ижил төстэй нөхцөлд байлгах, эд, эрхтнийг авах, албадан хөдөлмөрлүүлж мөлжих зорилгоор хүч хэрэглэж, хүч хэрэглэхээр заналхийлж, хулгайлж, хууран мэхэлж, итгэл эвдэж, эрх мэдлээ урвуулан ашиглаж, эмзэг байдлыг нь далимдуулж, эсхүл хяналтдаа байлгаж байгаа хүнд төлбөр төлж, хахуульдаж хүнийг эрхшээлдээ оруулан элсүүлсэн; тээвэрлэсэн; орогноулсан; дамжуулсан; хүлээн авсан бол хоёр жилээс найман жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

2. Энэ гэмт хэргийг:

2.1. хүүхэд, жирэмсэн эмэгтэйд мэдсээр байж худалдаалсан;

Тайлбар: -Хүүхдийн эсрэг энэ гэмт хэргийг үйлдсэнд тооцоход энэ зүйлийн 1 дэх хэсэгт заасан аргаар үйлдсэн байхыг шаардахгүй.

Хүүхдийн эрхийн тухай хууль

5 дугаар зүйл. Хүүхдийн эсэн мэнд амьдрах эрх

5.2. Хүүхэд эрүүл өсч бойжих, аюулгүй орчинд амьдрах, аливаа хүчирхийллээс ангид байх эрхтэй.

5.3. Хүүхэд эцэг эхтэйгээ амьдрах, тэдний анхаарал халамжид байх, эцэг эхээсээ буюу хэн нэгнээс нь тусдаа амьдрах үед тэдэнтэй байнгын харилцаатай байх, эцэг, эх нь гэрлэлтээ

цуцлуулсан, тусдаа амьдрах үед хэнтэй нь амьдрах тухай үзэл бодол, саналаа илэрхийлэх эрхтэй.

5.4. Хүүхэд төрөөс эмнэлгийн тусламж, тэтгэвэр, тэтгэмж, асрамж, халамж, хамгааллын үйлчилгээ авах эрхтэй.

7 дугаар зүйл. Хүүхдийн хамгаалуулах эрх

7.1. Хүүхэд гэмт хэрэг, зөрчил, хүчирхийлэл, бие махбодийн шийтгэл, сэтгэл санааны дарамт, үл хайхрах байдал болон мөлжлөгийн аливаа хэлбэрээс нийгмийн бүх орчинд хамгаалагдах эрхтэй.

7.2. Эцэг, эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигч хүүхдийн эрхийг нь зөрчсөн тохиолдолд хүүхэд тэдэнтэй хууль ёсны харилцаагаа зохих журмын дагуу зогсоох, таслах, тухайн нөхцөл байдал арилсан тохиолдолд уг харилцаагаа сэргээх эрхтэй.

7.3. Хүүхэд өөрийн нэр төр, гэр бүлийн амьдрал, эрүүл мэнд, хувийн харилцааны нууц, орон байрны халдашгүй байдал, хувийн орон зайгаа хамгаалуулах эрхтэй.

7.4. Хүүхэд эрхээ зөрчигдсөн тохиолдолд өөрөө болон итгэмжит төлөөлөгчөөрөө дамжуулан үндэсний болон олон улсын холбогдох байгууллагад гомдол гаргах, шийдвэрлүүлэх эрхтэй.

14 дүгээр зүйл. Хүүхэд, гэр бүлийн хөгжлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын үүрэг, оролцоо

14.1. Хүүхэд, гэр бүлийн хөгжлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага нь хүүхдийн эрхийг хангах талаар дараахь үндсэн чиг үүргийг хэрэгжүүлнэ:

14.1.1. хүүхдийн эрхийг хангах, хамгаалах талаархи хууль тогтоомж, төрийн бодлого, хөтөлбөрийг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах;

14.1.2. хүүхдийн эрхийг хангах талаархи хууль тогтоомжийн хэрэгжилтэд хяналт тавих;

14.1.4. хүүхдийн эрх зөрчигдөхөөс урьдчилан сэргийлэх, төрийн байгууллага, хуулийн этгээдэд зөвлөгөө өгөх, арга зүйн дэмжлэг үзүүлэх, хуулиар заасан чиг үүргийг хэрэгжүүлэх замаар хяналт тавих;

14.1.6. хүүхдийн эрхийн талаар мэдээллийн сан бүрдүүлж, ашиглах;

15 дугаар зүйл. Хүүхэд, гэр бүлийн хөгжлийн асуудал эрхэлсэн орон нутгийн байгууллагын үүрэг, оролцоо

15.1. Хүүхдийн эрхийг хангах, эрх нь зөрчигдөхөөс урьдчилан сэргийлэх, хүүхэд хамгаалал, хөгжлийн талаар хүүхэд, гэр бүлийн хөгжлийн асуудал эрхэлсэн орон нутгийн байгууллага, ажилтан нь дараахь чиг үүргийг хэрэгжүүлнэ:

15.1.1. тухайн нутаг дэвсгэртээ хэрэгжүүлэх бодлого, хөтөлбөр боловсруулан батлуулж, хэрэгжилтийг зохион байгуулах;

15.1.2. тухайн нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж байгаа байгууллагад хууль тогтоомжийн хүрээнд хяналт тавих;

15.1.3. эрх нь зөрчигдсөн хүүхдийг дагнасан үйлчилгээгээр хангаж, хамгаалах, нөхөн сэргээх, нийгмийн халамж, асрамжийн зэрэг шаардлагатай үйлчилгээнд хамруулах ажлыг зохион байгуулах;

15.1.4. хүүхдийн эрхийг хангах, эрх нь зөрчигдөхөөс урьдчилан сэргийлэх, хүүхэд хамгаалал, хөгжлийн ажлыг гэр бүл, олон нийтийн оролцоо, дэмжлэгт тулгуурлан холбогдох байгууллагатай хамтран зохион байгуулах;

15.1.5. хүүхэд, гэр бүлийн хөгжлийн асуудал эрхэлсэн тухайн шатны байгууллага, ажилтан нь хүүхэд, гэр бүл, эцэг эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигчийг зөвлөгөө, мэдээллээр хангах, шаардлагатай бол сургалт зохион байгуулах, нийгмийн ажилтны үйл ажиллагааг дэмжиж, арга зүйн удирдлагаар хангах;

Хүн худалдаалахтай тэмцэх тухай хууль

5 дугаар зүйл. Хүн худалдаалахтай тэмцэх талаарх төрийн байгууллагын бүрэн эрх

5.11. Хүүхдийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага нь хүн худалдаалахад өртөх эрсдэлтэй хүүхдийг хамгаалах, урьдчилан сэргийлэх үйл ажиллагаа явуулж, сургалт, судалгаа, хяналт шинжилгээ, үнэлгээ хийн улсын хэмжээнд цаашид авах арга хэмжээний санал боловсруулна.

Гэрч, хохирогчийг хамгаалах тухай хууль

3 дугаар зүйл. Гэрч, хохирогчийг хамгаалах үйл ажиллагааны зарчим

3.1. Гэрч, хохирогчийг хамгаалах үйл ажиллагаанд Монгол Улсын Үндсэн хуульд заасан зарчмаас гадна дараах үндсэн зарчмыг баримтална:

3.1.1. хүний хууль ёсны ашиг сонирхлыг хүндэтгэх;

3.1.2. нууцлалыг хамгаалах;

3.1.3. шуурхай байх;

3.1.4. хамтран ажиллах.

3.2. Гэрч, хохирогчийг хамгаалах үйл ажиллагаа нь хамгаалалтад байгаа хүний амьд явах эрх, итгэл үнэмшилтэй байх, шашин шүтэх, эс шүтэх эрх чөлөө, түүнчлэн эрүү шүүлт тулгах болон хүнлэг бус, хэрцгий хандах явдлаас ангид байх, эрүүл, аюулгүй орчинд амьдрах, эрүүл мэндээ хамгаалуулах эрхийг хязгаарлахгүй.

3.3. Хамгаалалтад байгаа хүн мэдээллээр хангагдах, мэдээлэл задрахаас хамгаалагдах, өмч болон ажлын байраа хадгалуулах эрхтэй.

Хүн худалдаалах гэмт хэргийн хохирогчийг таньж, илрүүлэх асуулт

Нэг. Суурь үзүүлэлт

Суурь үзүүлэлт нь хүн худалдаалах гэмт хэрэгт өртөх эрсдэлтэй хүүхдийн талаарх ерөнхий мэдээллийг цуглуулахад чиглэгдэх ба тухайн этгээд хохирсон эсэхийг тодорхойлохгүй юм.

НАС

Зөвлөмж: /хүүхэд/:

Хүүхдийн эрхийн конвенцын 1 дүгээр хэсгийн 1 дүгээр зүйлд “18 нас хүрээгүй хүн бүрийг хүүхэд гэнэ” хэмээн тодорхойлсон бол Хүүхдийн эрхийн тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1 дэх хэсэгт “Хүүхдийг төрсөн цагаас нь эхлэн 18 насанд хүртэлх эрхийг нь хангахад энэ хууль үйлчилнэ” гэж тодорхойлсон¹⁷. Үүнээс үзвэл тухайн хүнийг 18 нас хүрсэн өдөр хүртэлх хугацааг

¹⁷ Хүүхдийн эрхийн тухай хууль, УБ.,2016.

хүүхэд гэж үзэх бөгөөд энэ нь аливаа нөхцөл байдлыг зөвөөр үнэлж дүгнэхэд чухал ач холбогдолтой. Учир нь Монгол Улсын Эрүүгийн хуулийн 13.1 дүгээр зүйлд заасан Хүн худалдаалах гэмт хэргийг хүүхдийн эсрэг үйлдсэнд тооцоход мөн хуульд заасан аргаар үйлдсэн байхыг шаардахгүй байх зохицуулалт тусгагдсан.

Боловсрол

Зөвлөмж: Эрсдэлт нөхцөлд байж болзошгүй хүүхдийн ямар нэг шатны боловсролын байгууллагад суралцдаг эсэх, суралцдаггүй бол учир шалтгааныг тодорхойлох.

Амьдралын нөхцөл байдал

Зөвлөмж: Эрсдэлтэй байж болзошгүй хүүхдийн амьдралын нөхцөл байдал, гэр бүлийн байдал зэргийг тодорхойлох нь яг одоогоор тухайн хүүхэд эрсдэлгүй ч хойшдоо эрсдэл бүхий байдалд орж болзошгүй нөхцөлийг илрүүлэхэд чухал юм.

Хүүхдийг бэлгийн мөлжлөг, хүн худалдаалах гэмт хэргийн хохирогч болсон, болох эрсдэлтэй эсэхийг хавсралт №4-т байгаа асуулгын дагуу явуулах бөгөөд асуулга бөглөх явцдаа ярилцлага хийж, тэмдэглэл үйлдэнэ. Ингэхдээ хүүхдийн сэтгэл зүйн байдлыг мэдэрч, тэднийг сэтгэл зүйн таагүй байдалд оруулахаас урьдчилан сэргийлэх хэрэгтэй.

Хүн худалдаалах гэмт хэргийн хохирогчдод дараах ерөнхий шинж тэмдэг илэрч болно. Үүнд:

- » Хохирогчид заримдаа өөрсдөө хүсээгүй байсан ч хийх үүрэгтэй гэж боддог тохиолдол бий;
- » Тухайн ажлыг өөрийн сайн дураар орхин явах боломжгүй байх, эсхүл хохирогчдод тухайн газрыг өөрийн сайн дураар орхин явж болохгүй гэсэн мэдрэмж төрсөн байх;
- » Хохирогчдын үйлдэл бүрийг хянадаг байж болох шинж тэмдэг ажиглагдах;
- » Хохирогч байнга айдас, түгшүүрийн байдалтай байх;
- » Хохирогч өөрөө болон түүний гэр бүлийн гишүүний хэн нэг нь, эсхүл түүний эрхэмлэж явдаг хэн нэгэн нь хүчирхийлэл болон хүчирхийлэхээр заналхийлсэн нөхцөл байдал дунд амьдардаг байх;
- » Зодуурын улмаас шарх сорвитой болсон байх, эсхүл биедээ гэмтэл авсан байх, ийм гэмтлээсээ болж өвдөж шаналж байх;
- » Төрийн албан хаагч, ялангуяа хууль сахиулах байгууллагын албан хаагчдад үл итгэдэг байх;
- » Хохирогчдын хууль зөрчсөн үйлдлийг нь холбогдох байгууллагад мэдээлнэ гэж айлган сүрдүүлэх замаар тодорхой ажлыг хийлгэдэг байх;
- » Хууль бусаар цагаачилж буй тухайгаа бусдад мэдэгдэхээс айдаг байх;
- » Тухайн этгээдийн паспорт, бусад баримт бичгийг хураан авсан байх, эсхүл хуурамч баримт бичигтэй байх;
- » Тухайн улсын хэл мэддэггүй байх;
- » Ажлын болон гэрийнхээ хаягийг хэлж мэдэхгүй байх;
- » Өөртэй нь ярихыг оролдоход өөрийнхөө өмнөөс бусад хүмүүсээр яриулах;

- » Хэн нэгний тушаал зааврын дагуу тодорхой ажил, үйлдлийг хийж байгаа нь тодорхой байх;
- » Хөдөлмөрийн эсвэл ажил гүйцэтгэх гэрээгүйгээр хөдөлмөр эрхэлдэг байх;
- » Алдаа гаргасан тохиолдолд бие махбодын шийтгэл хүлээдэг байх;
- » Маш бага хэмжээний цалин авдаг буюу цалин авдаггүй байх, эсхүл цалин, урамшууллын хадгаламжаа өөрөө захиран зарцуулах эрхгүй байх;
- » Хэт урт цагаар удаан хугацааны турш ажил хийдэг байх, эсхүл огт амралтын өдөргүйгээр ажилладаг байх;
- » Ажиллах орчин нөхцөл нь наад захын стандарт нөхцлийг хангахгүй байх;
- » Эрүүл мэндийн тусламж үйлчилгээ авах боломжгүй байх;
- » Нийгмийн харилцаанд оролцох боломжгүй байх буюу маш хязгаарлагдмал хүрээнд оролцдог, бусадтай өөрийн дураар харилцах боломжгүй байх;
- » Гэр бүлийнхэнтэйгээ болон ойр дотны бусад хүмүүстэй харилцах боломжгүй байх;
- » Өрийн дарамтад орсон байх;
- » Хэн нэгнээс ямар нэг байдлаас хамааралтай нөхцөлд ажиллах;
- » Замын зардлыг нь хэн нэгэн тэдний өмнөөс төлсөн байх, үүнийх нь хариуд тухайн очсон газартаа ажил, үйлчилгээ хийх замаар олсон орлогоороо тухайн төлбөрийг буцаан төлөх үүрэгтэй байх;
- » Хуурамч амлалтад хууртагдан ирсэн байх зэрэг болно.

Хүн худалдаалах гэмт хэргийн хохирогч болсон байж болзошгүй насанд хүрээгүй хүний хувьд дараах нийтлэг шинж тэмдэг илэрч болно. Үүнд:

- » Төрсөн эцэг эх, асран хамгаалагчтайгаа уулзах боломжгүй байх;
- » Айсан шинжтэй байх буюу өөрийн насанд үл тохирсон зан үйл гаргах;
- » Тухайн ажлын байрны гадна орчинд өөрийн насны найз нөхөдгүй байх;

- » Сургууль, цэцэрлэгт хамрагдаагүй байх;
- » Тоглох цаггүй байх;
- » Бусад хүүхдүүдээс хол амьдрах, эсхүл амьдарч буй орчин нь туйлын муу байх;
- » Хамт амьдарч буй хүмүүсээсээ тусдаа хооллодог байх;
- » Хоолны үлдэгдлээр л гол зогоодог байх;
- » Хүүхдийн хийх боломжгүй ажил эрхэлдэг байх;
- » Садан төрлийн бус хүмүүсийн хамт зорчин явах;
- » Улс хооронд зорчих хөдөлгөөнд садан төрлийн бус хүмүүсийн хамт оролцож байх.
- » Ажлын багаж хэрэгслийг хүүхэд хэрэглэхэд тохиромжтой байхаар өөрчилсөн, зохион бүтээсэн байх зэрэг шинж илэрч болно.

Бэлгийн мөлжлөгт өртөж буй хохирогчдод дараах шинж тэмдэг илэрч болно. Үүнд:

- » Ямар нэгэн тогтсон байршилгүйгээр өөр өөр газар ажилладаг байх;
- » Ажил, дэлгүүрээс буцаж явах, эсхүл хаа нэг газар руу явахад нь хэн нэгэн заавал дагалдаж явдаг;
- » Тухайн хохирогчдын эзэд нь тэдний биен дээр өөрийн өмч болохыг илтгэсэн шивээс болон бусад тэмдэг тавьсан байдаг;
- » Уртасгасан цагаар ажилладаг, эсхүл амралтын өдрүүдээр цөөн цагаар үйлчилгээ явуулдаг;
- » Ажлынхаа байран дээр хоног төөрүүлдэг;
- » Олон хүмүүстэй хамт амьдрах, эсхүл хаа нэг тийш явахдаа ямагт хүмүүстэй хамт явдаг. Зарим тохиолдолд олон хэлээр ярьдаг, бие биеийнхээ хэлийг ойлгодоггүй хүмүүс нэг дор явж байх тохиолдол бий;
- » Маш цөөн тооны хувцастай байх, эдгээр хувцаснууд нь ихэвчлэн биеэ үнэлэх үйлчилгээ үзүүлдэг хүмүүсийн өмсдөг хувцас байх;
- » Хэрэв гадаадын иргэн бол Монгол хэлээр зөвхөн бэлгийн ажилтай холбоотой үгнүүдийг мэддэг байх, эсхүл огт Монгол хэл мэддэггүй байх,

- » Үзүүлэх бичиг баримт байдаггүй;
- » Тухайн хүн ямар нэгэн хамгаалалтгүйгээр болон хүчирхийллийн дор бэлгийн ажилд орсныг илтгэх илт шинж тэмдэг ажиглагдах;
- » Тухайн хүн өөрөө хүсэхгүй байсан ч үйлчлүүлэгчийн хүсэлтээр ямар нэгэн хамгаалалтгүйгээр болон хүчирхийллийн дор бэлгийн ажил хийхээс татгалзаж чадахгүй байгаа шинж илт ажиглагдах;
- » Тухайн хүнийг хэн нэгэнд зарсан буюу худалдан авсан баримт олдох;
- » 2 буюу түүнээс дээш эмэгтэйчүүд явж байхад тэдний нэг нь бусдыгаа хянаж байгаа шинж тус тус илэрч болно.

Хөдөлмөр мөлжлөгт өртөж буй хохирогчид дараах шинж тэмдэг ажиглагдаж болно. Үүнд:

- » Ажил гэр нь нэг дор байх, олон хүн нэг дор амьдардаг байх, тухайн байршлаасаа гадагшаа бараг гардаггүй байх;
- » Газар тариалангийн болон үйлдвэрийн газар гэх мэт хуучирч муудсан, амьдрахад тохиромжгүй газарт амьдрах;
- » Ажлын онцлогт тохирсон хөдөлмөр хамгааллын наад захын шаардлага, стандарт хангасан хувцас, хэрэглэлгүй байх;
- » Хэрэглэж буй хүнс, ахуйн хэрэгцээний бусад зүйлс нь хүний наад захын хэрэгцээг хангахгүй байх;
- » Хөдөлмөрийн эсхүл ажил гүйцэтгэх гэрээгүй байх;
- » Маш бага цалин авдаг эсхүл огт цалин хөлсгүй ажиллаж байх;
- » Цалингийн хуримтлалаа захиран зарцуулах эрхгүй байх;
- » Ажлын цаг нь хууль тогтоомжид зааснаас урт байх, эсхүл амралтгүй ажилладаг байх;
- » Амьдран суух газраа өөрөө сонгох эрхгүй байх;
- » Ажил олгогчийн зөвшөөрөлгүйгээр ажлын байрыг орхин явж чадахгүй байх;
- » Дуртай цагтаа чөлөөтэй орж, гарах боломжгүй байх;
- » Ажлын байран дээр нь тогтмол байгаа эсэхийг хянадаг систем ажилладаг;

- » Гаргасан зөрчил болгоныг нь мөнгөөр үнэлж торгодог байх;
- » Байнга доромжлуулах, хүчирхийлүүлэх, заналхийлүүлэх, хүч хэрэглэдэг байх;
- » Анхан шатны сургалт зохион байгуулдаггүй байх, мөн мэргэшлийн үнэмлэх олгодоггүй байх;
- » Гадаадын иргэн бол Монгол хэлээр огт ярьж чаддаггүй эсхүл эрхэлж буй хөдөлмөртэй холбоотой үг мэддэг байх;
- » Эрүүл мэнд болон аюулгүй байдлын талаар анхааруулсан анхааруулга байхгүй байх;
- » Гадаадын иргэдийг ажиллуулж байгаа байгууллагын эзэд болон менежер нь тухайн иргэдийг авч ажиллуулах эрхтэй эсэхийг баталсан баримт бичиггүй байх;
- » Гадаадын иргэдийг ажиллуулж байгаа байгууллагын эзэд болон менежер нь ажилтнуудад олгосон цалингийн талаарх нотолгоо болгох баримт бичиггүй байх;
- » Эрүүл мэндийн болон аюулгүй ажиллагааны техник, тоног төхөөрөмж, багаж хэрэгсэлгүй байх, эсхүл нь эдгээр нь ажилладаггүй байх;
- » Тухайн байгууллагын үйл ажиллагаанд Хөдөлмөрийн тухай хууль тогтоомж зөрчигдөж байгаа нь илэрхий байх;
- » Хөдөлмөр эрхлэгчид цалингаасаа ажлын багаж хэрэгслийн төлбөр, хоол хүнс, орон байр (ажлын байран дээрээ байрладаг, эсхүл байгууллагаас зохион байгуулалттайгаар бөөнд нь байлгадаг газар байрладаг үед)-ны төлбөр төлөх үүрэгтэй байх зэрэг шинж илэрч болно.

Хавсралт №1. Цагдаагийн албан хаагчийн хүн худалдаалах гэмт хэргийн хохирогчийг илрүүлэх асуулга

№	Асуулт	Тийм	Үгүй	Дэлгэрэнгүй мэдээлэл тэмдэглэх
Суурь үзүүлэлт				
1	Нас:			
2	Иргэншил:			
3	Ажил эрхлэлт			
4	Өр, зээлтэй эсэх			
5	Цалин хөлстэй эсэх			
Үндсэн үзүүлэлт				
Зөвлөмж:				
<ul style="list-style-type: none"> ✓ Ярилцлага хийж буй албан хаагч нь дор тавигдсан асуултаас гадна харилцагчийн яриа, бусад нөхцөл байдал, өөрийн мэдрэмжээр асуултуудыг нарийвчлан тодруулах замаар хохирогч мөн эсэхийг тогтоохыг зорих, ✓ Хүний наймаа, бэлгийн мөлжлөгийн хохирогчид болж өнгөрсөн үйл явдлын талаар олон удаагийн давтамжтай ярих нь сэтгэл зүйн дарамтанд орох эрсдэлийг бий болгож байдгийг анхаарах, ✓ Ярилцлагын явцад хүний наймааны хохирогч, биеэ үнэлэгч, мөлжлөгт өртөгч гэх мэт үгсийг аль болох ашиглахаас татгалзах, ✓ Хохирогч төвтэй хандлагатай, хүний эрхийн мэдрэмжтэй байж, ярилцлагын асуултыг аль болох ойлгомжтой байдлаар тайлбарлаж өгөх замаар тодорхой хариулт авахыг зорих. ✓ Ярилцагчид тавигдаж буй асуултууд, түүнд хариулж буй байдалд логик байгаа эсэх, үнэн эсхүл худал ярьж байгааг мэдрэх хэрэгтэй. ✓ Ярилцлагын явцад өөр бусад хохирогч болсон эсхүл хохирогч байх магадлалтай хүмүүсийн талаарх мэдээлэл гарвал түүнийг тусгайлан тэмдэглэж, олж тогтооход анхаарах нь зүйтэй. 				
Биеэ үнэлэх, биеийг нь үнэлүүлэхтэй холбоотой нөхцөл байдлыг тодорхойлох				
6	Та хэзээнээс биеэ үнэлж эхэлсэн бэ? Таныг биеэ үнэлэхэд хэн нэгэн татан оруулсан уу? /цаг хугацаа, явц, хэн татаж оруулсан, таних эсэх/			
7	Та биеэ үнэлнэ гэдгээ мэдэж байсан уу?			
8	Та биеэ үнэлэх талаар мэдээгүй байсан бол хэрхэн биеэ үнэлэх болсон бэ?			

Бэлгийн мөлжлөгтэй холбоотой нөхцөл байдлыг тодорхойлох:				
9	Биеэ үнэлэх явцдаа хэн нэгний /хамтран ажилладаг, худалдан авагч гэх мэт/ дарамт, хүчирхийлэлд орж байсан уу?			
	Эсвэл бусад биеэ үнэлэгч ийм байдалд орж байсан талаар сонссон зүйл бий юу?			
10	Таныг биеэ үнэлдэг гэдгийг олон нийтийн сүлжээгээр эсвэл өөр бусад байдлаар бусдад тараана, мэдэгдэнэ гэж айлган сүрдүүлж байсан уу?			
11	Таны биеийг үнэлүүлдэг этгээдийн зүгээс хууль сахиулах, шүүх эрх мэдлийн байгууллагын ажилтнуудтай дотно харилцаатай талаараа ярьж байсан уу?			
12	Монгол Улсын хуулиар биеэ үнэлсэн хүн ч мөн хариуцлага хүлээдэг гэж айлган сүрдүүлж, явуулж буй хууль бус ажиллагаагаа нуух, энэ талаар мэдээллэх боломжийг хязгаарлаж байсан уу?			
13	Ажил олгогчийн зүгээс таны зургийг авах, бэлгийн харилцааны үеийн болон тийм шинжтэй үйлдлийн бичлэгийг хийдэг байсан уу?			
Хянан харгалзах болон дарамт шахалттай холбоотой нөхцлийг тодорхойлох:				
14	Амьдарч байсан орон байрнаасаа чөлөөтэй гарч орох боломжтой байсан уу?			
	Хэрэв боломжгүй байсан бол ямар нөхцөл байдал байсан бэ?			
	Хэний зөвшөөрлөөр гадагш гарах боломжтой байсан бэ?			
	Амьдарч байсан орон байрны чинь гадна болон дотор талд хяналтын камер байсан уу?			

15	Амьдарч байсан орон байрны цонх эсхүл хаалганд хаалт байсан уу?			
	Гадна орчин үл харагдах өнгөөр будсан, өөр бусад зүйлсээр битүүлсэн байсан уу?			
16	Ажил олгогч, үйлчлүүлэгчийн хий гэсэн ажлыг үл хийх нь таныг ямар нөхцөл байдалд оруулдаг байсан бэ?			
17	Ажил олгогчийн зүгээс бэлгийн хүчирхийлэл үйлдэж байсан уу?			
18	Амралтын өдөр гэж байгаа юу?			
	Байдаг бол хэзээ, хэчнээн цаг амардаг байсан бэ?			
19	Өөрийн хүссэн үедээ энэ ажлыг хийхээс татгалзах боломж байсан уу? Яагаад?			
20	Хувийн бичиг баримтыг өөртөө байлгах боломж байсан уу?			
Үйлчилгээ авах, хэрэгцээгээ хангах, цалин хөлстэй холбоотой нөхцөл байдлыг тодорхойлох:				
21	Амьдралын наад захын хэрэгцээ болох хоол ундныхаа хэрэгцээгээ хязгаарлуулж байсан тохиолдол бий юу?			
22	Эрүүл мэндийн эмчилгээ, үйлчилгээ авах эрхээ хязгаарлуулж байсан уу?			
23	Цалин өгдөг үү?			
	Өгдөг бол ямар хэмжээний цалин өгдөг вэ?			
	Цалингаа өгөхгүй байх ямар тохиолдол байсан бэ?			
24	Үйлчлүүлэгч төлбөрөө төлөхгүй байх нь танд эрсдэл бий болгож байсан уу?			
	Тийм бол ямар эрсдэл үүсэж байсан бэ?			
Тэмдэглэл:				

Хавсралт №2. Хилийн шалган нэвтрүүлэх албаны албан хаагчийн хүн худалдаалах гэмт хэргийн хохирогчийг илрүүлэх асуулга

№	Асуулт	Тийм	Үгүй	Дэлгэрэнгүй мэдээлэл тэмдэглэх
Суурь үзүүлэлт				
1	Нас:			
2	Иргэншил:			
3	Ажил эрхлэлт			
Үндсэн үзүүлэлт				
Зөвлөмж:				
<ul style="list-style-type: none"> ✓ Ярилцлага хийж буй албан хаагч нь дор тавигдсан асуултаас гадна харилцагчийн яриа, бусад нөхцөл байдал, өөрийн мэдрэмжээр асуултуудыг нарийвчлан тодруулах замаар хохирогч мөн эсэхийг тогтоохыг зорих, ✓ Хүний наймаа, бэлгийн мөлжлөгийн хохирогчид болж өнгөрсөн үйл явдлын талаар олон удаагийн давтамжтай ярих нь сэтгэл зүйн дарамтад орох эрсдэлийг бий болгож байдгийг анхаарах, ✓ Ярилцлагын явцад хүний наймааны хохирогч, биеэ үнэлэгч, мөлжлөгт өртөгч гэх мэт үгсийг аль болох ашиглахаас татгалзах, ✓ Хохирогч төвтэй хандлагатай, хүний эрхийн мэдрэмжтэй байж, ярилцлагын асуултыг аль болох ойлгомжтой байдлаар тайлбарлаж өгөх замаар тодорхой хариулт авахыг зорих. ✓ Ярилцагчид тавигдаж буй асуултууд, түүнд хариулж буй байдалд логик байгаа эсэх, үнэн эсхүл худал ярьж байгааг мэдрэх хэрэгтэй. ✓ Ярилцлагын явцад өөр бусад хохирогч болсон эсхүл хохирогч байх магадлалтай хүмүүсийн талаарх мэдээлэл гарвал түүнийг тусгайлан тэмдэглэж, олж тогтооход анхаарах нь зүйтэй. ✓ Шалган нэвтрүүлэх албаны ажилтан нь тухайн этгээдийг хүн худалдаалах гэмт хэргийн хохирогч болсон байж магадгүй гэх үндэслэл байвал нутаг дэвсгэрийн цагдаагийн байгууллага эсхүл тагнуулын байгууллагын эрх бүхий албан тушаалтанд хандаж, шуурхай арга хэмжээг авна. 				
4	Та ямар ажлаар гадаад улс руу зорчих гэж байгаа вэ?			
5	Та хаанаас /аль аймаг, хот/ ирсэн?			
6	Та өөрийн ургийн овог, эцэг /эх/-ийн нэр, өөрийн нэр, регистрийн дугаарыг хэлнэ үү?			
7	Та гадаад паспортоо хэзээ авч байсан бэ?			

8	Таны бусад бичиг баримтууд таны биед байна уу?			
	Байгаа бол үзүүлнэ үү?			
9	Та хэн нэгэн хүнтэй хамт явж байгаа юу?			
	Хэрэв тийм бол хэнтэй хамт явж байгаа вэ?			
	Тантай ямар хамааралтай хүн бэ?			
10	Та өмнө нь тухайн хүнтэй хамт гадаад улсыг зорьж байсан уу?			
	Та хаанаас /аль аймаг, хот/ ирсэн бэ?			
	Та очих гэж буй тухайн улсдаа байгаа Элчин сайдын яам, Консулын газрын талаарх мэдээллийг мэдэх үү?			
Хөдөлмөр эрхлэлттэй холбоотой мэдээллийг тодруулах				
11	Таныг хэн нэгэн гадаад гадаад улсад ямар нэгэн ажилд зуучилж байгаа юу?			
	Хэрэв тийм бол аль улсад ажиллахаар явж байгаа вэ?			
12	Тантай ажил гүйцэтгэх эсвэл хөдөлмөрийн гэрээ байгуулсан уу? Тийм бол түүнийгээ үзүүлнэ үү?			
13	Таныг ажилд зуучилсан хүн эсвэл байгууллага хөдөлмөр зуучлалын албан ёсны зөвшөөрөлтэй байсан уу?			
14	Та гадаад улс руу зорчих зардлаа өөрөө гаргаж байгаа юу?			
	Хэрэв та өөрөө зардлаа гаргаагүй бол таныг зардлыг хэн хариуцаж байгаа вэ?			
	Энэ талаар гэрээнд тусгасан зүйл бий юу?			
15	Та гадаад улс руу ямар хугацаагаар явж байгаа вэ?			
Суралцахтай холбоотой асуудлыг тодруулах				
16	Та суралцахаар явж буй сургуулийнхаа талаар хаанаас мэдээлэл авсан бэ?			
	Танд сургуулийн талаар мэдээлэл өгсөн хүн тантай хамт явж байгаа юу?			

	Танд тухайн суралцах сургууль болон сургалтыг зуучилсан байгууллага нь албан ёсны зөвшөөрөлтэй байсан уу?			
17	Та гадаадад суралцахтай холбоотой гэрээ байгуулсан уу?			
	Таныг гадаад улсад очиж суралцахтай холбоотой сургалтын төлбөрөөс бусад зардлыг хэн хариуцаж байгаа вэ?			
	Таны сургалтын төлбөрийг хэн хариуцаж байгаа вэ?		Тэмдэглэл:	

Хавсралт №3. Эрүүл мэндийн байгууллагын мэргэжилтний хүн худалдаалах гэмт хэргийн хохирогчийг илрүүлэх асуулга

№	Асуулт	Тийм	Үгүй	Дэлгэрэнгүй мэдээлэл тэмдэглэх
Суурь үзүүлэлт				
1	Нас:			
2	Хүйс:			
Үндсэн үзүүлэлт				
Зөвлөмж:				
<ul style="list-style-type: none"> ✓ Эмнэлгийн мэргэжилтэн нь дор тавигдсан асуултаас гадна харилцагчийн яриа, бусад нөхцөл байдал, өөрийн мэдрэмжээр асуулуудыг нарийвчлан тодруулах замаар хохирогч мөн эсэхийг тогтоохыг зорих, ✓ Хүний наймаа, бэлгийн мөлжлөгийн хохирогчид болж өнгөрсөн үйл явдлын талаар олон удаагийн давтамжтай ярих нь сэтгэл зүйн дарамтанд орох эрсдэлийг бий болгож байдгийг анхаарах, ✓ Ярилцлагын явцад хүний наймааны хохирогч, биеэ үнэлэгч, мөлжлөгт өртөгч гэх мэт үгсийг аль болох ашиглахаас татгалзах, ✓ Хохирогч төвтэй хандлагатай, хүний эрхийн мэдрэмжтэй байж, ярилцлагын асуулыг аль болох ойлгомжтой байдлаар тайлбарлаж өгөх замаар тодорхой хариулт авахыг зорих. ✓ Ярилцагчид тавигдаж буй асуулууд, түүнд хариулж буй байдалд логик байгаа эсэх, үнэн эсхүл худал ярьж байгааг мэдрэх хэрэгтэй. ✓ Ярилцлагын явцад өөр бусад хохирогч болсон эсхүл хохирогч байх магадлалтай хүмүүсийн талаарх мэдээлэл гарвал түүнийг тусгайлан тэмдэглэж, олж тогтооход анхаарах нь зүйтэй. ✓ Эмнэлгийн мэргэжилтэн нь тухайн этгээдийг хүн худалдаалах гэмт хэргийн хохирогч болсон байж магадгүй гэх үндэслэл байвал нутаг дэвсгэрийн цагдаагийн байгууллага эсхүл тагнуулын байгууллагын эрх бүхий албан тушаалтанд хандаж, шуурхай арга хэмжээг авна. 				
3	Таны биед ямар нэгэн зовиур байна уу?			
	Хэрэв байгаа бол таны биеийн аль хэсэгт зовиур байна вэ?			
	Энэ зовиур хэзээнээс бий болсон бэ?			
4	Таны биед үүссэн гэмтэл, шарх, сорви /сонгох/ хэзээ, юунаас болж үүссэн бэ?			
	Яагаад ийм гэмтэл, шарх, сорвитой болсон бэ?			

	Танд хэн нэгний зүгээс хүчирхийлэл, дарамт, шахалт ирж байсан уу?			
5	Өмнө нь хүчирхийлэл, дарамт, шахалтад орж байсан уу?			
	Хэрэв орж байсан бол цаг хугацааны хувьд хэзээ ийм зүйл тохиолдсон бэ?			
6	Танд цаашид ямар нэгэн тусламж, дэмжлэг хэрэгтэй байна уу?			
Тэмдэглэл:				

Хавсралт №4. Нийгмийн ажилтан болон хүүхдийн асуудал эрхэлсэн мэргэжилтний хүн худалдаалах гэмт хэргийн хохирогчийг илрүүлэх асуулга

№	Асуулт	Тийм	Үгүй	Дэлгэрэнгүй мэдээлэл тэмдэглэх
Суурь үзүүлэлт				
1	Нас:			
2	Хүйс:			
3	Суралцаж буй байдал:			
4	Амьдралын нөхцөл байдал			
Үндсэн үзүүлэлт:				
Зөвлөмж:				
<ul style="list-style-type: none"> ✓ Нийгмийн ажилтан болон хүүхдийн асуудал эрхэлсэн мэргэжилтэн нь дор тавигдсан асуултаас гадна хүүхдийн яриа, бусад нөхцөл байдал, өөрийн мэдрэмжээр асуултаудыг нарийвчлан тодруулах замаар хохирогч мөн эсэхийг тогтоохыг зорино. ✓ Хүүхэд, ялангуяа хүн худалдаалах гэмт хэрэг, бэлгийн мөлжлөгийн хохирогчид болж өнгөрсөн үйл явдлын талаар олон удаагийн давтамжтай ярих нь сэтгэл зүйн дарамтанд орох эрсдэлийг бий болгож байдаг анхаарч ажиллана. ✓ Ярилцлагын явцад хүн худалдаалах хэргийн хохирогч насанд хүрсэн болон хүрээгүй хүн мөлжлөгт өртөгч, биеэ үнэлэгч гэх мэт үгсийг аль болох ашиглахаас татгалзах хэрэгтэй. ✓ Хохирогч төвтэй хандлагатай, хүний эрхийн мэдрэмжтэй байж, ярилцлагын асуултаудыг хүүхдэд аль болох ойлгомжтой байдлаар тайлбарлан, тодорхой хариулт авахыг зорьж ажиллана. ✓ Ярилцагчийн асуултад хариулж буй байдал логик холбоотой байгаа эсэхэд анхаарлаа хандуулж, эргэлзээтэй санагдсан хариултыг 4-5 асуулт, хариулт явуулсны дараа дахин тодруулан асууж нягталж байх хэрэгтэй. ✓ 10 буюу түүнээс дээш асуултанд “Тийм” гэсэн хариултыг өгч байвал ХХГХ-ийн хохирогч болсон байх магадлалтай гэж үзнэ. ✓ Ярилцлагын явцад илэрсэн хохирогч болсон эсхүл хохирогч байх магадлалтай өөр хүмүүсийн талаарх мэдээллийг тодорхой тэмдэглэж, яаралтай цагдаа, тангуулын байгууллагад мэдээлэх нь зүйтэй. ✓ Нийгмийн ажилтан болон хүүхдийн асуудал эрхэлсэн мэргэжилтэн нь тухайн хүүхдийг бэлгийн мөлжлөг, хүн худалдаалах гэмт хэргийн хохирогч болсон байх магадлалтай гэх үндэслэл байвал нутаг дэвсгэрийн цагдаагийн байгууллага эсхүл тагнуулын байгууллагын эрх бүхий албан тушаалтанд хандаж, шуурхай арга хэмжээг авна. 				
1	Хүүхэд гэр бүлээсээ тусдаа амьдарч байна уу?			
2	Хүүхэд хүссэн үедээ эцэг эхтэйгээ уулзах боломжгүй байна уу?			

3	Хүүхэд сургуульд явахаа больсон уу?			
4	Хүүхдийн зан авирт огцом өөрчлөлт гарсан шинж ажиглагдсан уу?			
5	Хүүхэд бэлгийн мөлжлөгт өртсөн байх магадлалтай талаар мэдээлэл авсан уу?			
6	Хүүхэд өөрөө бэлгийн мөлжлөгт өртсөн талаар мэдээлэл өгсөн үү?			
7	Хүүхэд хөдөлмөр мөлжлөгт өртсөн байх магадлалтай талаар мэдээлэл авсан уу?			
8	Хүүхэд өөрөө хөдөлмөр мөлжлөгт өртсөн талаар мэдээлэл өгсөн үү?			
9	Хүүхэд хэт урт цагаар, амралтгүйгээр ажилладаг уу?			
10	Хүүхдийн яриа эмх цэгцгүй, эргэлзсэн эсвэл сэтгэл санааны дарамт, хүчирхийлэл, сэтгэцийн хувьд хэвийн биш байгаа байдал харагдаж байна уу?			
11	Хүүхдэд бие махбодын хүчирхийллийн шинж тэмдэг илэрч байна уу?			
12	Хүүхэд ажлын байран дээр хоног төөрүүлдэг, ажлын байрандаа амьдардаг			
13	Хүүхэд аймхай, цочимхой, хүлцэнгүй, бусдаас хараат шинж байна уу?			
14	Хүүхдэд хоол хүнс, амралт, нойр, эмнэлгийн тусламж дутагдсан шинж тэмдэг илэрч байна уу?			
15	Хүүхэд ихэвчлэн өөрийг нь хянадаг эсвэл нөхцөл байдлыг байнга хянаж байгаагаа илэрхийлдэг хэн нэгэнтэй хамт байдаг уу? (хаашаа явах, хэнтэй уулзах, ярилцах, асуултад юу гэж хариулах талаар байнга заадаг, хянаж шалгадаг гм)			
16	Хүүхдэд юу хэлэхийг зааж сургасан шинж ажиглагдаж байна уу?			

17	Хүүхэд хэвийн амьдрахад тохиромжгүй нөхцөлд амьдарч байна уу?			
18	Хүүхэд өмнө нь гэмт хэрэг, ялангуяа бэлгийн эрх чөлөөний эсрэг гэмт хэргийн хохирогч болж байсан уу?			
19	Тухайн хүүхэд амьдарч буй газраа чөлөөтэй орхиж чадах уу?			
20	Тухайн хүүхэдэд улирлын чанартай хувцас дутагдсан, эсвэл насандаа тохирохгүй илт бэлгийн болон хөдөлмөр мөлжлөгт өртөж буйг илтгэх хувцас, хэрэгсэлтэй байна уу?			
21	Хүүхэд хийсэн ажлынхаа хөлсийг тохиролцсон хэмжээндээ авч чадсан уу?			
22	Хүүхдийн хөдөлмөр эрхэлсэн хөлсийг хэн нэгэн шууд болон шууд бусаар авдаг байсан уу? (эцэг эх, гэр бүл, хамаатан садан, ажил олгогч гм)			
23	Хүүхдийн аюулгүй байдлыг хангах яаралтай үндэслэл байна уу?			
24	Хүүхдийн амь нас, эрүүл мэндэд ноцтой хохирол учруулж болзошгүй бусад хүчин зүйл байгаа юу?			
25	Ямар нэгэн хүчирхийллийн улмаас гэрээсээ зугатааж, оргож байсан уу?			
26	Цагдаагийн байгууллагаар эрэн сурвалжлагдаж байсан уу? (хэдэн удаа)			
27	Хүүхэд амиа хорлох, биеэ гэмтээх оролдлого хийж байсан уу?			
28	Цагдаагийн байгууллагад зөрчлийн улмаас саатуулагдаж байсан уу?			

Тэмдэглэл:

Хавсралт №5. Эрсдэл бүхий гадаадын иргэнээс авах асуулга

№	Асуулт	Тийм	Үгүй	Дэлгэрэнгүй мэдээлэл тэмдэглэх
Суурь үзүүлэлт				
1	Нас:			
2	Иргэншил:			
3	Ажил эрхлэлт			
4	Цалин хөлстэй эсэх			
5	Та Монгол хэл мэдэх үү, мэддэг бол ямар түвшинд мэддэг вэ?			
6	Монголд хэзээ, хэрхэн, хэнтэй, яаж ирсэн бэ?			
7	Танаас зөвшөөрөл авалгүйгээр визний хугацааг сунгах, ажлын байр өөрчлөх тохиолдол гарч байсан уу?			
8	Яагаад Монголд ирж ажиллах болсон бэ?			
9	Таныг энд ирүүлэхийн тулд хэн нэгэн ятгах, дарамтлах зэргээр нөлөөлсөн үү?			
10	Таны ирэх зардлыг хэн хариуцсан бэ?			
11	Та одоо Монголд ямар нөхцөлд ажиллаж амьдарч байна вэ?			
12	Та өдөрт, долоо хоногт хэдэн цаг ажилладаг вэ?			
13	Та одоо эрхэлж байгаа ажлаа хийж эхлэхдээ хөдөлмөрийн ямар нэгэн гэрээ байгуулсан уу?			
14	Танд мэдээлэл, харилцаа, холбооны хэрэгсэл ашиглах боломж байдаг уу?			
15	Ажил олгогч тантай анх тохирсноосоо өөр эсвэл илүү ажил хийхийг санал болгох/ шаардах тохиолдол гарч байсан уу?			
16	Хэрэв тийм бол ямар ажил хийхийг санал болгосон бэ?			
17	Таны иргэний бичиг баримтууд өөрт тань бий юу?			
18	Та ажил олгогчдоо эсхүл таныг ажилд зуучилсан хүнд өртэй юу?			
19	Та хийж буй хөдөлмөрийнхөө хөлсөнд хэдэн төгрөг авдаг вэ?			
20	Ажил олгогч тантай анх тохирсны дагуу цалингаа бүрэн олгодог уу?			

	Таны олсон орлогоос хувь авдаг хүн бий юу?	
18	Хэрэв тийм хүн байгаа бол хэд, хэдэн хувиар нь хуваадаг вэ?	
	Танд оногдох хувь таны амьдралд хүрэлцээтэй байдаг уу?	
19	Таныг амьдарч байгаа орон байрнаасаа гарахыг хориглох тохиолдол гарч байсан уу?	
	Хэрэв тийм бол та тухайн үед ямар арга хэмжээ авсан бэ?	
20	Нутаг руугаа буцах боломж байсан уу?	
Тэмдэглэл:		

Хавсралт №6. Хүн худалдаалах гэмт хэргийн хохирогчид шаардлагатай дэмжлэг, туслалцаа үзүүлэх, холбон зуучлах зураглал

1

Баг хорооны иргэд /хүүхэд/ -ээс хүн худалдаалах гэмт хэргийн хохирогч байж болзошгүй хүнтэй удирдамжийн дагуу ярилцлага хийх

2

Хохирогч байж болзошгүй нөхцөл байдал тогтоогдвол харьяа аймаг, дүүргийн цагдаагийн байгууллагад хандах

3

Хохирогчид шаардлагатай дэмжлэг туслалцааг хууль, стандарт журамд заасны дагуу үзүүлэх